

**ЧИНГЭС ХААНЫ НЭРЭМЖИТ “ИХ ЗАСАГ”  
ИХ СУРГУУЛЬ**



GaVaL.net

Эрүүгийн  
эрх зүйн тэнхим  
Гар бичмэлийн эрхтэй

**Халхууд овогт Баясгалангийн Баттулга**

**Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт  
хэрэгтэй тэмцэх арга замыг боловсронгуй  
болгох зарим асуудал**

**МАГИСРТИЙН ЗЭРЭГ ГОРИЛСОН ДИПЛОМЫН АЖИЛ**

Эрдэм шинжилгээний удирдагч:

Профессор.....Ц.Бүдханд

Албан ёсны шүүмжлэгч:

Магистр.....Б.Баттулга

Улаанбаатар  
2008 он



**Батлав: Эрүүгийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч**

Профессор.....Ц.Бүдханд

Удирдагч: Профессор.....Ц.Бүдханд

Шүүмжлэгч: Магистр.....Б.Баттулга

**Чингэс хааны нэрэмжит ” Их Засаг”  
Их сургуулийн магистрын зэрэг горилсон  
дипломын ажлын төлөвлөгөө**

**Сэдэв: Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэгтэй тэмцэх арга замыг  
боловсронгуй болгох зарим асуудал**

**Удиртгал**

**Нэгдүгээр бүлэг: Бусдын эд эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэгтэй тэмцэх эрх  
зүйн зохицуулалт.**

- 1.1 Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтын түүхэн уламжлал.
- 1.2 Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн ойлголт, үндсэн шинж, онцлог.
- 1.3 Гадаадын зарим улс орнуудын эрх зүйн зохицуулалт.

**Хоёрдугаар бүлэг: Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргээс урьдчилан  
сэргийлэх арга замыг боловсронгуй болгох нь**

- 2.1 Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн шалтгаан нөхцөл.
- 2.2 Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга зам.

**Дүгнэлт**

**Хавсралт**

**Ном зүй**

Төлөвлөгөө боловсруулсан магистрын зэрэг гориллогч

.....Б.Баттулга

## Удиртгал

### **Сэдвийг сонгон судлах болсон үндсэлэл:**

Монгол улсад төр улс үүсээд 800 гаруй жил болж байна. 1992 онд ардчилсан нийгмийг цогцлон байгуулж хүмүүнлэг, энэрэнгүй ёсонд тулгуурласан шинэ үндсэн хуулиа баталсан билээ. Монгол Улсын Үндсэн хуулинд хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон хувийн өмчийг хайрлан хамгаалах талаар тусгасан. Тухайлбал: <sup>1</sup>Монгол улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална гэж тунхагласан, 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэгт иргэдийг хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийг шударгаар олж авах, өмчлөх эрхийг баталгаажуулан өгсөн байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн /2002 он/ тусгай ангийн долдугаар хэсэг Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг, арван есдүгээр бүлэгт өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн бүлэгт оруулан 147 дугаар зүйлд хуульчлан өгсөн байна.

Манай орны Эрүүгийн нөхцөл байдлын онцлогоос үзэхэд бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг нийт гарч буй гэмт хэргийн 10 хүрэхгүй хувийг эзэлж, бага гарч байгаа мэт боловч энэ гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээдүүдийн 90 гаруй хувь нь таваас дээш 15 жилийн хугацаагаар хорих ялаар шийтгүүлж байгаа нь улсын хэмжээнд анхаарал татсан хэргийн нэг болж байна. Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг нь хүний оршин суугаа газар болон зан заншил, гэр бүлийн байдал, боловсрол, ажил мэргэжил, хүйс, нийгмийн хөгжлийн байдалтай уялдан үйлдэгддэг бөгөөд үйлдлийн арга хэлбэр, цаг хугацаа, нийгмийн хор аюулын шинж байдал нь өөр өөр байдаг. Зах зээлийн орой бусгаа энэ жилүүдэд амар хялбар амьдрахыг хүссэн этгээдүүд болон бусад шалтгаанаар бусдын бие махбодид халдан довтолж эд хөрөнгө болон эрүүл мэндэд нь хохирол учруулан зэрлэг авирлаж байдаг. Субъектив шинж чанараараа бусад гэмт хэргээс ялгаатай юм.

Иймд бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн гаралтын шалтгаан нөхцлийг тогтоохын зэрэгцээ онол практик болон эрх зүйн талаас нь үнэлэлт дүгнэлт

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль 1992 он Төрийн мэдээлэл сэтгүүл №1

хийж цаашид энэ гэмт хэрэгтэй тэмцэх арга замыг боловсронгуй болгох, урьдчилан сэргийлэх асуудалд анхаарал хандуулахын тулд уг сэдвийг судлахаар сонгон авсан болно.

### **Эрдэм шинжилгээний ажлын зорилго:**

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийг үйлдэгсэдийн 80 гаруй хувь нь 18-35 насны буюу Монгол улсын ирээдүй болсон залуучууд үйлдэж байна. Монгол Улсын хэмжээнд авч үзвэл 2002 оны шинэ Эрүүгийн хууль дагаж мөрдөснөөс хойш бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэгт оногдуулж буй ял шийтгэл нь хүнд, онц хүнд гэмт хэрэг буюу оногдуулах ялын хамгийн доод хэмжээ нь 5 жилээс дээш 15 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулж байна. Үүнээс өөр ял оногдуулах боломжгүй болж энэ гэмт хэргийг үйлдэгсэдэд доод тал нь таван жил нэг хоног болон түүнээс дээш 15 жил хүртэл хугацаагаар ял оногдуулж гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг жирийн болон чанга дэглэмтэй хорих ангид ял эдлүүлж байна. Энэ гэмт хэрэгт хорихоос өөр төрлийн ямарч ял оногдуулах боломжгүйгээр хуульчлагдсан нь ялын бодлого гэж үзэх үндэслэлтэй юм. Дээрмийн гэмт хэрэг үйлдэгсэдийн хувийн байдал маш ихээр нөлөөлж байгаа ба дээрэмдэн авч буй зүйл нь анхаарлыг маш их татаж байна. Дээрмийн гэмт хэргийн субъект болон энэ гэмт хэрэгт өртөгдөж байгаа халдлагын зүйлийн байдлыг харгалзан үзэж ялыг ялгамжтай оногдуулах эрх зүйн механизмыг өөрчлөх шаардлага практикаас урган гарч байгаа болно.

Мөн энэ гэмт хэргийн улмаас иргэдийн эд хөрөнгө төдийгүй амь нас, эрүүл мэндэд хохирол учруулдаг давхар объектой онцлог гэмт хэрэг юм. Иймд бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийг шалтгаан нөхцлийг тогтоохын зэрэгцээ практик болон эрх зүйн үндэслэлтэй судалгааг, дүгнэлтийг хийх, цаашид уг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга замыг боловсронгуй болгоход анхааралаа хандуулж, энэхүү гэмт хэргийн гаралтын тоо багасгахад эрдэм шинжилгээгний ажлын гол зорилго болно.

### **Сэдвийн судлагдсан байдал:**

Манай улсын хууль зүйн шинжлэх ухааны анхны эрдэмтэн болох Р.Гүнсэн 1965 онд “Улс хоршооллын хөрөнгийг ашиглан шамшигдуулах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага” сэдвээр дэд доктор, 1974 онд “БНМАУ-д Социалист

хөрөнгө хамгаалах эрүүгийн эрх зүйн болон криминологийн асуудал” сэдвээр Хууль зүйн шинжлэх ухааны докторын зэргийг Москва хотноо хамгаалсан, 1972 онд “Хөрөнгөтний биш хөгжлийн замаар социализмд шилжихэд улс хоршооллын өмчийг хамгаалах асуудал” гэсэн бүтээл гаргасныг эс тооцвол бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэгтэй тэмцэх талаар онол, практикийн дагнасан бүтээл одоохондоо гаргаагүй ба зарим эрдэмтэн судлаачид энэ талаар өөрсдийн бүтээлүүдэд зохих хэмжээгээр тусгасан байна. Тухайлбал: Хууль зүйн шинжлэх ухааны профессор Ж.Авхиа, Г.Совд, доктор, дэд профессор С.Жанцан, академич С.Нарангэрэл зэрэг эрдэмтэн судлаачид өөрсдийн бүтээлдээ дээрмийн гэмт хэргийн талаар зохих хэмжээнд судалгаа шинжилгээ хийж онолын болон практикийн асуудлыг дэвшүүлсэн байна.

#### **Эрдэм шинжилгээний ажилд хэрэглэсэн арга зүй:**

Сэдэвт заагдсан бүтээлийг боловсруулахын тулд сэдэвтэй холбогдох бүхий л хууль тогтоомж, судлаачдын бүтээлд задлан шинжилгээ хийж, тодорхой судалгаан дээр харьцуулан судалсан болно. Нийгмийн шинжлэх ухаанд нийтлэг хэрэглэгддэг ерөнхий болон тусгай аргуудаас хэрэглэсэн.Тухайлбал: танин мэдэхүй, диалактик аргад суурьлан бичсэн бөгөөд нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх, индукц, дидукц, харьцуулах, түүхчлэх, статистик, анектын болон ярилцагын аргуудыг ашигласан болно.

#### **Эрдэм шинжилгээний ажлын зорилт:**

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн үйлдэлийн арга, хэрэгсэл, гэмт хэрэг үйлдэх болсон шалтгаан нөхцөл, хэрэгтэний хувийн байдал, хохирогчийн гэм буруу, эрх зүйн зохицуулалт, түүхэн уламжлал, шүүхийн практикт хэрхэн шийдвэрлэж байгаа байдлыг судлаж илрүүлэхийн зэрэгцээ энэхүү гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, тэмцэх арга замыг нарийн боловсронгуй болгоход анхаарах асуудлуудыг нээн илрүүлж, цаашид онол практикт хэрэглэн уг гэмт хэргийн гаралтыг бууруулахад бага ч гэсэн хувь нэмэр оруулахад уг эрдэм шинжилгээний ажлын зорилт оршино.

#### **Эрдэм шинжилгээний ажлын шинэлэг тал, ач холбогдол:**

Уг судлагдаж буй сэдвийн талаар онол, шүүхийн практикт хэрхэн шийдвэрлэж буй талаас харьцуулан дүгнэлт хийж, практикт тулгамдаж байгаа асуудлуудад дүн шинжилгээ хийж уг гэмт хэргийн шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга замыг боловсронгуй болгох зарим саналыг дэвшүүлэн гаргах ач холбогдолтой гэж үзэж байна.

**Эрдэм шинжилгээ судалгааны ажлын бүтэц:**

Магистрийн зэрэг горилон бичсэн энэхүү дипломын ажил нь 2 бүлэг, 5 зүйлтэй болно.

## Нэгдүгээр бүлэг

### Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэгтэй тэмцэж буй арга зам, эрх зүйн зохицуулалт

#### 1.1 Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтын түүхэн уламжлал.

Монгол улс Үндсэн хуулиндаа монголын ард түмэн бид төрт ёс, түүх соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж эх орондоо хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно... гэж заасан билээ.

Аливаа гэмт хэрэгтэй тэмцэх төрийн үйл ажиллагааны онцлог нь тухайн орны хөгжлийн түвшин, зан заншил уламжалт онцлогт тохирсон төрийн бие даасан бодлогын хүрээнд илэрдэг. 2200 гаруй жилийн түүхтэй Монгол улсын төр хууль цаазын түүхийн судлалд Монголын дундад үеийн эхийг хамрах суут богд Чингисийн хаант улсын төр, хууль цаазад холбогдох сурвалж бичгүүд гол байр суурийг эзэлдэг. Манай ард түмний хууль цаазын уламжлал нь МЭӨ 3-р зууны үеээс үндэслэсэн бөгөөд анхны төрт улс Хүннү гүрэн нь хууль цаазын арвин их уламжлалтай билээ.

Хүннү гүрний хууль нь хориглох заншилд тулгуурласан хууль байсан бөгөөд тус хуульд ангийн ялгааг ихээхэн гаргажээ. Хүннү нарын дараа Монгол нутагт Тоба, Сяньби, Нирун, Түрэг, Уйгар зэрэг төрт улсууд нь өөрсдийн онцлог шинжийг тусгасан хуулийг баримтлан дагаж мөрдөж байв. Тухайлбал: Түргийн хуулиар бослого тэмцэл гаргагсад, төрд урван тэрслэгчид чөдөртэй морь хулгайлагсад, бусдын гэргийтэй нөгцөгсдөд алах ял оноож байсан бөгөөд чөдөртэй мориноос өөр зүйл хулгайлагсдад түүний өртгийг арав нугалж төлүүлнэ... хэмээн заасан байна.



Монгол нутагт уйгарын төрт ёс наймаас ёсдүгээр зууны үед ноёрхож хууль цаазны уламжлалыг ихээхэн хөгжүүлсэн бөгөөд дээрх улсуудын хууль цаазыг авч үзвэл ихэнх нь хулгайн гэмт хэргийг заасан заалт байна.

Монголын хууль цаазын томоохон эх сурвалж нь Монголын нууц товчоо бөгөөд түүнд эрүүгийн цаазад холбогдолтой зүйл нь өшөө хонзон авах, хулгай дээрэм хийх, хүн алах зэрэгт ор босгох зарга шүүх, дөнгө зүүхайл хэсүүлэх<sup>2</sup> зэрэг ял оноодог байв. 13-р зууны үед монгол оронд үйлчилж байсан хууль цаазын аугаа их бичиг нь Чингис хааны “Их засаг” хууль юм. Тус хуулийг Чингис хаан их ор суух үед хуралдуулсан хуралдаанаар батлан тунхаглажээ.

Их засаг хуульд заасан эрүүгийн хуулийн заалт нь хүн алсан, хулгай,, дээрэм хийсэн садар самууныг үйлдсэн бол цаазаар авна<sup>3</sup> гэх зэргээр заасан байна. Мөн хулгайлах дээрэмдэх булаах эвдэн сүйтгэх замаар бусдын эд хөрөнгөнд халдах зэрэг гэмт хэргүүдийг багтааж байсан бөгөөд тухайлбал тус хуулийн 30-р зүйлд “...ямар нэг хүн нутаг дэвсгэр дээр булаан дээрэмдэх буюу булааж байхыг олж мэдсэн байвал түүнийг огт хайр найргүй алж орхи ...”<sup>4</sup> хэмээн заажээ. Мөн тус хуульд хохирлын хэмжээг харгалзан үздэг байсан байна. МЭ-ний 13-14-р зууны үед Чингэсийн их засаг хуулийн дараа залган үйлчилж байсан Монгол хууль цаазны дорвитой дурсгалт бичиг бол Их Юань гүрний нэвтэрхий хууль юм. Тус хууль нь зарлиг бичгийн хууль 94 зүйл, дүрэм зүйл 115, таслах дүрэм 717 зүйлээс бүрдэнэ. Тус хуулийн их муу гэсэн заалтуудад өвгөдийн хүүрийг ухах , эд юм хулгайлах ,хулгай худал зэргийг оруулдаг байсан байна. МЭ-ний 14-17-р зууны үед заншлын эрх зүйн шинжтэй боловч бичмэл хууль зүйн эх сурвалж байсан бөгөөд үүний нэг нь “Алтан хааны цааз” юм. МЭ-ний 14-р зууны эл цааз бичиг бол бараг бүхэл бүтнээрээ манай үед уламжлагдан ирсэн Монголын хууль цаазны бичгээс хамгийн эртнийх болно. Түмэдийн Алтан хааны цааз нь хэв хуулийн уламжлалд тулгуурласан бөгөөд өмчийн эсрэг гэмт хэргийн талаарх 32 заалт байх боловч ихэнх нь хулгайн цааз юм. Уг хуульд “Хулгайчийг албал цаазгүй, хулгайч нь хүнд сум харвабаас тусавч есөн есөөр иоргож, хүн тэмээний нэгээр ор босго” гэж заажээ. Үүнээс үзвэл хулгайн хэрэг хийсэн боловч 10 нас

<sup>2</sup> МУИС. Эзэн богд Чингис хааны Их Засаг хууль. 1995

<sup>3</sup> Н.Ням-Осор Их засаг хуулийн тайлбар 2001

<sup>4</sup> Э.Авирмэд, Д.Дашцэдэн, Г.Совд Монгол Эрүүгийн эрх зүй 1999

хүрээгүй бол ял хэлэлцэхгүйгээр зааж өгсөн нь гэмт хэрэг үйлдсэн субъектийн талаарх асуудлыг хуульчилж өгчээ.

МЭ-ний 17-р зууны үед Монголын бутрал болсны уршгаар зүүн баруун Монголын феодал эзэд өөр хоорондоо тэмцэлдэж улс орон гүнзгий хямралд орж, үндэсний төр улс бутрах байдалд орсон байв. 1640 оны 8-р сарын эхээр 120 зүйлтэй Монгол Ойрадын хууль батлагдсан ба хуулийн эрүүгийн заалтуудаас үзвэл хүний амьжиргааны хэрэгслийн хулгайлах, бусдын эд юмыг эзнийх нь зөвшөөрөлгүй худалдах зэргийг өмчийн эсрэг гэмт хэрэгт оруулан тооцсон бөгөөд энэ хуульд дээрмийн талаар тодорхой заалт үгүй байна. Дээрх өмчийн эсрэг гэмт хэрэгт ял шийтгэлийг оногдуулахдаа мөн л амьжиргааны болон ахуйн хэрэглээний талаас нь ангилж ялыг ялгамжтай оногдуулдаг байжээ.

Монголын хууль цаазны хамгийн шилдэг нь Халх журам мөн. Халх журмыг 1709-1796 оны хооронд халхын хаад ноёд өөр өөр газар бүгд 14 удаа хуралдаж тогтоосон. “Халх журам” хуулийн 2-р бүлэгт хулгайн цаазыг хуульчилсан ба тэр дотроо дээрмийг хуульчилжээ. Жишээлбэл: “Дээрэмчнийг үзээд эс зарлаваас нэг өст, зар таслаад дээрэмчин мал булаах ба хүн албал зар таслагч хүн гурван өст, хэн нэгэн хүн хулгай дээрэмд цохилт сайн хийвээс ноён нь шан хайрла”, “Гадны хүнээс хүн босч ирж адуу хөөн иржээ. Хуврагын шавь нар хийд сахигчид зарласаар байтал эс очвол баань /ял/ хийд сахигчдаас 2 хязаалан морь авах”, “Аливаа илт хулгай /дээрэм/ хийсэн хүнийг дээдийн хуучин цаазын ёсоор алаад гэр мал ба эмс, хүүхэд сэлтийг цөм малын эзэнд өг”, “Илт хулгай хийж баригдсан хүнийг хэдэн хулгайч байсан бүгдийг нь 80 ташуурдаж 2 гарыг хавсарч төмрөөр бугуйвчлан хадаад 1 жил байх ахул малын эзэн ноёнд тушааж тавь, хоёр дахин хулгай хийсэн хүнийг хоёр жил болох ахул мөнхүү тэр ёсоор хадаж хадгалаад мөн ёсоор тавь, гурван үе хулгай хийвээс насан турш хадаж буу тавь<sup>5</sup>” гэжээ.

Дээрх заалтаас үзвэл 2 дахь, 3 дахь удаагийн үйлдлийг хүндрүүлж үзэхээр заасан гэж хэлж болох болой. “Хүнийг шархдуулсан хулгайчийг худгаас /шоронгоос/ гармагц хүн шархдуулсан мэсний эзний гарыг хугалъя, гар эдгэсний хойно түлээ түүлгэе, мэсний эзэн эс танигдах ахул хулгайчийг энэ ёсоор засаглая” гэжээ. Дээрх заалтаас үзвэл хүнийг шархдуулсан хулгайч гэдэг нь дээрэмчин бөгөөд өнөөгийн шинэ эрүүгийн хуулийнд заасантай адил биед нь гэмтэл учруулж эд зүйлийг нь авсан

<sup>5</sup> Жалан-Аажав “Халх журам” 1995 он 273-р зүйл

байж болох талтай. Монгол улсын түүхэнд Богд хаант Монгол улсын үед боловсруулсан “Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг” гэдэг хууль ихээхэн сонирхол татдаг түүхэн дурсгалт бичиг мөн. 1914 онд засгийн газарт зөвлөх эрх бүхий улсын дээд доод хурлыг байгуулсан нь үнэн хэрэгтэй хууль тогтоох байгууллагыг бүрдүүлсэн болох уг хууль зүйлийн бичигт тухайн үеийн Монголын нийгмийн дүр төрхийг тусгасан зан заншил, эрдэм, боловсрол, өртөө улаа, төр шашин, цэрэг цагдаа зэрэг олон төрлийн харилцаа зэргийг төрөлжүүлэн тусгажээ. Уг цаазын 5-р бүлэгт Илтэд булаах нь гэсэн зүйлийн дор:

**Нэгэн зүйл:** Аливаа хүн олныг хурааж цэргийн зэвсгийг барьж гэгээн өдөр зан дор тосон булааж эд хөндлөн тодорхой үнэн болох ба жич харанхуй шөнө гэрэл илт барьж нүүр түрхэн гэрт орж эд юмыг нэгжих, уулгалах, үнэхээр хүнийг алах ба гал тавих зэргийн олон хүнд учир бүхийг нь тэргүүн дэдийг үл бодон буудан алах.

Олон хошоолж уулгалан булаахыг нь ялган салгаж ял оноох нь гэсэн зүйлийн дор:

**Нэгэн зүйл:** Олон газар аливаа хүн уулгалан булаахад огт хүнийг хор хийсэн үгүй эд олсон нь хулгайн тоо 3 түүнээс доош болвоос тэргүүлснийг улсын хязгаарт цөл, хулгайн тоо 4-9 хүн дор хүрвээс цөмийг цөл, хүн алваас буудан ал.

**Нэгэн зүйл:** Монгол газар уулгалан булаах хэргийн дотор хэрвээ Монгол гадаадын хүн лугаа нэгэн хоршоолж уулгалан булаах нь буй бөгөөс халдсан ялыг үзэж гадаад улсын түшмэлийн хамт нийлж хянан байцаагаад өөр өөрийн хууль бичгийн ёсоор шийтгүүлэгтүн.

Дээрх заалтуудаас харвал бүлэглэн дээрмийн гэмт хэргийг бүлэглэн үйлдэх хэлбэрийг тогтоосон ба үүнтэй холбогдуулан ялыг ялгамжтай оногдуулж байсан байна. Мөн Монгол хүн гадаад хүнтэй хамтран дээрэм хийвэл тус тусын хуулиар шийтгэдэг байжээ. Дээрмийн хэрэг хийх явцдаа хүн алвал ял нь мөн алах ял байжээ. Энэ хууль нь урьд урьдын хуулиудаас илүү боловсронгуй хууль байв.

Энэхүү хууль зүйлийн бичиг нь 1921 оны ардын хувьсгал ялах хүртэлх хугацаанд нийгмийн бүх л харилцаа болох эрүү, иргэн, гэр бүл, захиргааны гэх мэт харилцаануудыг зохицуулж байсан байна.

1921 онд Ардын хувьсгал ялснаар хуучин төрийн байгууламжийг устгаж, хууль цаазыг нь шинэчлэх шаардлага нийгмийн хөгжлийн зүй тогтлын дагуу үүсэж бий болжээ. Хууль цаазыг өөрчлөн шинэчлэх үеийн гол зорилго нь Манжийн үед

Монголын ард түмэнд хэрэглэж байсан Фёодалын эрүү шүүлтийг хүчингүй болгон шинэ төртэйгөө зохицсон хууль цаазыг боловсруулан гаргах, улмаар төрийн байгуулал, шүүхийн системийг боловсруулах явдал байлаа. Тухайн үеийн Эрүүгийн хууль тогтоомжийн нэг эх сурвалж нь Ардын засгийн газраас гаргасан хууль эрхийн акт бөгөөд 1921 оны 7-р сарын 16-ны 4-р хурлын тогтоолд “Гэмт хэрэгт холбогдогчийн бурууг нотлох баримтанд тулгуурлан тогтоох ба эрүү шүүлт хэрэглэх, бие махбодийг зовоох зэргийг хориглосон байна. 1921 оны 8-р сарын 3-ны өдрийн 5-р тогтоолд зааснаар албадан хөдөлмөр хийлгэх түүнчлэн 1924 оны 6-р сарын 29-ны өдрийн 18-р тогтоолоор эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүйчүүд, тахир дутуу бологсод, жирэмсэн эмэгтэйчүүдэд оногдуулсан хорих ялыг хэтрүүлэн эцэг эх ойр төрлийн хүмүүст шилжүүлж, хорих ялын өдрийн тоогоор албадан хөдөлмөр хийлгэхээр тогтоожээ.” Энэ мэтчилэн Ардын засгийн газраас удаа дараалан тогтоол гаргаж хууль цаазны шинэчлэлтийг явуулж байсан нь нийгмийн хөгжил дэвшилд ихээхэн түлхэц болсон юм.

Монгол улсын анхны эрүүгийн хууль цаазны шинэчлэлтийг явуулж байсан нь нийгмийн хөгжил дэвшилд ихээхэн түлхэц болсон юм.

Монгол улсын анхны эрүүгийн хууль болох **Шүүх цаазын бичиг**-ийн ерөнхий анги, тусгай ангийг 1926 оны 1-р сарын 11, 15-нд тус тус батлан улс орон даяар дагаж мөрдөхийг батлан хуульчилжээ.

Тус хуулийн 212-р зүйлд зааснаар “Буу зэвсэг хэрэглэж бусдын эд юмыг хүчирхэн дээрэмдсэнийг гурваас долоон жил гяндан хорихоос гадна хэрэв зэвсэг хэрэглэн олон хүний нэвтрэх зам сүвийг тосож эд юмыг дээрэмдэх эсвэл гурваас дээш тооны хүмүүс бүлэглэн зэвсэг хэрэглэн дээрэм хийх аваас<sup>6</sup> долоогоос арван жил хүртлэх хугацаагаар гянданд хорино., хэрэв хүнийг алвал цаазаар авбаас зохин ...” гэжээ.

Энэхүү заалт нь Богд хаант улсын /Зарлигаар тогтоосон хууль зүйлийн бичиг/-т заасан дээрмийн гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй адил бөгөөд уг хуульд дээрмийн гэмт хэргийн хүндрүүлэх болон онц хүндрүүлэх бүрэлдэхүүнийг хуульчилж хариуцлагыг түүнтэй уялдуулан тогтоож өгсөн нь ихээхэн дэвшилттэй юм.

<sup>6</sup> Д.Адъяабазар.Монгол Улсын 1921 оноос хойшхи эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. 1998 он 32 дахь тал

1926 онд батлагдсан Шүүх Цаазын бичгийн хэм хэмжээг боловсронгуй болгох түүнийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх, хуулийн заалтыг сайжруулах зорилгоор 1929 онд “Шүүх цаазын бичгийг шинэчлэн найруулжээ. Тус хуулийн **214-р зүйлд зааснаар ...** Буу зэвсэг хэрэглэж бусдын эд хөрөнгийг хүчирхэн дээрэмдэгсдийг гурваас долоон жил хүртэл хугацаагаар хорихоос гадна олон хүний нэвтрэх зам сүвийг тосож эд юмийг дээрэмдэх эсвэл гурваас дээш тооны хүмүүс бүлэглэн зэвсэг хэрэглэн дээрэм хийх аваас долоогоос арван жил хүртлэх хугацаагаар хоримой, хэрэв хүндэтгэх зүйл байваас буудан албал зохино. 1926 оны Шүүх цаазын бичигт хүн алвал цаазаар авна гэсэн бол 1929 оны Шүүх цаазын бичигт хүндэтгэх зүйл байваас буудан албал зохино гэжээ. Тус хуулийн ерөнхий ангийн 31-р зүйлд заасан тайлбарыг авч үзвэл хүндэтгэх зүйл гэдэг нь туйлын харгис хатуу арга хэрэглэсэн, хувийн ашгийг хичээсэн, эртнээс санаатайгаар бусдад ямар гэм хорлол болохыг мэдсээр байж үйлдэх гэх зэрэг нөхцөлүүдийг ойлгоно гэж тайлбарлажээ. Мөн хүний амь хохирсон бол хүндэтгэх зүйл болно.

Цаг үеийн шаардлага, нийгмийн хөгжлийн зүй тогтолын дагуу 1929 оны Шүүх цаазын бичгийг өөрчлөн шинэчлэх шаардлага урган гаргч 1934 оны 5-р сарын 4-ны 13 хурал Улсын бага хурлын Тэргүүлэгчдийн мөн оны 5-р сарын 24-ний 17-р хурлаар 1934 оны “Шүүх цаазын бичиг”-ийг баталжээ. Үүнтэй уялдан хөгжин улсын ба хоршооллын өмч хөрөнгийг улам сайжруулж, ашиглан шамшигдуулагчдад хүлээлгэх хариуцлагын хэлбэр халдагчийн байдлыг харгалзан тогтоох явдал зайлшгүй шаардлагатай болсон бөгөөд энэ уг Шүүх цаазын бичигт тусгалаа олжээ.

Тус хуулийн 7-р бүлгийн 141-р зүйлд зааснаар "... Бусдын эд хөрөнгийг уул эзэн хүний нүдний өмнө илтээр хулгайлж дээрэмдэн авсан бол нэгээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэвэл зохино. Мөнхүү илтээр хулгайлж дээрэмдэх явдлыг хэд хэдэн хүмүүсээс бүлэглэн үйлдсэн уул хохирсон хүнийг хүнд гэмтээн тахир дутуу болгох ба үхүүлсэн бол гурваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэвэл зохино.

Мөнхүү явдлуудыг зэвсэг барьж дайран довтолж уулгалан булаасан бол таван жилээс доошгүй хугацаагаар хорих ял шийтгэвэл зохих, хэрэв тухайд онц хүндрүүлэх учир шалтгаан байвал буудан алах ял шийтгэвэл зохино.

Дээрхи заалтуудаас үзвэл дээрэмдэх гэмт хэргийг үндсэн болон хүндрүүлэх бүрэлдэхүүн, онц хүндрүүлэх бүрэлдэхүүнийг хуульчилсан бөгөөд энэ гэмт хэргийг

давтан үйлдсэн хүнийг хүнд гэмтээсэн буюу тахир дутуу болгосон, үхүүлсэн бол онц хүндрүүлж үзэхээр заасан. Онц хүндрүүлэх учир шалтгаанд буудан алах ял шийтгэнэ хэмээсэн боловч онц хүндрүүлэх учир шалтгаанд юуг хамаарахыг хуульд тусгайлан заагаагүй байна. Мөн 1934 оны хуульд дээрэмдэх, хулгайлах, булууу гэмт хэргийг хамтад нь нэг зүйл болгон хуульчилсан бөгөөд энэ нь ихээхэн зохимжгүй юм. Учир нь гэмт хэрэг нь эд хөрөнгийн эсрэг гэмт хэрэгт хамаарах боловч учруулж болох хор уршиг, үйлдлийн арга хэлбэр, нийгмийн хор аюулаараа харьцангуй өөр өөр гэмт хэргүүд юм.

1940 онд БНМАУ-ын Үндсэн хууль батлагдан гарч уг хуулийн 5,7,8- р зүйлүүдэд социалист өмчийн харилцааг бататган бэхжүүлэх талаар тунхаглаж , улс хоршоолол олон нийтийн өмч хөрөнгийг хамгаалан бэхжүүлэх явдлыг БНМАУ-ын иргэн бүрийн ариун үүрэг болгон тогтоосон байна. 1942 оны 1-р сарын 14-ны өдөр Улсын 25-р бага хурлаар эд хөрөнгийг ашиглан шамшигдуулах гэмт хэрэг үйлдэгчдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын талаар хэд хэдэн зүйлийг шинээр оруулжээ.

Тус хуулийн 176-р зүйлд зааснаар нэг хүнээс бусдын эд хөрөнгийг эзнийг нь байсаар атал дээрэмдэх гэмт хэргийг хүчин хэрэглэхгүйгээр анх үйлдсэн байвал таван жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ. Эдгээр явдлыг давтан гарсан буюу удаа дараа үйлдсэн эсхүл хэсэг бүлэг хүмүүс бүлэглэн үйлдсэн, хүчин хэрэглэсэн байвал таван жилээс доошгүй хугацаагаар хорьж шийтгэнэ. Эдгээр явдлыг үйдпэхдээ хүчийг хэрэглэж хүнд шарх учруулсан, эрэмдэг зэрэмдэг болгосон амийг сүйтгэсэн байвал хуулийн дээд хэмжээ буудан алах ял шийтгэж хөрөнгийг хурааж харин хөнгөтгөх шалтгаан байвал арван жил хорьж хөрөнгийг хураана.

Дээрх заалтаас үзвэл дээрмийн гэмт хэрэг үйлдэх аргыг нь хүч хэрэглэж, хүч хэрэглэхгүйгээр дээрэм хийх гэж ялгавартайгаар тогтоон ялыг ялгамжтай оногдуулдаг байсан бөгөөд уг гэмт хэргийн санкцад хөрөнгө хураах ялыг нэмсэн байна. Хуулийн 45-р зүйлд ямар нэгэн ялыг оногдуулахдаа хүндэтгэн үзэх шалтгаануудад бүлэглэн нийлж үйлдэх, дээрэм хийх түүнчлэн дахин гэмт хэрэг үйлдэх зэргийг ойлгохоор тогтоожээ.

Ийнхүү тогтоосноор бүлэглэж дээрмийн гэмт хэрэг үйлдвэл хүндрүүлэн үзэх шалтгаанд орно. Мөн хуулийн 76- зүйлд зааснаар "...Нэгэнт дээрэмдсэн буюу бэлтгэж байгаа явдлыг мэдсээр атал энэ тухай мэдэгдээгүй байвал гурван жил хүртэл хугацаагаар хорино" гэж заажээ. 1961 оны 1-р сарын 31-нд БНМАУ-ын Ардын их

хурлын 2 дугаар чуулганаар шинэ Эрүүгийн хуулийг баталсан бөгөөд уг хуулинд өмчийн эсрэг гэмт хэргийг социализмын бүтээн байгуулалтын үетэй холбон социалист өмчийн эсрэг гэмт хэрэг гэж тусгай бүлэг болгон өөрчилжээ. Энэ хуулиар өмчийн эсрэг гэмт хэрэг болох дээрмийн гэмт хэргийг 10-р бүлэг болгох нийгмийн аюулгүй байдал, нийгмийн хэв журам, ард иргэдийн эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт хуульчилжээ.

Энэ хуулийн 168-р зүйлд зааснаар...

А/ Улс олон нийтийн хөрөнгө ба иргэдийн амьны хөрөнгийг авах зорилгоор хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж дайран довтолвол хоёроос арван жил хүртэл хугацаагаар хорьж хөрөнгийн зармыг буюу бүгдийг хураана.

Б/ Энэ гэмт хэргийг давтан, бүлэглэж, эсхүл зэвсэг бусад зүйлийг зэвсгийн чанартайгаар хэрэглэж, ноцтой хор хохирол учруулсан бол хоёроос таван жил хүртэл хугацаагаар нутаг заан суулгах буюу суулгахгүйгээр хөрөнгийн зарим буюу бүгдийг хураана.

В/ Дээрмийн гэмт хэргийг удаа дараа үйлдсэн буюу улс олон нийтийн хөрөнгийг ашиглан шамшигдуулсан /63-р зүйлийн б, в/, иргэдийн хөрөнгийг хулгайлсан /109-р зүйлийн б,в/ хэрэгт урьд шийтгүүлсэн этгээд үйлдсэн эсвэл хүний амь хохирсон буюу зэвсэг бүхий бүлэг этгээд үйлсэн бол хоёроос таван жил хүртэл хугацаагаар нутаг зааж суулгах буюу суулгахгүйгээр арваас таван жил хүртэл хугацаагаар хорьж бүх хөрөнгийг хураан цаазаар авна.

Дээрх заалтаас үзвэл дээрмийн гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийг хөнгөн тогтоосон бөгөөд үүнийг арилгах үүднээс 1963 оны 1-р сарын 5-нд Ардын их хурлын тэргүүлэгчид /улс олон нийтийн хөрөнгийг ашиглан шамшигдуулах, хулгай дээрэм хийх явдалтай тэмцэх тэмцлийг хүчтэй болгох зорилгоор 1961 оны Эрүүгийн хуульд зарим өөрчлөлтүүдийг оруулан ял шийтгэлийг чангатгасан тухайлбал Эрүүгийн хуулийн 63-р зүйл /улс хоршоололын өмч хөрөнгийг ашиглан шамшигдуулах/, 64-р зүйл / улс хоршоололын өмч хөрөнгийг бага хэмжээтэй ашиглан шамшигдуулах/, 168-р зүйл /дээрэм /, 114-р зүйл/ залилан мэхлэх буюу шунахай зорилгоор далайлган сүрдүүлэх/ гэх мэт.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг 1974 оны 6-р сарын 15-ны Улсын Дээд Шүүхийн 5, 11-р тогтоолоор дараах байдлаар тогтоожээ. Үүнд

-Бага хэмжээний хохирол гэдэгт 400 хүртэл төгрөг

-Бага бус хэмжээний хохирол гэдэгт 400-10000 төгрөг

-Их хэмжээний хохирол гэдэгт 25000 хүртлэх төгрөг

-Онц их хэмжээний хохирол гэдэгт 25000-аас дээш төгрөгийг заажээ.

1990 оноос хойш Монгол Улсад Ардчилалын уур амьсгал орж зах зээлийн харилцаанд шилжин орсноор өмчийн шинэ харилцаа бий болж улсын бага хурлаас 1990 оны 12-р сарын 28-ний өдөр /БНМАУ-ын иргэний хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсан. Тус хуулиар өмч нь нийтийн, хувийн холимог хэлбэртэй болж төр нь өмчийн олон хэлбэрийг хүлээн зөвшөөрч өмчлөгчийн эрхийн хуулиар хамгаалах зорилгоор Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсан бөгөөд 1986 оны Эрүүгийн хуулийн 3-р бүлэгт заасан социалист өмчийн эсрэг гэмт хэрэг, 5-р бүлэгт заасан иргэдийн амьны өмчийн эсрэг гэмт хэргийг 3-р бүлэгт нэгтгэн бусдын өмчийн эсрэг гэмт хэрэг болгон өөрчлөн найруулжээ. Эрүүгийн хуулийн 125-р зүйлийн 1-т зааснаар ...Бусдын эд хөрөнгийг авах зорилгоор иргэдийн амь нас, эрүүл мэндэд аюултайгаар хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж довтолсон бол гурваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Уг зүйлийн 2 дахь хэсэгт энэ үйлдлийг урьд бусдын эд хөрөнгийг авах зорилгоор дээрэмдсэн, зандалчилсан гэмт хэрэг үйлдсэн этгээд буюу онц аюултай гэмт хэрэгтэн эсхүл зохион байгуулалттай бүлэг этгээд орон байр агуулах саванд хууль бусаар нэвтэрч хийсэн уг үйлдлийг хийхдээ зэвсэг буюу бусад зүйлийг зэвсэгийн чанартайгаар хэрэглэсэн, уг үйлдлийн улмаас иргэдийн бие махбодид хүнд гэмтэл учирсан буюу уг үйлдэл нь бусдын эд хөрөнгийг их хэмжээтэй авахад чиглэсэн бол арваас хорин таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж заажээ.

Дээрх заалтаас үзвэл 125-р зүйлийн 1 дэх хэсэгт байсан эд хөрөнгө хураах ял 125-р зүйлийн 2 дахь хэсэгт заасан эд хөрөнгө хураах ял, нутаг зааж хорих зэрэг ялыг хассан байна. Мөн 1987 оны Эрүүгийн хуулийн 125-р зүйлийн 2 дахь хэсэгт заасан урьдчилан тохиролцсон бүлэг этгээд гэдгийг зохион байгуулалттай бүлэг этгээд болгон өөрчлөн найруулжээ. 125-р зүйлийн 2 дахь хэсэгт наймаас арван таван жилийн хорих ял оноож байсныг арваас хорин таван жил болгон ихсэгжээ.

Эрүүгийн хууль тогтоомжууд дахь дээрэмдэх гэмт хэрэгт оруулж байсан өөрчлөлтүүд нь эртний хууль цааз болон шинэ үеийн хууль тогтоомжийн шинж чанарыг хадгалж байхын зэрэгцээ улам боловсронгуй болжээ.



## 1.2 Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт ойлголт үндсэн шинж

Нийтийн болон хувийн өмчийн бүх төрлийг гэмт хэргийн халдлагаас хамгаалах явдал бол эрүүгийн эрх зүйн нэгэн чухал чиг үүрэг мөн. Хууль зүйн утгаараа Эрүүгийн хууль нь зохицуулах чиг үүргийн зэрэгцээ хамгаалах чиг үүргийг түлхүү гүйцэтгэдэг юм. Үүнийг Эрүүгийн хуулийн зорилтоос тодорхой харж болох юм. Үүнд:

Монгол Улсын Эрүүгийн хуулийн зорилт нь Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон хувийн өмч, үндэсний баялаг, байгаль орчин, эрх зүйн журам, энхтайван, хүн төрөлхтөний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалахад оршино.

.Монгол Улсын Эрүүгийн хууль энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд хүн, төр, нийгэмд аюултай ямар үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, түүнийг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээг тогтооно гэсэн нарийн зохицуулалттай юм.

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийг Монгол Улсын Эрүүгийн хуулийн долдугаар хэсэг Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг, арван есдүгээр бүлэг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 147 дугаар зүйлд тусгагдсан байна. Үүнд:

.....Бусдын эд хөрөнгийг авах зорилгоор амь биед нь аюултайгаар хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж довтолсон бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<sup>7</sup>

.....Энэ хэргийг давтан, бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, урьд энэ гэмт хэрэгт болон булаах, далайлган сүрдүүлэх гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд үйлдсэн, эсхүл зэвсэг, зэвсгийн чанартай бусад зүйл хэрэглэсэн, энэ хэргийн улмаас бусдад их хэмжээний хохирол учирсан бол наймаас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

.....Энэ хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл, урьд нь уулгалан довтолох гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд үйлдсэн, энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол, бусдын бие махбодид хүнд гэмтэл учирсан бол эд хөрөнгийг хурааж арваас дээш хорин таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэжээ.

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг нь өмчийн эсрэг гэмт хэргийн дотроос хамгийн хүнд гэмт хэрэг юм

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн бүрэлдэхүүнийг нарийвчлан авч үзвэл.

#### **Дээрэмдэх гэмт хэргийн бүрэлдэхүүний объект нь<sup>8</sup>:**

Бусдын өмчийн эрх бөгөөд уг өмчийн эд зүйлийг эзэмших, ашиглах, хамгаалж байгаа хүний амь бие, эрүүл мэндэд халддаг давхар объектой байдаг тул өмчийн эсрэг гэмт хэргийн хамгийн хүнд нь юм.

#### **Дээрэмдэх гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив тал нь:**

Бусдын өмчийн эд хөрөнгийг өөрийн өмч болгохын тулд биеийн болон сэтгэхүйн хүч хэрэглэсэн буюу тийм хүч хэрэглэхээр довтолох үйлдлээр илэрнэ..

Дээрэмдэх гэмт хэргийн хүчирхийллийн эрчим болон зорилго нь уг өмчийн эд зүйлийг эзэмших, ашиглах, хамгаалж байгаа хүний амь бие, эрүүл мэндэд аюул учруулах шинжтэй байдаг. Үүгээрээ хүч хэрэглэж булаах гэмт хэргээс ялгагдана.

<sup>7</sup> Монгол Улсын Эрүүгийн хууль 2002 он Төрийн мэдээлэл сэтгүүл №5

<sup>8</sup> Г.Совд. Монгол Улсын Эрүүгийн хуулийн талбар. УБ. 2002 он. 219, 220 дахь тал

Булаах хэргийн хүч хэрэглэж үйлдэхэд гэмт этгээд эд хөрөнгөө хүчээр авах боловч хүчирхийллийн эрчим нь төвөөс зугатах шинжтэй. Өөрөөр хэлбэл эд зүйлээ хүчээр авахаас биш хүний эсэргүүцлийг эргүүлэн хүчээр дарах чиглэл байдаггүй. Гэтэл дээрэмдэх хэргийг үйлдэгч нь эд хөрөнгө авах үндсэн арга түүнийг тухайн үед эзэмшиж, ашиглаж, хамгаалж байгаа хүний амь бие, эрүүл мэндэд хүчээр хор хохирол учруулах төврүү тэмүүлэх чиглэлтэй хүчирхийлэл байдаг.

Дээрэмдэх гэмт хэргийн хүчирхийлэл нь биеийн болон сэтгэхүйн аль ч хэлбэртэй байж болно. Биеийн хүчирхийлэл нь бусдын эрхэнд халдаж зодох, шархтуулахаас эхлээд янз бүрийн зэвсэг хэрэглэж халдах хэлбэрүүдтэй байж болно.

Сэтгэхүйн хүчирхийлэл гэдэг нь айлган сүрдүүлсэн тулгарсан заналхийлэл байдаг. Хэрэв эд хөрөнгийг шилжүүлэн өгөхгүй бол түүний амь бие, эрүүл мэндэд аюул учруулахаар бэлэн байгаа нь бодитой болсон байдаг.

“Сэтгэхүйн хүч хэрэглэх” гэдэг нь хохирогчийн амь бие, эрүүл мэндэд аюултайгаар хүч нэн даруй хэрэглэхээр заналхийлнэ гэсэн үг бөгөөд энэ нь үг яриа, үйл хөдөлгөөний хэлбэрээр илэрч болно.<sup>9</sup>

Дээрэмдэх гэмт хэргийн бүрдэл нь эд зүйл авсан эсэх, хүний амь бие, эрүүл мэндэд аюул учруулсан эсэхээс шалтгаалахгүй тийм шинжтэй хүчирхийлэл хийх довтолгоон эхэлснээр төгсдөг онцлогтой.

#### **Дээрэмдэх гэмт хэргийн бүрэлдэхүүний субъект нь:**<sup>10</sup>

14 насанд хүрсэн, сэтгэхүйн хувьд хэрэг хариуцах чадвартай этгээд Монгол Улсын иргэн, гадаадын харъяат, аль ч улсын иргэн биш хүн байж болно.

#### **Дээрэмдэх гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив тал нь:**

Шунахай сэдэлттэй бөгөөд бусдын эд хөрөнгийг өөрийн болгон хүчээр авах зорилготой шууд санаатай байдаг.

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн хүндрүүлэх болон онц хүндрүүлэх бүрэлдэхүүнийг нэг бүрчлэн нарийвчлан авч үзье. Үүнд:

#### **Давтан үйлдэх**

Гэмт хэрэг давтан үйлдэхийг эрүүгийн хуулийн 18 дугаар зүйлд заажээ. Үүнд:

<sup>9</sup> Монгол Улсын Дээд Шүүхийн тогтоолын эмхтгэл 2004 он 361 дэх тал

<sup>10</sup> Г.Совд. Монгол Улсын Эрүүгийн хуулийн талбар. УБ. 2002 он. 220, 221 дэх тал

.....Энэ хуулийн нэг зүйл, түүний нэг хэсэгт заасан гэмт хэргийг хоёр буюу түүнээс дээш удаа үйлдсэн байхыг давтан гэмт хэрэг гэнэ. Энэ хуулийн тусгай ангийн хэд хэдэн зүйл, хэсэгт заасан хоёр буюу түүнээс дээш гэмт хэрэг үйлдэх нь зөвхөн тусгай ангид заасан тохиолдолд давтан гэмт хэрэгт тооцогдоно.

.....Хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдсөн, ялгүй болсон, ялгүйд тооцогдсон этгээд гэмт хэрэг шинээр үйлдсэн нь давтан гэмт хэрэг болохгүй.

Дээрмийн гэмт хэргийг давтан үйлдэнэ гэдэг бол дээрмийн хэргийг тус тусдаа бүрдэлтэй хоёр буюу түүнээс дээш удаа үйлдэхийг хэлэх бөгөөд урьд нь шийтгүүлсэн шийтгүүлээгүй аль аль нь хамаарна. Харин түрүүчийн дээрмийн үйлдлээс хойш одоо шийтгүүлж байгаа үйлдэл хүртэл хөөн хэлэлцэх хугацаа өнгөрөөгүй буюу түрүүчийн шийтгүүлсэн хэргээс хойш ял шийтгэлгүйд тооцогдоогүй байх учиртай. Гэмт хэргийг давтан үйлдэх нь 147.2 зааснаар хүндрүүлэх нөхцөлд орно.

### **Гэмт хэрэгт хамтран оролцох хэлбэр<sup>11</sup>**

.....Хоёр буюу түүнээс дээш этгээд урьдчилан үгсэж тохиролцоогүй боловч гэмт хэрэг үйлдэхдээ санаатай нэгдсэн бол бүлэглэн гүйцэтгэгч гэнэ.

.....Гэмт хэрэг хамтран үйлдэх талаар урьдчилан үгсэж тохиролцсон хоёр буюу түүнээс дээш этгээдийг урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг гэнэ.

Үүнийг Эрүүгийн хуулийн 147.2 дахь хэсэгт хүндрүүлэх бүрэлдэхүүнд тусгасан байна.

.....Гэмт хэрэг үйлдэхийн тулд урьдчилан нэгдсэн, тогтвортой бүлгийг зохион байгуулалттай бүлэг гэнэ.

.....Гэмт хэрэг үйлдэж ашиг олох зорилготой, бүтэц, зохион байгуулалт бүхий этгээдүүдийн нэгдлийг гэмт бүлэглэл гэнэ.

Үүнийг Эрүүгийн хуулийн 147.3 дахь хэсэгт онц хүндрүүлэх бүрэлдэхүүнд тусгасан байна.

### **Зэвсэг болон зэвсгийн чанартай бусад зүйл**

Зэвсэг болон зэвсгийн чанартай бусад зүйлийг хэрэглэсэн гэдэгт халуун, хүйтэн зэвсэг юуны өмнө орно. Халуун зэвсэг гэдэгт тэсрэх бодисын хүчээр амьд биеийг устгах чадалтай зэвсэг орох бөгөөд үүнд гар хийцийнхээс эхлээд байлдааны

<sup>11</sup> Монгол Улсын Эрүүгийн хууль 2002 он Төрийн мэдээлэл сэтгүүл №5

зориулалт бүхий бүх төрөл, хэлбэрийн буу хамаарна. Хүйтэн зэвсэг гэдэг нь хатгах, огтлох, үйлчилгээгээр амь биеийг устгах гэмтээх чадалтай, жад, сэлэм, хутга, сүх, хайч хүртэл хамаарна.

Зэвсгийн чанартай бусад зүйл хэрэглэсэн гэдэгт халуун, хүйтэн зэвсгээс гадна хүний амь бие, эрүүл мэндэд хор хүргэх чадалтай, эд зүйлийг зориуд бэлтгэн хэрэглэснийг ойлгоно. Үүнд: муна, лантуу, лом, төмөр нударга, ташуур хүртэл хамаарна. Гэхдээ энэ бол тусгай зориулсан зүйл байх учиртай. Иймд тухайн тодорхой нөхцөлд тохиолдлоор олдсон зүйлийг хэрэглэснийг бусад зэвсгийн чанартай хэрэглэсэн гэж үзэж болохгүй.

Монгол Улсын Дээд Шүүхийн талбарт<sup>12</sup>

”Зэвсэг” гэдэгт бүх төрлийн галт болон хүйтэн зэвсэг хамаарна.

“Зэвсэгийн чанартай хэрэглэсэн бусад зүйл” гэдэгт гааз, сүх, царил, алх, бороохой гэх мэт бусдын амь бие, эрүүл мэндэд гэмтэл учруулж болох бусад зүйлийг тус тус ойлгоно.

“Хэрэглэсэн” гэдэгт зэвсэг болон бусад зүйлээр довтолгоонд өртөгчийн амь бие, эрүүл мэндэд хохирол учруулах, тэдгээрээр сүрдүүлэхийн аль алиныг хамааруулсан үйлдэл болно.

Зэвсэг болон зэвсгийн чанартай зүйл хэрэглэн довтолсон бол энэ нь хэрэглэсэн гэсэн үг юм. Тухайн зүйлээр гэмтэл учруулсан үгүйгээс үл хамааран хэрэглэсэнд тооцно.

Зэвсгийн хэлбэртэй зүйл хэрэглэснийг хохирогч зэвсэг гэж андуурч ойлгосон боловч уул зүйл нь гэмтэл бодитойгоор учруулж чадахгүй бол хэргийг зэвсгийн чанартай зүйл хэрэглэсэн гэж зүйлчлэхгүй.

### **Хохирлын хэмжээг тодорхойлох**

Эрүүгийн хуулийн 147.2 дахь хэсэгт хүндрүүлэх бүрэлдэхүүний шинж болох их хэмжээ, 147.3 дахь хэсэгт онц хүндрүүлэх бүрэлдэхүүний шинж болох онц их гэдгийг Эрүүгийн хуулийн 29 дүгээр зүйлийн тайлбар. Үүнд:

.....Гэмт хэрэг үйлдэх үед мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид заасан нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун хорин таваас дээш хоёр зуу

<sup>12</sup> Монгол Улсын Дээд Шүүхийн тогтоолын эмхтгэл 2004 он 361 дэх тал

дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээг их, хоёр зуугаас дээш дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээг онц их гэж тооцон хохирлын хэмжээг тодорхойлно<sup>13</sup>.

Улсын Их хурлын тогтоолоор 2007 оны 10 сарын 01-ний өдрөөс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 90000 төгрөгөөр тогтоосон.

Бусдын эд хөрөнгийг их хэмжээтэй авах зорилготой довтолсон бол тэр хэмжээний эд хөрөнгө байсан эсэх, авч чадсан эсэхээс хамаарахгүйгээр уул хэргийг бусдын эд хөрөнгийг их хэмжээтэй дээрэмдсэн гэж зүйлчилнэ.<sup>14</sup>

### Онц аюултай гэмт хэрэгтэн

Энэ ойлголт нь өмнөх эрүүгийн хуульд байгаагүй шинээр орж ирсэн.

Дараахь этгээдийг шүүх онц аюултай гэмт хэрэгтэнд тооцно:

Онц аюултай гэмт хэрэгтэн гэдэг нь энэ удаагийн шийтгэлээс өмнөх шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолоор онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон этгээд байна. Онц аюултай гэмт хэрэгтэн гэж ямар хүнийг хэлэх тухай Эрүүгийн хуулийн 24 дүгээр зүйлийн талбар. Үүнд:

.....урьд нь хүнд гэмт хэрэг үйлдэж хорих ялаар хоёр удаа шийтгүүлж, уг ялаа эдэлж байхдаа буюу эдэлсний дараа дахин хүнд гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгүүлсэн этгээд;

.....урьд нь хүнд буюу онц хүнд гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгүүлж, уг ялаа эдэлж байхдаа буюу эдэлсний дараа дахин онц хүнд гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгүүлсэн этгээд;

.....урьд нь хорих ял шийтгүүлж байгаагүй боловч онц хүнд гэмт хэрэг давтан үйлдэж хорих ял шийтгүүлсэн этгээд;

.....гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгүүлсэн, энэ хуулийн 36.5-д заасан гэмт бүлэглэлийн гишүүн.

.....Онц аюултай гэмт хэрэгтнээр тооцоход насанд хүрээгүй байхдаа үйлдсэн гэмт хэрэг болон энэ хуульд заасан үндэслэлээр ялгүй болсон, ялгүйд тооцогдсон гэмт хэрэг хамаарахгүй.

.....Онц аюултай гэмт хэрэгтэн гэмт хэрэг үйлдсэнийг ял хүндрүүлэх нөхцөл байдал болгон заасан энэ хуулийн тусгай ангийн хэм хэмжээг уг этгээд тухайн хэргийг

<sup>13</sup> Монгол Улсын Эрүүгийн хууль 2002 он Төрийн мэдээлэл сэтгүүл №5

<sup>14</sup> Монгол Улсын Дээд Шүүхийн тогтоолын эмхтгэл 2004 он 362 дахь тал

үйлдэхээс өмнө хуульд заасан үндэслэлээр онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон тохиолдолд хэрэглэнэ.

.....Шүүх тухайн этгээдийг онц аюултай гэмт хэрэгтнээр тооцох болсон үндэслэлээ шийтгэх тогтоолд заана.

.....Онц аюултай гэмт хэрэгтнээр тооцсон шүүхийн шийдвэр нь уг этгээд сүүлчийн гэмт хэрэгтээ ялгүй болсон, ялгүйд тооцогдсон үед хүчингүй болно.

### **Хүнд гэмтэл учруулах**

Бусдын бие махбодид хүнд гэмтэл учруулсан бол онц хүндрүүлэх нэгэн шинж болж байна. Дээрэмдэх гэмт хэргийг үйлдэхдээ бусдын бие махбодид учруулсан гэмтлийн зэргийг шүүх эмнэлэгийн шинжээчийн дүгнэлтээр тогтоолгох ёстой. Хүнд гэмтлийн хууль зүйн ойлголтыг Эрүүгийн хуулийн 96 дугаар зүйлийн тайлбартай адилаар ойлгож хэрэглэх учиртай. 96 дугаар зүйлд:

.....Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулсан, өөрөөр хэлбэл амь биед нь аюултай гэмтэл учруулсан буюу хараа, сонсголгүй болгосон, эрхтнээс нь хагацуулсан, ажиллагаагүй болгосон, нүүрийг засаршгүй эвдэж дүрсийг алдагдуулсан, хүүхэд дутуу гаргуулсан, сэтгэцийн өвчтэй болгосон, түүнчлэн хөдөлмөрийн чадварыг бүрмөсөн алдагдуулсан хүнд гэмтэл учруулсан гэж үзнэ.

Иргэдийн бие махбодид хүнд гэмтэл учруулсан гэдэгт Монгол Улсын Дээд шүүхээс тогтоосон “гэмтлийн зэрэг тогтоох заавар”-т заасныг ойлгоно. Тус зааварт зааснаар

**А.**Бусдын бие махбодид, амь насанд аюултай гэмтэл учруулсан. Энэ нь гавал, цээж, хэвлий, нугасны хөндий рүү нэвт орсон шархнууд, гавлын орой суурин ясуудыг ил ба битүү хугарах зэрэг 40-өөд гэмтэл орно.

**Б.**Сохор болгосон. Энэ нь 2 нүдийг эмчлэгдэхгүйгээр бүр мөсөн хараагүй болгосон болон ойрын юм дүрсийг ялгахгүй болгохыг хэлнэ.

**В.**Дүлий болгосон. Энэ нь 2 чих эмчлэгдэхгүйгээр сонсголгүй болох, 3-5 см-ийн зайд ердийн яриаг сонсох чадваргүй болохыг хэлнэ.

**Г.**Бусад ямар нэгэн эрхтнээс нь хагацуулах буюу түүнийг ажиллагаагүй болгосон. Энэ нь хэлгүй болгох, гар хөлнөөс нь хагацуулах, бэлгийн үйл ажиллагаа алдагдуулсныг хэлнэ.

Д.Нүүрийг засрашгүй эвдэж дүрсийг алдагдуулах. Энэ нь нүүрийн гэмтлийг засаж арилгахад мэс заслын эмчилгээ зайлшгүй шаардлагатай болсныг хэлнэ.

Е.Хүүхэд дутуу гаргасан. Энэ нь жирэмсэлтийн хугацаанаас өмнө жирэмсэлт тасалдсныг хэлнэ.

Ё. Сэтгэл мэдрлийн өвчтэй болгосон, эрүүл мэндийг саринуулсан хөдөлмөрийн чадварыг гурваны нэгээс доошгүй хугацаагаар алдагдуулсан. Энэ нь Сэтгэл мэдрэлийн үйл ажиллагааг түр хугацаагаар саринуулсан, хөдөлмөрийн ерөнхий чадварыг 33 хувиас дээш алдагдуулсныг хэлнэ.

Урьд нь энэ хэрэгт болон булаах, далайлган сүрдүүлэх, уулгалан довтлох хэрэгт шийтгүүлсэн бөгөөд ял шийтгэлтэй байгаа нь гэмт этгээдийн хувийн байдлыг харгалзан хүндрүүлэх буюу онц хүндрүүлэх бүрэлдэхүүний шинж болдог.

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн үед хүний амь насыг хохироосон бол Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2.7 зааснаар уулгалан довтлох дээрмийн гэмт хэргийг үйлдэхдээ хүнийг санаатай алсан бол 15 жилээс дээш 25 жил хүртэл хугацаагаар хорих эсхүл цаазаар авах ял шийтгэнэ гэж заасан байна.

Дээрэмдэх гэмт хэргийн онцлог нь хохирогчийн амь насанд аюултай хүч хэрэглэж довтолсон, эсхүл тийм хүч хэрэглэхээр заналхийлж айдас төрүүлсэн байх явдал юм. Хулгайн гэмт хэрэг далд аргаар үйлдэгддэг, ихэнх булаалт ил үйлдэгддэг боловч үйлдсэнийхээ дараа зугтаж нуугдах нийтлэг хандлагатай байдаг бол дээрмийн гэмт хэрэг нь ихэвчлэн дээрэлхэж давамгайлсан түрэмгий дээрэнгүй үйлдлээр илэрнэ.

Гэхдээ дээрмийг тэр бүр олны дунд үйлдэх нь ховор, харанхуй бүрэнхий цагаар, хүнгүй буйд газар гэх мэт өөрийгөө таниулах, хохирогчид бусдын дэм туслалцаа үзүүлэх боломж муутай нөхцөл байдлыг сонгож үйлдэх нь элбэг байдаг. Энэ нь мөн уг гэмт хэргийг илрүүлж нотлоход бэрхшээл учруулах гол нөхцөл байдаг.

Амь насанд аюултай хүч хэрэглэсэн тохиолдолд хохирогчийн биед уг хүч хэрэглсэнээс буй болсон гэмтэл, ул мөрийг үзлэгээр илрүүлэн бэхжүүлэх, шүүх эмнэлгийн шинжилгээ томилж дүгнэлт гаргуулах зэрэг ажиллагааг юуны өмнө хийх хэрэгтэй. Тухайн гэмтэл, ул мөрийг чухамхүү дээрэм болох тэр үед үүсгэгдсэн гэдгийг хожим маргашгүйгээр тогтоох хэрэгтэй. Эсрэг тохиолдолд зарим шарх, гэмтэл харьцангуй хурдан бүдгэрч, эдгэрдэг тул эдгээр ажиллагааг хойшлуулашгүй явуулбал зохино.



Ихэнх тохиолдолд гэмт этгээдүүд хүч хэрэглэснээ үгүйсгэх хандлагатай байдаг тул хүч хэрэглэсэн байдлыг тал бүрээс нь бүрэн дүүрэн тогтооход ихээхэн анхаарах ёстой.

Харин заналхийлсэн байдлыг хохирогчийн мэдүүлэг, хэрэглэсэн буюу авч явсан зэвсэг хэрэгслийн байдал, дээрэмдсэн этгээдийн хувийн зан чанар, өмнө нь энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж байсан арга хэлбэр зэрэг олон зүйлээр тодорхойлж болно. Заналхийлэл заавал биелэх байсан эсэхээс хамаарахгүй тухайн заналхийлж байгаа байдал нь хохирогчид айдас, болгоомжлол төрүүлсний улмаас дээрэмдэж буй этгээдэд шаардсан зүйлийг нь сайн дураараа гаргаж өгсөн, эсхүл авахад нь эсэргүүцэл үзүүлээгүй нь дээрмийн гэмт хэргийн шинжийг илэрхийлдэг. Булаах гэмт хэргийн үед хохирогч санамсаргүй байснаас гэнэдэж эд зүйлээ алдсан байдаг бол дээрэмдэх гэмт хэргийн үед хохирогч шаардсан зүйлийг нь сайн дураараа өгөх, эсхүл авч байгааг таслан зогсоох, эсэргүүцэл үзүүлэх боломж байсаар атал тийм үйлдэл хийлгүйгээр эд зүйлийг авах бололцоо олгосон байдаг. Иймд эд зүйлээ гэмт этгээдэд алдсан, өгсөн, авах бололцоо олгосон бүх нөхцөл байдлыг тал бүрээс нь нотолсон байх ёстой.

Дээрмийн гэмт хэрийн хүндрүүлэх бүрэлдэхүүн болох дараах нөхцөл байдлууд байгаа эсэхийг нэг бүрчлэн нотолж тогтоосон байхыг шаардана.

147.2-т заасан хүндрүүлэх бүрэлдэхүүн:

- дээрэмдэх хэргийг давтан үйлдсэн,
- бүлэглэж үйлдсэн,
- урьдчилан үгсэн тохиролцсон бүлэг үйлдсэн,
- урьд энэ гэмт хэрэгт болон булаах, далайлган сүрдүүлэх гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд үйлдсэн,
- зэвсэг, зэвсгийн чанартай бусад зүйл хэрэглэсэн,
- энэ хэргийн улмаас бусдад их хэмжээний хохирол учирсан.

147.3-т заасан хүндрүүлэх бүрэлдэхүүн:

- онц аюултай гэмт хэрэгтэн үйлдсэн,
- зохион байгуулалттай бүлэг үйлдсэн,
- гэмт бүлэглэл үйлдсэн,

- урьд нь уулгалан довтлох гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд үйлдсэн,
- энэ хэрийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан,
- бусдын бие махбодид хүнд гэмтэл учирсан.

Дээрмийн гэмт хэргийн бас нэг онцлог бол энэ гэмт хэргийг бүлэглэж үйлдэх хандлагатай, судалгаанаас харахад өсвөр насныхан үйлдэх нь элбэг байдаг байна.

Энэ онцлогоос хамааран түүнийг энгийн байдлаар бүлэглэсэн, урьдчилан тохиролцсон, зохион байгуулалттай бүлэг, эсхүл гэмт бүлэглэл байсан эсэхийг сайтар нотолж тогтоосон байх хэрэгтэй. Дээрмийн гэмт хэргийг урьдчилан тохиролцсон бүлэг этгээд байнга үйлдсэн байх магадлал өндөртэй байдаг нь үүнд онцгой анхаарах шалтгааныг буй болгодог юм.

1986 оны 12 сарын 05-ны өдрийн Эрүүгийн хууль болон 2001 оны 01 сарын 03-ны өдрийн Эрүүгийн хуульд бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн өөрчлөгдсөн болон нэмэгдсэн зүйлүүд.<sup>15</sup>

**Өөрчлөгдсөн:** 125-р зүйлийн 1 дэх хэсгийн.....иргэдийн амь бие, эрүүл мэндэд аюултайгаар хүч хэрэглэж гэснийг 147.1-р зүйлд.....амь биед нь аюултайгаар хүч хэрэглэж гэж

**Нэмэгдсэн:** Эд хөрөнгө хураах ялыг

Бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцон бүлэг, давтан, далайлган сүрдүүлэх гэмт хэрэгт шийтгэгдсэн этгээд, гэмт бүлэглэл үйлдсэн, энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсаныг хүндрүүлэх нөхцөл байдалд тооцно.

### **Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийг төсөөтэй**

#### **бусад гэмт хэргээс ялган зүйлчлэх нь**

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг нь хэдийгээр бусдын өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн нэг боловч тэднээс ялгагдах өөрийн гэсэн өвөрмөц шинжүүдтэй.

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийг бусад төсөөтэй гэмт хэргүүдээс ялгагдах онцлог шинжүүдийг эрүүгийн эрх зүйн үүднээс нарийвчлан тогтоох нь энэ

<sup>15</sup> Монгол улсын хууичн ба шинэ эрүүгийн хуулиудыг харьцуулсан судалгаа УБ 2002он 78-79 дэх тал

гэмт хэргийг үйлдэгсэдэд хариуцлагыг зөв оноох, бусад төсөөтэй гэмт хэргүүдээс ялгаж зүйлчлэх, энэ хэргийн талаар хуулийн байгууллагын ажилчдад нэг мөр ойлголт өгөх ач холбогдолтой. Иймээс бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн бусад төсөөтэй гэмт хэргээс ялгагдах онцлогыг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнээр нь авч үзье. Юуны өмнө дээрмийн гэмт хэрэгтэй практикт хамгийн ихээр алдаж зүйлчлэгддэг хэргийг авч үзье.

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг нь бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэргээс дараах шинжээр ялгагдана. Үүнд:

1.Бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэрэг нь бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргээс үйлдлийн аргаараа ялгагдана. Булаах гэмт хэрэг нь төвөөс зугтаасан шинжтэй байдаг. Харин дээрмийн гэмт хэрэг нь төврүү чиглэсэн байдаг. Булаан гэмт хэрэг хүч хэрэглэж болон хүч хэрэглэхгүйгээр булаах гэсэн 2 хэлбэртэй бөгөөд хүч хэрэглэж булаах үед гэмт этгээд нь илээр буюу бусдын нүдний өмнө хохирогчийн биед аюулгүйгээр зөвхөн түлхэх, угзрах гэсэн хэлбэрээр хүч илэрч болох бөгөөд энэ үед хохирогчийн биед ялгүй гэмтэл учирна. Дээрмийн гэмт хэрэгт гэмтэл учрахаас гадна тийм аюул учруулах нөхцөл байдал үүсдэггүй. Түүнчлэн дээрмийн гэмт хэргийн үед хохирогч нь гэмт этгээдээс айж улмаар амь нас, эрүүл мэндээ хамгаалахаар эд зүйл, мөнгөө гаргаж өгөх болон гэмт этгээд нь хохирогчийн биед далд байгаа зүйлийн нэгжин авдаг. Мөн хувцас болон гутлыг нь тайлуулан авдаг.

Дээрмийн гэмт хэргийн үед хэрэглэж байгаа буюу хэрэглэхээр заналхийлж байгаа хүч нь биеийн буюу сэтгэл зүйн шинжтэй байж болох бөгөөд учрах үедээ довтолгоонд өртөгсдийн амь бие, эрүүл мэндэд бодитой аюул учруулдаг буюу учруулж болзошгүй байдгаараа хүч хэрэглэж булаах гэмт хэргээс ялгагдана.

Булаах гэмт хэрэг нь бусдын амь бие, эрүүл мэндэд аюулгүйгээр хүч хэрэглэхдээ хохирогчийн буюу бусад хүмүүсийн амь бие, эрүүл мэндэд аюул учруулаагүй үйлдэл байна. Энэ нь түлхэх, хүлэх, байранд нь оруулж түгжих, амыг нь боох зэрэг үйлдлээр илэрч болно. Булаах үйлдлийн үед хэрэглэсэн хүчний улмаас улайх, зулгарах зэрэг түргэн эдгэрэх хөнгөн гэмтэл учирсан байж болно. Эд хөрөнгө авахын тулд хүч хэрэглэснээс үүсэн гэмтэл нь шинж чанар, зэргийн хувьд үүнээс

хэтэрч эрүүл мэндийг сарниулах, хөдөлмөрийн чадварыг бага боловч алдагдуулахад хүргэсэн бол дээрмийн гэмт хэргийн шинжтэй болно<sup>16</sup>.

2.Бүрэлдэхүүний хэлбэрээр ялгаатай. Булаах гэмт хэрэг нь материалаг бүрэлдэхүүнтэй бөгөөд бусдын эд хөрөнгийг булаан авч өөрийн болон бусдын эзэмшилд шилжүүлснээр бүрэлдэхүүн бүрэн төгсдөг. Харин дээрмийн гэмт хэрэг нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй. Бусдын эд хөрөнгийг авахаар хүч хэрэглэж болон хүч хэрэглэхээр заналхийлэн довтолсон үеэс бүрэлдэхүүн төгсөж төгссөн гэмт хэрэгт тооцно.

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг нь бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргээс дараах шинжээр ялгагдана. Үүнд:

1.Объектоор – хулгайн гэмт хэргийн объект нь өмчлөх эрх байдаг бол дээрмийн гэмт хэргийн объект нь өмчлөх эрхээс гадна иргэдийн амь нас, эрүүл мэнд байдаг.

2.Үйлдлийн аргаараа – хулгайлах гэмт хэргийн үед өмчлөгчийн нүднээс далдуур нууц далд аргаар гэмт үйл ажиллагаа хэрэгжидэг бол дээрмийн гэмт хэргийн үед өмчлөгч этгээдэд хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж түүний нүдэн дээр эд хөрөнгийг авдаг.

Бусдын эд хөрөнгийг дээрэдэх гэмт хэрэг нь бусдын эд хөрөнгийг авахаар далайлган сүрдүүлэх гэмт хэргээс дараах шинжээр ялгагдана. Үүнд:

1.Үйлдлийн аргаараа ялгагдана – Далайлган сүрдүүлэх гэмт хэргийн үед өмчлөгч буюу түүний ойр дотны хүмүүст хүч хэрэглэн, нэр төрийг нь гутаасан мэдээ баримт тараана гэж сүрдүүлж заналхийлэх ба энэхүү заналхийлэх нь дээрмийн гэмт хэрэг шиг тэр даруйдаа хэрэгжих биш хэсэг хугацааны дараа хэрэгжих магадлалтай.

2.Мөн далайлган сүрдүүлэх гэмт хэргийн илэрэл нь нэр төрийг нь гутаасан мэдээ, баримт тараана гэсэн заналхийллийн хэлбэрээр илэрдэг бол дээрмийн гэмт хэргийн заналхийлэл нь ална, буудна, хутгална гэх мэт заналхийлэл байдаг.

Бусдын эд хөрөнгийг дээрэдэх гэмт хэрэг нь бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэргээс дараах шинжээр ялгагдана. Үүнд:

<sup>16</sup> Монгол Улсын Дээд Шүүхийн тогтоолын эмхтгэл 2004 он 360-361 дахь тал

1.Залилан мэхлэх гэмт хэрэг нь эд хөрөнгө, мөнгө, үнэт зүйлийг хуурч мэхлэх буюу түүний итгэлийг эвдэх замаар шунахай сэдэлтээр авч буй идвэхтэй үйлдэл юм.

2.Залилах гэмт хэргийн нэг гол шинж нь хохирогч этгээд нь хөрөнгөө гэм буруутай этгээдэд хуурч мэхлэгдэж буюу итгэл эвдэж сайн дураараа шилжүүлэн өгдөг.

## эрх зүйн зохицуулалт

**БНХАУ-ын эрүүгийн хуульд бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийг тусгасан нь:**

БНХАУ-ын Эрүүгийн хуулийг БНХАУ-ын 8-р хуралдааны тус улсын Ардын төлөөлөгчдийн их хурлын 5-р хуралдаанаас 1997 оны 3-р сарын 14-ний өдөр засвар оруулж тогтоожээ.<sup>17</sup>

Эдүүгээ засвар оруулсны дараа БНХАУ-ын Эрүүгийн хуулийг нийтлэв. 1997 оны 10-р сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлнэ гэжээ.

БНХАУ-ын эрүүгийн хуулийн 5- дугаар бүлэгт **Эд хөрөнгөнд халдах ял** гэж заажээ..

**БНХАУ-ын эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлд<sup>18</sup>:**

Хүчирхийлэл, сүрдүүлэг буюу бусад аргаар албаны ба амины эд хөрөнгийг тонон дээрэмдсэн байвал гурван жилээс дээш арван жилээс доош хугацаатай хорихоор шийтгээд зоосоор яллахаар шийтгэнэ.

Доорх байдлуудын аль нэг нь байвал арван жилээс дээш хугацаатай хорих, хугацаагүй хорих буюу алахаар шийтгээд зоосоор яллах буюу эд хөрөнгийг нь хураан авахаар нийлүүлэн шийтгэнэ.

**Нэг.** Гэрт орж тонон дээрэмдсэн байвал

**Хоёр.** Олон нийтийн зам харилцааны бааз хэрэгслийн дээр тонон дээрэмдсэн байвал

**Гурав.** Банк буюу бусад мөнгөн гүйлгээний байгууламжийг тонон дээрэмдсэн байвал

**Дөрөв.** Олон удаа тонон дээрэмдсэн буюу тонон дээрэмдсэн тоо нь лут байвал

**Тав.** Тонон дээрэмдээд хүнийг хүнд шархдуулсан, үхүүлсэн байвал

**Заргаа.** Цэрэг цагдаагийн нэр барьж тонон дээрэмдсэн байвал

**Долоо.** Буу барьж тонон дээрэмдсэн байвал

**Найм.** Цэргийн хэрэгслийн эд бараа буюу аюулаас аврах, гамшигаас тэнхрүүлэх, тусалж тэтгэх эд барааг тонон дээрэмдсэн байвал

<sup>17</sup> БНХАУ-ын Эрүүгийн ба эрүүгийн заргын хууль.УБ.Б.Батзориг, Э.Зууннасан. 75 дахь тал

<sup>18</sup> БНХАУ-ын Эрүүгийн хууль. 1997 он

Эдгээрийг хүндрүүлэх нөхцөл болгон заасан байна.

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэгт оногдуулах ял нь

1. Хугацаатай хорих
2. Хугацаагүй хорих
3. Зоосоор яллах
4. алах ял
5. Эд хөрөнгийг хураан авах

Хугацаатай болон хугацаагүй хорих ялыг БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 45, 46, 47 дугаар зүйлүүдэд зааж өгсөн байна. Үүнд<sup>19</sup>

Хугацаатай хорих тус хуулийн 50-р зүйл, 69-р зүйлд тогтоосныг гаргавал 6 сараас дээш арван таван жилээс доош байлгана. **/45-р зүйл/<sup>20</sup>**

Хугацаатай хорих, хугацаагүй хорихоор шийтгэгдсэн ялт этгээдийг гянданд буюу бусад гүйцэтгэх талбарт гүйцэтгэнэ. Хөдөлмөрлөх чадалтай нь цөм хөдөлмөрт оролцож, хүмүүжигдэн өөрчлөгдөх ёстой. **/46-р зүйл/**

Хугацаатай хорих эрүүгийн хугацааг шүүн таслалтыг эрхлэн гүйцэтгэх өдрөөс тооцно. Шүүн таслалтыг гүйцэтгэх өдрөөс өмнө урдаар хорьсон байвал хоригдсон нэг өдрийг нь эрүүгийн хугацааны нэг өдрөөр тооцно. **/47-р зүйл/**

Алах эрүүг гагцхүү туйлын хүнд ял хийсэн ялт этгээдэд л тохируулан хэрэглэнэ. Алахаар шийтгэх ёстой ялт этгээдийг заавал дор нь гүйцэтгэх хэрэгтэй биш байвал алахаар шийтгэхийг хоёр жил алгуурлан гүйцэтгэж болно. Хууль ёсоор Ардын дээд шүүх хорооны шүүн таслахаас бусад алах эрүүг бүгдийг нь Ардын дээд шүүх хороонд мэдүүлж хянан зөвшөөрүүлэх ёстой. Алах эрүүг алгуурлан гүйцэтгэхийг ардын өндөр зэргийн шүүх хороо шүүн таслах буюу хянан зөвшөөрч болно. **/48-р зүйл/**

Ял хийх үедээ бүх л арван найман насанд үл хүрсэн ба шүүн таслах үед жирэмсэн байх эмэгтэйд алах ялыг тохируулан хэрэглэхгүй. **/49-р зүйл/**

Алахаар шийтгэхээр алгуурлан гүйцэтгэгсэд алахыг алгуурлан гүйцэтгэх хугацаа нь хэрвээ зохиуд ял хийсэнгүй байвал хоёр жилийн хугацаа нь дууссаны дараа хугацаагүй хорих болгон хөнгөрүүлнэ. Үнэнхүү чухал их гавъяа байгуулсан нь илрэлтэй байвал хоёр жилийн хугацаа дууссаны дараа арван таван жилээс дээш

<sup>19</sup> БНХАУ-ын Эрүүгийн ба эрүүгийн заргын хууль.УБ.Б.Батзориг, Э.Зууннасан. 18 дахь тал

<sup>20</sup> БНХАУ-ын Эрүүгийн хууль. 1997 он

хорин жилээс доош хугацаатай хорих болгон хөнгөрүүлнэ. Хэрэв зориуд ял хийсэн бөгөөд байцаан тодлоод үнэн магад байвал Ардын дээд шүүх хороогоор хянан зөвшөөрүүлээд ялах эрүү гүйцэтгэнэ. **/50-р зүйл/<sup>21</sup>**

Алахаар шийтгээд агуулан гүйцэтгэх хугацааг нь шүүх таслалтыг тогтоосон өдрөөс эхлэн бодно. Алах эрүүгийн алгуурлан гүйцэтгэхийг хугацаатай хорих болгон хөнгөрүүлсэн байвал түүний эрүүгийн хугацааг түүний алах эрүүгийн алгуурлан гүйцэтгэх хугацаа дууссан өдрөөс эхэлж бодно. **/51-р<sup>22</sup> зүйл/**

Зоосоор яллахаар шийтгэхдээ хийсэн ялынх нь үйл байдлыг үзэж яллах зоосны тоог тогтох ёстой. **/52-р зүйл/**

Ялласан зоосыг шүүн таслалт тогтоосон хугацааны дотор нэг удаад буюу хугацаа хувааж тушаана. Хугацаа дүүртэл тушаахгүй байвал албадан тушаалгана. Ялласан зоосыг бүгдийг тушааж дийлэхгүй байвал Ардын шүүх хороо гүйцэтгэгч хүнд гүйцэтгэж болох эд хөрөнгийг нь олж мэдмэгц цаг тухайд нь нэхэмжилж тушаалгах ёстой. Хориглогдошгүй гай гамшиг тушаахад үнэхээр учиртай болсон байвал байдлыг нь үзэж багасгах буюу хэлтрүүлж болно. **/53-р зүйл/**

Эд хөрөнгийг нь хураан авах нь ялт этгээдийн хувийн өмчлөлийн нэг хэсэг буюу бүгдийг нь хурааж авах явдал болно. Эд хөрөнгийг нь бүгдийг нь хурааж авахдаа ялт этгээдийн хувь хүн хийгээд түүний асран тэжээж байгаа гэр бүлийнхэнд чухал бүхий амьдралын зардал үлдээх ёстой. Эд хөрөнгийг нь хураан авахаар шийтгэхдээ ялт этгээдийн гэр бүлийнхний өмчлөл болох буюу эдлэх эрхтэй эд хөрөнгийг хураан авч болохгүй. **/59-р зүйл/**

Эд хөрөнгийг хураан авахаас өмнө ялт этгээдийн зүй ёсны өрийг хураан авсан эд хөрөнгөөр төлөх чухалтай байвал авцаатны хүсэлтээр төлөх ёстой. **/60-р зүйл/**

**ОХУ-ын эрүүгийн хуульд бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийг тусгасан нь:**

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 162 дугаар зүйлд бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийг зүйлчлэн тусгасан байна. Үүнд:

1.Дээрэмдэх буюу бусдын эд хөрөнгийг дээрэмдэх зорилгоор хүний амь нас, эрүүл мэндэд аюултайгаар хүч хэрэглэх эсвэл хүч хэрэглэхээр сүрдүүлж довтолсон

<sup>21</sup> БНХАУ-ын Эрүүгийн ба эрүүгийн заргын хууль.УБ.Б.Батзориг, Э.Зууннасан. 20 дахь тал

<sup>22</sup> БНХАУ-ын Эрүүгийн хууль. 1997 он



бол 3-8 жилийн хугацаагаар хорьж эд хөрөнгийг нь хураах эсвэл эд хөрөнгийг нь хураахгүйгээр хорих ял шийтгэнэ.

2.Дээрмийн үйлдлийг:

а/Урьдчилан тохиролцсон бүлэг этгээд үйлдсэн

б/Нэг бус удаа давтсан

в/Орон байр, байшин, агуулахад хууль бусаар нэвтэрч үйлдсэн

г/Буу зэвсэг, зэвсгийн чанартайгаар ашиглагдах эд зүйлс хэрэглэж үйлдсэн бол эд хөрөнгийг хурааж 7-оос 12 жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ.

3.Дээрмийн үйлдлийг:

а/Зохион байгуулалттай бүлэг үйлдсэн

б/Ихээхэн хэмжээний эд хөрөнгийг авах зорилгоор үйлдсэн

в/Хохирогчийн биед хүнд гэмтэл учруулсан

г/Урьд нь 2 түүнээс дээш удаа хулгай, сүрдүүлгийн хэргээр ял шийтгүүлж байсан этгээд үйлдсэн бол эд хөрөнгийг хурааж 8-аас 15 жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ.<sup>23</sup>

Үүнээс харахад оногдуулах ялын доод хэмжээ нь манай улсын хувьд 5-8 жилээс эхлэж байна. БНХАУ-ын хувьд 3-8 жил, ОХУ-ын хувьд 3-8 жил байна. БНХАУ-ын хуульд гэрт орж тонон дээрэмдсэн, олон нийтийн зам харилцааны бааз хэрэгслийн дээр тонон дээрэмдсэн, банк буюу бусад мөнгөн гүйлгээний байгууламжийг тонон дээрэмдсэн гэж онцлог объектуудыг зааж өгсөн байна. ОХУ-ын хуульд орон байр, байшин, агуулахад хууль бусаар нэвтэрч үйлдсэн гэж заасан байна. Бусад хүндрүүлэх нөхцөл байдлуудын хувьд манай орны хуультай адил төсөөтэй байна.

<sup>23</sup> ОХУ-ын “Эрүүгийн хууль” 162-р зүйл 2002 он

## Хоёрдугаар бүлэг

### Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга замыг боловсронгуй болгох нь

#### 2.1 Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн шалтгаан нөхцөл.

Гэмт явдлын шалтгааны тухай асуудал нь криминологийн шинжлэх ухааны үндсэн асуудлын нэг юм. Гэмт явдлын шалтгаан нөхцөл нь тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаанаас хавьгүй өргөн хүрээтэй ойлголт бөгөөд гэмт явдлын шалтгааныг зөв тогтоох нь уг нийгмийн үзэгдлийн мөн чанарыг илрүүлэх, түүнийг арилгах арга замыг олоход чухал ач холбогдолтой, криминологийн шинжлэх ухааны үндсэн асуудлын нэг юм.

Гэмт явдлын шалтгааныг зөв тайлбарлахын тулд шалтгаан нөхцөл, нөхцөл байдал, хүчин зүйл гэсэн ойлголтуудыг ялгаа, заагтай авч үзэх шаардлагатай.

Гэмт явдлын шалтгааныг судлахдаа залшгүй буюу тохиолдлын шинжийн ялгааг гаргах шаардлагатай бөгөөд тодорхой үзэгдэл бүхэн өөртөө тохиолдлын буюу залшгүй шинжийг агуулсан байдаг.

Шалтгаангүй юм гэж нэгээхэн ч үгүй бөгөөд байгаль, нийгэм, юмс, үзэгдэл тодорхой шалтгаан, нөхцөл тохироогоор нөхцөлдөн үүсэн бий болж, устан арилж, түгээмэл хэлхээ холбоонд оршин тогтнож, хувьсан өөрчлөгдөж байдаг. Шалтгаан нь үр дагаварыг төрүүлдэг бөгөөд тодорхой нөхцөл тохироо бүрдсэн үед өөр үзэгдлийг төрүүлдэг тийм үзэгдэл үйл явцыг шалтгаан гэдэг. Шалтгааны шууд үйлчлэлээр төрж гарсан үзэгдлийг үр дагавар гэнэ. Гэмт явдал нийгмийн үзэгдлийн хувьд шалтгаан нөхцөлтэй байдаг. Гэмт явдлын шалтгааныг тайлбарлахад “шалтгаан”, “нөхцөл”, “нөхцөл байдал”, “хүчин зүйл” гэсэн ойлголтууд аяндаа гардаг ба эдгээр нь эсрэг,

тэсрэг ойлголтууд биш боловч нэгдмэл чанартай, нэг төрлийн ойлголт бас биш юм. Шалтгаан нь нөхцөлтэй уялдаж байж үр дагвар бий болгоно. Жишээ нь: хөдөө орон нутгаас хотруу олон тооны хүмүүс шилжин ирж суурьшин тэдгээрийн зарим нь ажилгүйдлээс үүдэн гэмт хэрэг үйлдсэн гэвэл орон нутагт амьдрахад хүнд болж хотод шилжин ирсэн нь гэмт хэргийн шалтгаан биш, харин нөхцөл нь болно. Шалтгаан нь тухайн тохиолдолын хувьд хүний гэмт зан төлөв бий болоход шууд нөлөөлсөн хүчин зүйл юм. Тэгвэл нөхцөл байдал гэдэг нь зөвхөн тодорхой гэмт хэрэг дээр ойлгох ойлголт бөгөөд хүний зан төлөвт хэд хэдэн нөхцөл байдал нөлөөлж болно.<sup>24</sup>

Ийнхүү дээрхи ойлголтуудыг ялган зааглах нь гэмт явдлын шалтгааныг судлахад тус дөхөм үзүүлнэ. Гэмт явдлын шалтгаан нөхцлийн нийгмийн шинж чанар нь улс төр, эдийн засаг, сэтгэл зүй, үзэл суртал, зохион байгуулалтын агуулгатай нийгмийн үзэгдэл үйл явцын нэгдэл бөгөөд нөгөө талаар нийгэмд хор хөнөөл учруулдаг үйлдэл, эс үйлдлийг төрүүлдгээрээ тодорхойлогдоно. Гэмт явдал нь тодорхой гэмт хэргүүдээс бүрддэг тул гэмт хэрэг нэг бүрийн шалтгаан нөхцөл гэмт явдлын шалтгаан нөхцөл болно.

#### **Тодорхой гэмт хэргийн шалтгаан нөхцөл:**

Тодорхой гэмт хэргийн шалтгаан гэсэн ойлголтонд тухайн хүнд гэмт хэрэг үйлдэх шийдмэг бодол төрүүлсэн үзэгдэл, зүйл явц хамаарах ба энэ тусгай шалтгаан нь янз бүрийн цаг хугацаанд тодорхой нөхцөлүүдээс үүдэн гарсан хэд хэдэн шалтгааны нэгдэл байна<sup>25</sup>.

Тодорхой гэмт хэргийн шалтгааныг хувь хүнд төлөвшин тогтсон нийгэмд харш үзэл бодол, дадал заншил, хүрээлэн буй орчны тааламжгүй нөлөөлөл, амьдралын тодорхой нөхцөл байдал буюу гэмт хэрэг үйлдэх тохироо гэсэн гурван хүчин зүйлийн нэгдлээр тодорхойлж болно. Хувь хүнд төлөвшин тогтсон нийгэмд харш үзэл бодол, дадал заншил тодорхой гэмт хэргийн нийтлэг шалтгаан болно.

Гэмт хэрэг үйлдэж байгаа хүмүүс нь ямар нэгэн хэмжээгээр нийгэмд харш үзэл бодол тогтсон, хууль ёсыг ул тоомсорлодог, хувийн хэрэгцээгээ гэмт хэрэг үйлдэх замаар хангах эрмэлзлэлтэй, бусдын эрх чөлөө, нийгмийн дэг журмыг хэрэгсдэггүй байх нь олонтоо. Мэдээж тохиолдлын шинжтэй гэмт хэрэг үйлдэгсэд, болгоомжгүй гэмт хэрэг үйлдэгсэдийн хувьд нийгэмд харш зан төлөв гүнзгий тогтоогүй байдаг бол

<sup>24</sup> Н.Баатаржав, Б.Жаргал “Криминологи” УБ. 2001 он 33-34 дэхь тал

<sup>25</sup> Н.Жанцан. “Криминологи” УБ. 2003 он. 71 дэх тал

давтан гэмт хэрэг үйлдэгсэд, санаатай гэмт хэрэг үйлдэгсэд, хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдэгсэдийн дийлэнх нь нийгэмд харш зан төлөв нь гэмт хэрэг үйлдүүлэхэд хүргэсэн байдаг.

Нийгэмд харш зан төлөв, дадал заншил гэдэг нь нийгмийн сөрөг үзэгдэл, үйл явцын нөлөөллийн улмаас тухайн хүний оюун санаанд бүрэлдэн тогтсон нийгмийн ёс суртахуунд илтэд харш үзэл бодлын нийлбэр цогцос юм.

Тухайлбал: хар амиа бодох, бусдын үл тоомсорлох, үл хүндэтгэх, бүдүүлэг танхай балмад зан гаргах, шударга хөдөлмөрөөс хойш суух, хууль ёсыг үл тоомсорлох, үл биелүүлэх зэрэг нь ёс суртахуун, зан төлвийн доголдол бөгөөд ийм үзэл бодол нь тодорхой гэмт хэрэг үйлдэх үед сэдэлтийн хэлбэрээр илэрдэг.

### **Гэмт хэрэг үйлдэхэд хүрээлэн буй орчны тааламжгүй нөлөө**

Орчин ахуйн тааламжгүй нөхцөл нь бие хүний хүмүүжил, ёс суртахуунд нийгэмд харш үзэл бодол, дадал заншил бүрэлдэн тогтох эх үндэс нь болдог.

Орчин ахуйн тааламжгүй нөлөө гэдэгт гэр бүл, хамт олон, сургууль, албан байгууллага зэрэг бичил орчны тааламжгүй нөлөө, тэдгээрээс зохиож буй хүмүүжлийн болон урьдчилан сэргийлэх ажлын дутагдал зэрэг хамаарна.<sup>26</sup>

Нийгмийн бүхий л амьдралд гэр бүл, ахуй амьдралын нөхцөл, хүрээлэн буй хүмүүсийн харьцаа зэрэг эд материал, оюун санааны харилцан үйлчлэлийн үр дүнд хүний зан төлөв бүрэлдэн тогтдог боловч бие хүнд шууд нөлөөлж байгаа тэрхүү орчин нь хүн бүрт, тодорхой нөхцөл байдал бүрд адил хэмжээгээр биш өөр өөр онцлогтойгоор нөлөөлж байдаг.

Орчин ахуйн тааламжгүй нөхцөл нь тухайн хүнд нийгэмд харш зан төлөв, дадал заншил бүрдэн тогтох шууд шалтгаан болдог. Нийгэмд харш зан төлөв хүмүүсийг гэмт хэрэг үйлдэх үндсэн нөхцлийг бүрдүүлдэг.

Гэмт этгээдүүдийн хувьд өөрсөддөө тулгарсан бэрхшээлтэй асуудлыг хуульд заасан арга хэрэгслээр давахыг бараг бодохгүй, гэмт хэргийн замаар буюу хэнийг дээрэмдэх бэ, хэний эд зүйлийг хулгайлах бэ, гэж л бодож түүнийгээ гүйцэлдүүлдэг онцлогтой.

Хүнийг хүрээлэн байгаа бичил орчин нь тааламжтай, тав тухтай, элбэг хангалуун, аз жаргалтай бол тухайн хувь хүн гэмт хэрэг үйлдэх магадлал эрс буурдаг. Харин эсрэгээр хүрээлэн буй орчин нь тааламжгүй, байнгын дутагдал, гачигдал,

<sup>26</sup> Н.Жанцан. “Криминологи” УБ. 2003 он. 71 дэх тал

өлсгөлөн, зовлонтой орчинд амьдардаг хүмүүс нь нийгэмд харш зан төлөвтэй бол тухайн хувь хүн гэмт хэрэг үйлдэх магадлал бараг 90 хувьтай байна. Тухайлбал: өнөөдөр траншейнд амьдарч байгаа хүмүүсийн бараг бүгд гэмт хэргийн замаар амьдардаг. Эрэгтэйчүүл нь хулгай, дээрэм хийдэг. Эмэгтэйчүүд нь биеэ үнэлж хог түүж амьдарч байна. Хэдийгээр хүрээлэн байгаа орчин тааламжгүй байдаг ч гэсэн гэмт хэрэг бүгд үйлдэнэ гэсэн үг биш юм.

Амьдралын тодорхой нөхцөл байдал буюу гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн тохироо гэдэг нь: хувь хүнийг гэмт хэрэг үйлдэхэд хүргэж байгаа орчны хүмүүсийн эвгүй зан харьцаа, доромжлол, мөнгөгүй болох, архидан согтуурах, ар гэрийн гачигдал, санаа сэтгэлийн дарамт зэргийг ойлгож болох бөгөөд нийгэмд харш зан төлөвтэй хүн ийм тохироо бүрдмэгц гэмт хэрэг үйлддэг байна. Олон тохиолдолд хохирогчийн зүй бус зан байдал тухайн хүнийг гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн байдаг бөгөөд угаас догшин, хэрцгий зан авиртай хүнд хохирогчийн ёс бус харьцаа нь гэмт хэрэг үйлдэх сайхан далим, шалтаг болдог.

Тодорхой гэмт хэрэг үйлдэхэд хүний мөн чанар болсон зан төрхийн онцлого чухал үүрэгтэй гэж барууны судлаачид баталдаг. Өөрөөр хэлбэл хувь хүний шунал, тачаал, уур уцаар, атаа чөтөө, атаархал, өс хонзон санамтгай байдал, уур хилэн зэрэг нь гэмт хэрэг үйлдэхэд нилээд түлхэц болдог.

Аливаа гэмт хэрэгтэй тэмцэх төрийн үйл ажиллагааны онцлог нь тухайн орны хөгжлийн түвшин, зан заншил уламжалт онцлогт тохирсон төрийн бие даасан бодлогын хүрээнд илэрдэг.

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн асуудлыг бүрэн зөв тодорхойлсноор уг гэмт хэргээс бүрэн дүүрэн урьдчилан сэргийлж чадахгүй. Ийм учраас бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн үйлдэгдээд байгаа шалгаан, нөхцөл уг гэмт хэргийг үйлдэж буй бие хүний тухай асуудлыг авч үзэх шаардлагатай. Мөн уг асуудлыг практикт хэрхэн шийдвэрлэж байгаа, ямар хүндрэлтэй тал байгаа болохыг тогтох нь нэн чухал юм.

Миний судалгаа хийсэн Дорноговь аймгийн Сум дундын 1-р шүүх, Сум дундын 2-р шүүхийн 2000 оноос 2007 он хүртэл дээрмийн гэмт хэргийн дэлгэрэнгүй судалгаа, Сонгинохайрхан дүүргийн шүүхийн 2004 оноос 2006 он хүртэл дэлгэрэнгүй судалгаа, Чнгэлтэй, Баянгол, Сүхбаатар, Хан-Уул, Баянзүрх дүүргийн шүүхийн 2004 оноос 2006 он хүртэл хийсэн судалгаагаар дээрмийн гэмт хэргийн 95 гаруй хувь нь хот, суурин

газарт үйлдэгдэж байгаа бөгөөд ихэвчлэн гудамж талбай, орц, такси, вокзал хүний хөлнөөс зайдуу харанхуй / гэрэлтүүлэггүй/ газарт орой, үдшийн цагаар гарч байна. Дээрмийн довтолгооны ихэнх нь хохирогчид халдаж зодсон, заналхийлсэн, сэтгэл санааны дарамтанд оруулсан, зэвсэг хэрэглэсэн гэх мэт үйдэлээр илэрч байна.

**Дээрмийн гэмт хэрэг үйлдэгсэн этгээдүүдийн нас:**

Судалгаанд хамрагдсан 585 хүнээс насанд хүрээгүй 71 хүүхэд.

18-35 хүртэлх насны хүн 456 хүн.

35 дээш насны хүн 23 хүн байна.

90 гаруй хувь нь 14-35 хүртэлх насны эрэгтэй хүмүүс үйлдэж байна.

**Дээрмийн гэмт хэрэг үйлдэгсэн этгээдүүдийн хүйс:**

Эмэгтэй 54

Эрэгтэй 531 хүн байна.

Энэ тоон үзүүлэлтийг харахад маш харуусалтай байна. Монгол Улсын маань ирээдүй болсон залуучууд торны цаана амьдралынхаа залуу насыг өгөрүүлж байна. Эдгээр хүмүүсээс хэд нь засран хүмүүжиж хэд нь гэмт хэргтний замаар замнах бол.

**Дээрмийн гэмт хэрэг үйлдэгсэн этгээдүүдийн боловсрол:**

Боловсролгүй 32 хүн.

Бага боловсролтой 100 хүн

Дээд боловсролтой 12 хүн

Үлдсэн 441 хүн нь бүрэн бус дунд, тусгай дунд, бүрэн дунд боловсролтой хүмүүс байна.

**Дээрмийн гэмт хэрэг үйлдэгсэн этгээдүүдийн урьд нь ял шийтгүүлсэн байдал:** эдгээр хүмүүсийн 80 гаруй хувь нь өмнө нь ял шийтгүүлж байгаагүй буюу анх удаагаа гэмт хэрэг үйлдсэн байна. Үлдэх 20 хувь нь ял шийтгүүлж байсан байна.

Дээрмийн гэмт хэргийг ихэндээ согтуугаар үйлдэж байгаа бөгөөд энэ гэмт хэргийн хохирогч нь согтуу байхдаа халдалгад өртсөн тохиолдол их байна. Дээрмийн гэмт хэрэг үйлдэгчдийн олонх нь боловсролын түвшин доогуур , 30 орчим хувь нь боловсролгүй, бага боловсролтой хүн байна.

Дээрмийн гэмт хэрэг үйлдэгчдийн ихэнх нь эрхэлсэн тодорхой ажилгүй, хөнгөн хялбар амьдрахыг хүсэгчид бэртэгчин хүмүүс байна. Тэдний 80 гаруй хувь нь ажил хөдөлмөр эрхэлдэггүй, согтууруулах ундаа хэрэглэдэг ба дээрмийн гэмт хэргийн 80 гаруй хувь нь согтуугаар үйлдэгдэж байна.

Дээрхи судалгаанаас дүгнэн үзвэл дээрмийн гэмт хэргийн шалтгаан нөхцөл нь

### **1. Ажилгүйдэл:**

Ажилгүйдэл нь ямарч нийгмийн байгууллын үед бодитойгоор байдаг үзэгдэл бөгөөд зах зээлийн нийгэмд хөдөлмөрлөх нь хувь хүний эрх бөгөөд өөрийн мэдлэг чадвао, авъяас, хүсэл сонирхол, мэргэжил болон өөрийнхөө боломжийн хэрээр ажил хөдөлмөр эрхэлдэг. Өнөөдөр гагцхүү манай оронд бус дэлхий даяар ажилгүйдэл ихсэж ч байна. Манай оронд ажил идвэхтэй хайж байгаа хөдөлмөрийн захад бүртгүүлсэн хүний тоо 32000 хүсэн байна. Гэхдээ бодит байдал дээр дээрхи тоог 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний хүмүүс ажилгүй байна.<sup>27</sup>

Ажилгүйдэл яагаад гэмт хэрэг үйлдэгдэх аятай, таатай суурь үндэс нөхцөл болдог бэ?. Ажил хөдөлмөр бол хувь хүний амьжиргаагаа залгуулах гол арга хэрэгсэл болдог бөгөөд ажилгүй хүн бол орлогогүй, амьжиргаа муу байх нь зүй ёсны хэрэг. Нэгэнт амьжиргааны түвшин дорой, чадан ядан амьдарч байгаа тохиолдолд гэр бүлийн зөрчил улам бүр хурцдах болно. Өнөө маргаашийн хоол, хүүхдийн боловсрол, бусад хүмүүсийн өмссөн зүүсэнтэй өөрсдийгөө харьцуулан сэтгэл байнга тавгүй явах болно. Түүнчлэн гэртээ байнга сууснаар хүмүүстэй харьцах харьцаа, нийгэмд ашигтай хэлхээ холбоо нь суларч нийгмийн баялагаас хүртэх хувь хэмжээ улам бүр багасна.

Ажилгүй хүнд өдөр, хоног удаан өнгөрч уйдахын эрхэнд болохгүй, бүтэхгүй хүмүүстэй нийлж тэнэх, архидан согтууран гэмт хэрэг үйлдэхэд хүрдэг. Мэдээж ажилгүй байгаа бүх хүмүүс гэмт хэрэг үйлдэхгүй нь тодорхой бөгөөд ажилгүйдэл нь зөвхөн гэмт хэрэг үйлдэгдэх шалтаг нөхцөл болдог. Өөрөө хэлбэл тухайн хүн нийгэмд харш зан төлөв гүнзгийрээгүй, хуулийг дагаж биелүүлдэг бол ажилгүй байх нь гэмт хэрэг үйлдэх шалтаг болохгүй, харин ч ажил идэвхитэй хайх, өөрийгөө боловсруулах сурах зэргээр цагийг өнгөрөөж ажилтай болох цагаа тэвчээртэй хүлээж улмаар үр дүнд хүрэн ажилтай болдог.

Энд тэмдэглэхэд ажилгүй байгаа хүмүүсийн олонхи нь мэргэжилгүй, мэргэжилтэй ч түүндээ эзэн болоогүй, авъяас чадваргүй, ажиллах, сурах эрмэлзлэл муутай, ажлаас зугтдаг болох нь ажиглагддаг бөгөөд ажилгүй байх гол шалтгаан тэдэнд өөрсдөд нь байдаг. Тэд ажилгүй, мөнгөгүй байгаа шалтгаанаа өөрөөсөө

<sup>27</sup> Ц.Цэлмэг Криминологи УБ. 2005 он 66 дахь тал

хайхын оронд төр засаг, хууль тогтоомж, нийгмийн шударга бус явдлаас хайж гомдоллодог.

Монгол улсад ажилгүйчүүдийн тоо маш их байна. Энэ нь ажлын байр олдохгүй байгаа бус одоогийн залуус ажлын байр, цалин хөлсөө голж байгаатай холбоотой юм. Мөн ямарч үр дүнгүйгээр дээд сургуульд орж суралцан төгсөөд тухайн чиглэлээр ажиллах ажлын байр олдохгүй байна. Нийт дээрмийн гэмт хэрэг үйлдэгсэдийн 90 гаруй хувь нь ямар нэгэн эрхэлсэн тодорхой ажилгүй байна.

## **2. Архидан согтуурал:**

Гэмт хэргийн гаралтанд архидан согтуурлын нөлөөний тухай асуудал нь анхаарах хамгийн чухал тулгамдсан асуудал болоод байна.

Согтуурал нь олон зууны турш хүн төрөлхтөнд хортой нөлөөгөө үзүүлснээр ирсэн бөгөөд манай улс зах зээлийн харилцаанд шилжсэн үеэс улам бүр газар авах болсон. Согтуурал нь гэмт явдлын нийгэм, сэтгэл зүйн шалтгааныг дэмжиж түлхэц өгч байдаг бөгөөд энэ нь нийгэмд харш зан ааш гаргах бодит нөхцөл байдлуудыг бүрдүүлэн хүнийг гэмт хэрэгт түлхэн оруулдаг.

Архидан согтуурал нь хүний нийгэм, хамт олон, гэр бүлийн харьцаанд сөргөөр нөлөөлж зөрчилтэй байдлыг бий болгодог бөгөөд хувь хүнийг эцэстээ хэнд ч хэрэггүй нийгмийн хог шаар болгодог.

Согтуурал нь хүний мэдрэлийн системийн ажиллагаа, сэтгэхүйн хэвийн байдлыг алдагдуулж, гадаад орчны нөлөөнд хэт цоцромтгой хандаж зэрлэг, бүдүүлэг аашлах, хүнлэг ёс, иргэний үүрэг, хууль болон тогтоосон журмыг хүндлэхгүйд хүргэдэг. “Архи шилнээсээ бусдыг дийлдэг” гэсэн ардын маань сургааль хүртэл бий.

Архичид согтууруулах ундааг уухаа амьдралын зорилгоо болгож архины мөнгө олохын тулд гэмт хэрэг үйлдэхээс буцахгүй байдалд орох нь цөөнгүй. Энэ нь харгис хэрцгий, бүдүүлэг авирлах шалтгаан болж улмаар хүч хэрэглсэн гэмт хэрэг үйлдэхэд хүргэдэг.<sup>28</sup> Архи уух нь тухайн хүний зан төлөвтэй ямар нэгэн хэмжээгээр холбоотой бөгөөд эрүүл ухаанаар өөрийгөө барьж байсан тэвчээрийн ухааныг нь тасалсанаар уг хүний мөн чанар илэрдэг. Өөрөөр хэлбэл архи руу бүх буруугаа чихэж байгаа

<sup>28</sup> Ц.Цэлмэг Криминологи УБ. 2005 он 67 дахь тал



этгээдэд итгэх хэрэггүй бөгөөд тэр этгээд нийгэмд харш зан төлөвтэй, танхай балмад зан ааштай, гагцхүү түүнийгээ нууж явдаг нь архины нөлөөгөөр илэрч байга юм.

Согтуурал нь нэг талаар гэмт хэрэг үйлдэх гэсэн санаа бодлыг бусдад төрүүлдэг, хүний үзэл бодол, оюун сэтгэхүйд байгаа нийгэмд харш санаа бодол нь хэрэгжин биелэх нөхцлийг бүрдүүлдэг. Тэр ялангуяа дээрмийн гэмт хэрэг үйлдэгсэдийн ихэнх хувь нь согтууруулах ундааны зүйлийг хэрэглэсэн байна. Мөн энэ гэмт хэргийн хохирогчид нь мөн л согтууруулах ундаа хэрэглэсэн судалгаа гарч байна.

Одоогийн залуус чөлөөт цагаа зохистой өнгөрүүлэх бус баар, цэнгээний газарт архи, согтууруулах ундааг хэт их хэрэглэн өөрийгөө жолоодох чадваргүй болж гэмт хэрэгтэн эсвэл хохирогч болж байна. Жил ирэх бүр архидалт улам залуужиж байна.

Ялангуяа сүүлийн үед хүүхэд, эмэгтэйчүүд ихээр архидан согтуурах болж улмаар гэмт хэрэг, зөрчилд холбогдох болсон нь сэтгэл эмзэглүүштэй.<sup>29</sup> Манай улс нэг хүнд ноогдох спирт, архины хэмжээгээр дэлхийд тэргүүлэгчдийн эгнээнд орж 1 хүнд жилд 10 литр архи ноогдож байгаа. Хэрвээ архи уудаггүй, бага зэрэг уудаг хүмүүсийг хасаад тооцвол насанд хүрсэн нэг хүнд 22 литр буюу 44 шил архи ноогдож байна.

Энэ тоон дээр нэрмэл архи, пиво, дарс зэргийг нэмэгдүүлбэл ямар тоо гарах бол. Үүнээс болж гэмт хэрэг үйлдэх хүмүүсийн тоо өсөн нэмэгдсээр байна. Ганц дээрмийн гэмт хэрэг дээр бус бусад бүх төрлийг гэмт хэргийг үйлдэхдээ архидан согтуурсан байдал ихээр гарч байна. Манай залуучууд чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлэх газар байхгүй байна. Мөн шоудаж байгаа нь энэ гээд хэтэрлээ архи, согтууруулах ундаа хэрэглэж байгаа нь харамсалтай зүйл. Монголд бараг бүх 8 нэрийн барааны дэлгүүрт архи зарж байна. Чанартай, чанаргүй маш олон төрлийн архийг үйлдвэрлэлийн болон үйлдвэрлэлийн бус нөхцөлд үйлдвэрлэн зах зээлд худалдаалж байна. Монгол улс архидалтаас нийгмээ цэвэрлэж чадахгүй бол хөгжин дэвшилтэд муугаар нөлөөлж, гэмт хэргийн тоо өссөөр байх болно.

Монгол Улсын Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль амьдралд огт үйлчлэхгүй байна.

<sup>29</sup> Цагдаагийн академи “Гэмт явдалтай тэмцэх асуудал” УБ. 2005 он

### 3. Тэнүүчлэл:

Манай орон зах зээлийн харилцаанд шилжин орсон 1990 оноос эхлэн орон, гэргүй хүмүүсийн асуудал хурцаар тавигдаж эхэлсэн. Урьд нь социалист нийгмийн үед орон, гэргүй тэнүүлчин хүмүүс мэр сэр байсан боловч хаалттай нийгэм тэр бүхнийг нуун дарагдуулж чаддаг байсан.

Өнөөдөр албан ёсны мэдээгээр 3500 хүүхэд болон насанд хүрэгсэд орон гэргүй тэнүүчилж байгаа гэдэг боловч бодит байдал дээрээ тэнүүчдийн тоо 10000 гаруй байгаа гэсэн судалгааны дүн бидэнд байна. Орон гэр бол хүний амьдралын наад захын шаардлага бөгөөд орон гэргүй байна гэдэг бол сурч боловсрох, ажил хөдөлмөр эрхлэх, нийгмийн бусад эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болдог.

Төр, нийгмийн бүхий л үйлчилгээ нутаг дэвсгэрийн харъяалалаар буюу оршин суугаа газраар дамжин хүрдэг байхад тэнүүлчид хүн амын тооллогод л алдаг оног хамрагддаг билээ.

Хэрхэн амь амь зуулгаа залгуулдаг талаар ярилцахад 60 хувь нь хог түүдэг, бусад нь хулгай, дээрмийн замаар мөн гуйлга гуйх аргаар амьдардаг гэжээ.<sup>30</sup> Тэдгээр хүүхдүүдээс ямар нэгэн байдлаар гэмт хэрэг хийсэн талаар асуухад 76 хувь нь тийм, 34 хувь нь тэр л аргаар байнга амьдарч байдаг гэсэн байна.

Энэ бүхнээс үзэхэд орон гэргүй хүмүүст нийгмийн харш зан төлөв гүнзгийрэн тогтсон., хууль зөрчихийг юманд бодохоо больсон, гэмт хэргийн замаар амьдардаг, нийгэм болон чинээлэг хүмүүсийг үзэн яддаг, өөрийгөө гэмт хэрэг үйлдэж байна гэж боддоггүй, ял шийтгэлээс айхаа больсон зэрэг шинжтэй байна.

### 4. Ядуурал:

Гэмт хэрэг үйлдэхэд суурь нөхцөл болдог. Өнөөдөр манай нийгэм баян, чинээлэг, дунд, ядуу, нэн ядуу гэсэн 5 хэсэгт хуваагдаж байгаа бөгөөд хүн амын 3 хүрэхгүй хувь нь дээд буюу баян чинээлэг хэсэгт хамрагдаж байна. Харин нэн ядуу хэсэгт 38 хувь нь хамрагдаж байгаа. 20 хувь нь дунд хэсэгт, үлдэх 35 хувь ядуу амьдарч байна.<sup>31</sup> Манай орон ядуучуудын тоо жил ирэх тусам нэмэгдэж байна. Хүн амын орлого өдрөөс өдөрт хомосдож, цөөн зарим нь өдрөөс өдөрт баяжиж юмны үнэ тэнгэрт хадаж байгаа цаг үед бид амьдарч байна. Төсвийн байгууллагын ажилдын

<sup>30</sup> Ц.Цэлмэг Криминологи УБ. 2005 он 69 дахь тал

<sup>31</sup> Цагдаагийн академи “Гэмт явдалтай тэмцэх асуудал” УБ. 2005 он 38 дахь тал

цалинг 30 хувиар өсгөсөн. Гэвч юмны үнэ дагаад л өссөн. Тэгээд дүндээ дүн болсон. Харин өдөрт 3000-5000 төгрөг өөрсдийн хөдөлмөрөөр олж авдаг хүмүүст улам муугаар нөлөөлж амьдралаа залгуулах чадваргүй болгож байна.

Ядуу амьдарч байгаа хүмүүс боловсрол, мэргэжил олж авах нөхцөл муутай, хүрээлэн байгаа орчин нь таагүй, нийгмийн баялагаас тун өчүүхэн хувийг хүртдэг учир оюун ухааны ядууралд ч нэрвэгдсэн байдаг. Тэдний хууль эрх зүйн мэдлэг дорой, ухамсар муу, гэмт хэрэг үйлдэхээс төдийлөн эмээхгүй, амьдрахын тулд яахаас ч буцахгүй шинжтэй. Мэдээж бүх ядуу хүмүүс нийгэмд харш зан төлөвтэй гэмт хэрэг үйлдэхэд бэлэн гэсэн хэрэг биш бөгөөд ядуурал нь гагцхүү гэмт хэрэг үйлдэх шалтгаан нөхцөл болж байна.

Монгол улсын 5-н өрх бүрийн 3 нь нэн ядуу өрхөд хамрагдаж байна. Энэ манай нийгмийн хамгийн том дутагдал юм. Ядуурал манай нийгмээс арилаагүй тохиолдолд гэмт хэргийн тоо багасахгүй.

#### **5. Боловсрол, мэргэжил:**

Уг гэмт хэргийг үйлдэж байгаа нийт хүмүүсийн боловсролгүй, бага, бүрэн бус дунд, тусгай дунд боловсролтой хүмүүс 80 гаруй хувийг эзэлж байна. Өөрөө хэлбэл дээд боловсролтой хүн уг гэмт хэргийг бараг үйлдэхгүй буюу 5 гаруй хувийг эзэлж байна. Монгол ардын сургаальд эрдэмтэй хүн даруу их мөрөн дөлгөөн гэдэг үг бий.

#### **6. Эцэг, эх болон сурган хүмүүлэгч, цагдаагийн байгууллагын хараа хяналтгүй байдал.**

Эцэг эх нь хүүхдээ сургуульдаа явж байгаа эсэх орой үдшийн цагаар хаагуур хэнтэй явж байгаа болон болох болохгүй хүнтэй нийлж байгааг анхаарахгүй байна. Сурган хүмүүжүүлэгч багш нар нь хүүхдүүдийн сурлага болон хичээлийн идвэхийн талаар анхаарал тавихгүй байна. Цагдаагийн байгууллага нь тэнсэн хянан харгалзаж буй хүмүүст бүрэн гүйцэт хараа хяналт тавьж ажиллахгүй байна. Үүнээс болж дахин гэмт хэрэг үйлдэх явдал тасрахгүй гарч байна.

#### **7. Хохирогчийн гэм буруу:**

Дээрмийн гэмт хэргийн гарахад хохирогчийн буруу маш их байна. Хохирогч нь архи болон согтууруулах ундаа ихээр хэрэглэсэн буюу өөрийгөө удирдан жолоодох чадваргүй үедээ гудамж талбайгаар ганцаараа явах, олон хүний газар их хэмжээний

мөнгө болон гар утас, үнэт эдлэлүүдийг гаргах, хэтэрхий оройн цагаар ганцаараа харанхуй гудамж талбайгаар явах нь энэ гэмт хэргийн хохирогч болж байна.

Дээрхи нөхцөл байдлууд нь дээрмийн гэмт хэрэг гарах гол үндсэн нөхцөлүүд болж байна.

Сүүлийн жилүүдэд манай улсад иргэдийн шилжилт хөдөлгөөн, хүн амын ядуурал, ажилгүйдэл, хот хөдөөгийн ялгаа, амьжиргааны тэгш бус байдал, иргэдийн боловсрол, мэргэжил, нас, хүйс, хохирогчийн гэм буруу зэрэг нь бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг үйлдэхэд ихээр нөлөөлж байна. Хууль тогтоогч Эрүүгийн хуулийн тусгай ангийн 147 дугаар зүйлд бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийг хуульчилсан байна. Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг гэдэг нь шунахай сэдэлттэйгээр бусдын өмчийн эд хөрөнгийг хууль бусаар хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх аргаар авч өөрийн өмчийн нэгэн адил захиран зарцуулах боломж бүрдүүлэхийг хэлнэ. Энэ гэмт хэрэг нь бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэн авахаас гадна иргэдийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж буй хүнд гэмт хэрэг юм.

## **2.2 Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга зам.**

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга зам нь криминологийн шинжлэх ухааны авч үзэх шаардлагатай юм.

Криминологийн шинжлэх ухааны гол зорилт бол гэмт явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулахад оршдог бөгөөд сүүлийн үед ном, сурах бичгүүдэд гэмт явдлаас урьдчилан сэргийлэх, гэмт явдалтай тэмцэх, гэмт хэргийг таслан зогсоох, хяналт тавих, эсрэг зогсох зэрэг олон нэр томъёо хэрэглэж байна.

Энэ талаар хууль зүйн ухааны доктор Н.Жанцан.....гэмт явдалтай тэмцэх арга хэмжээний хүрээнд гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн байцаах, шүүн таслах, ял эдлүүлэх болон энэ бүх ажиллагаанд хяналт тавих түүнчлэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ багтан ордог.<sup>32</sup>

<sup>32</sup> Н.Жанцан Криминологи. 2004 он 88-р тал

Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ бол “тэмцэх” ажиллагааны үндсэн чиглэл, баримтлах гол шугам болдог.

Гэмт хэрэгтэй тэмцэх гэж гэмт хэргийн гаралтыг багасгах, нийгмийн хор аюулыг бууруулах, шалтгаан нөхцлийг арилгах буюу саармагжуулах зэрэг нарийн зохион байгуулалт бүхий, системтэй үйл ажиллагаануудын цогцыг ойлгоно.

Харин гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гэж гэмт явдлын гаралтыг хорогдуулах, түүнийг төрүүлдэг шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн төр, олон нийтийн байгууллага, иргэдээс зохион явуулж байгаа үйл ажиллагааны системийг ойлгож болно.

Хүн төрөлхтөн гэмт хэрэг үйлдсэн этгээдийг зөвхөн цээрлүүлэх бус түүнээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хүмүүжүүлэх төлөвшүүлэх олон янзын үзэл санааг боловсруулж байсан нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх онолыг бий болгосон гэж үздэг.

Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх онол гэж тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг илрүүлэхэд нийгмийн харилцааг чиглүүлэх, төгөлдөржүүлэх, гэмт явдлын гаралт, байдалд хяналт тавих үйл ажиллагааны арга хэлбэр, мэдлэгийн нийлбэр цогц юм.

Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг өргөн утгаар нь авч үзвэл нийгмийн бүхий л хөгжил дэвшил, түүний эдийн засаг, үзэл суртал, соёл, техникийн цогц арга хэмжээний үр дүнд нийгмийн харилцааг боловсронгуй болгож, аж төрөх ёсыг хэвшүүлэн тогтоосноор хангагдах үйл ажиллагаа юм.

Явцуу утгаараа гэмт хэргийн тухай мэдээ, мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг үйлдэгдэж байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар авч хэрэгжүүлж байгаа цогцолбор арга хэмжээ мөн.

Гэмт явдал нь нийгмийн үзэгдэл болохыг хувь нийгмийн амьдралын янз бүрийн хүрээ түвшинд оршиж байгаа өөртөө нөлөөлөх шалтгаан, нөхцөлүүдтэй нягт холбоотой байна.

Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд нь эдгээр шалтгаан нөхцөл бүрт нөлөөлж чадахуйцаар зохион байгуулагдах учиртай. Гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилт аяндаа хэрэгжихгүй, харин урт удаан хугацаанд нэр их хүч хөдөлмөр шаарддаг үйл явц бөгөөд нийгэм, төрийн зүгээс

чиглэсэн зорилготой, системтэй, байнгын тасралтгүй иж бүрэн арга хэмжээ авч байхыг шаарддаг.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаа бол өргөн хүрээтэй, иж бүрэн, олон талтай, нарийн төвөгтэй үйл ажиллагаа юм.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гэж гэмт хэргийн гаралтыг бууруулах, хорогдуулах, түүний шалтгаан нөхцөлийг илрүүлэн арилгахад чиглэсэн нийгэм, төр, төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, иргэдээс явуулж байгаа үйл ажиллагааны системийг хэлнэ.

Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажил нь Монгол Улсын Үндсэн хууль, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад хууль, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актуудаар зохицуулагдана.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохицуулж байгаа субъектуудын үйл ажиллагаа нь гэмт явдалд нөлөөлж байгаа объектив, субъектив нөхцөл байдлуудыг судлан илрүүлж арилгах, таслан зогсооход оршидог. Үүний тулд субъектууд криминологийн мэдээллийг солилцох, хамтарсан дүн шинжилгээ хийх, цаашид зохиох ажлын чиг баримжааг тогтоох нь чухал ач холбогдолтой. Ийм нэгдмэл систем бий болгох явдал орчин үед чухлаар шаардагдаж байна.

Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэл нь

1.Гэмт явдлын талаархи мэдээллийг цуглуулж, түүнд судалгаа шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг бодитойгоор тогтоох.

2.Гэмт явдлын шалтгаан нөхцөлийг арилгах нийгэм, эдийн засаг, эрх зүйн арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх.

3.Давтан гэмт явдал үйлдэхээс сэргийлэх зорилгоор хорих ял эдлээд суллагдсан хүмүүст гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуулийн дагуу захиргааны хяналт тогтоох.

4.Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажилд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр татан оролцуулах.

5.Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбогдсон хууль тогтоомж, хэм хэмжээг иргэдэд мэдээлэх, сурталчлах, сургалт зохион байгуулах явдал юм.

Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг төвшингөөр нь нийгмийн нийтлэг ба криминологийн тусгай арга хэмжээ гэж ангилна.

Нийгмийн нийтлэг урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь нийгмийн тогтвортой хөгжил, түүний эдийн засаг, улс төр, нийгмийн амьдралын хэвийн үйл ажиллагааг хангах, ард иргэдийн амьжиргааг сайжруулах, ухамсар, боловсрол, соёлыг нь дээшлүүлэх, ядуурлыг бууруулах зэрэг үйл ажиллагаа хамаарна. Эдгээр арга хэмжээ нь шууд гэмт явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэхэд чиглэгдээгүй боловч нийгмийн үзэгдлийн хувиар оршин тогтнож байгаа гэмт явдлын төвшинг бууруулах, шалтгаан нөхцлийг илрүүлэн арилгах, даван туулах боломжийг бүрдүүлнэ. Нийтлэг арга хэмжээ нь нийгмийн амьдралын удаан хугацааны шинжтэй томоохон төслүүдийг хамааруулдаг. Тухайлбал: үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, инфляцийг багасгах, үндэсний банк, санхүүгийн систем болон үндэсний валютыг бэхжүүлэх зэрэг арга хэмжээнүүд хамаардаг.

Тусгай арга хэмжээний хүрээнд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг илрүүлэх, мөрдөн байцаах, ял шийтгэл оногдуулах, засан хүмүүжүүлэх зэрэг үйл ажиллагаатай холбогдон гарч ирсэн гэмт явдалтай явуулах эрүүгийн эрх зүйн тэмцэл чухал байр суурьтай.

Криминологийн урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээг түүний эзлэх байр, цар хүрээ, хэмжээгээр нь

- Бүх улс орны хэмжээний
- Бус нутгийн
- Нийгмийн их бага тодорхой бүлгийн
- Нэг бүрчилсэн арга хэмжээ гэж ангилна.

Улс орныг хамарсан урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт тэгш үйлчлэх бөгөөд хүн амын нийтлэг ашиг сонирхлыг гэмт халдлагаас хамгаалах, ажилгүйчүүд, ядуусын амьдралыг дэмжих, ядуурлыг бууруулах зэрэг хэлбэрээр илэрнэ.

Бүс нутгийн хамарсан урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь тухайн засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэрт зохион байгуулагддаг онцлогтой.

Тодорхой бүлгийг хамарсан арга хэмжээ нь үйлдвэр, албан газар, амралтын газар, боловсролын байгууллагуудад хууль зөрчиж болох нөхцөл байдлыг илрүүлэх, арилгах явдал юм.

Нэг бүрчилсэн арга хэмжээ нь гэмт хэрэг үйлдэж болзошгүй тодорхой этгээд, түүний ойрын хүрээнд урьдчилан сэргийлэх нөлөөллийг үзүүлэх зорилготой.

Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг агуулга, шинж байдлаар нь дараах байдлаар ангилна.

- Эдийн засгийн
- Улс төр, үзэл суртлын
- Удирдлага, зохин байгуулалтын
- Эрх зүйн
- Техникийн шинжтэй арга хэмжээ

Эдийн засгийн арга хэмжээнүүдэд нэг хүнд ноогдох үндэсний орлогыг дээшлүүлэх, иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, ядуурлыг бууруулах, орлогыг нэмэгдүүлэх, хөдөлмөрлөх нөхцөл, орон сууцны болон ахуй үйлчилгээний нөхцлийг сайжруулах, татварын дарамтыг бууруулах, зэрэг нийгэм, эдийн засгийн арга хэрэгслийг ашиглах замаар хэрэгжин биелэх асуудлууд хамаарна.

Улс төр, үзэл суртлын арга хэмжээ нь хүмүүнлэг, ардчилсан, эрх зүйт нийгэм байгуулах, нийгмийн харилцааг улам боловсронгуй болгох, нийгмийн ухамсарт нөлөөлж дээшлүүлэх, иргэдийн ухамсар, боловсрол, соёлын түвшинг дээшлүүлэх зэрэг хэлбэрээр илэрнэ.

Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ нь гэмт явдалтай тэмцэхэд төр, нийгэм, аж ахуйн болон олон нийтийн байгууллага, иргэдийн хамтын ажиллагааг уялдуулах, мэдээлэл цуглуулах, шалтгаан нөхцөлийг илрүүлэн арилгах, иргэдийн гэмт хэрэгтэй тэмцэх идэвхижилийг дээшлүүлэх зэрэг болно.

Эрх зүйн арга хэмжээ нь гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, боловсронгуй болгох замаар хэрэгжин биелэх үйл ажиллагаа юм.

Техникийн арга хэмжээ нь гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаанд орчин үеийн техник хэрэгсэл, компьютерийн тусламжтайгаар гүйцэтгэгдэх арга хэмжээнүүд хамаарна. Гэмт хэргийг илрүүлэх мөрдөн байцаах ажиллагаанд орчин үеийн дэвшилтэд техник, компьютерийг өргөнөөр ашиглах, нийт иргэдийн гар хурууны хээг авч хадгалах, татварын тооцоо, бэлэн мөнгөний эргэлтийг аль болох банкны картын системд оруулах нь чухал юм.



Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх үндсэн зарчмууд нь

- 1.Хууль дээдлэх зарчим
- 2.Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх зарчим
- 3.Ардчилсан зарчим
- 4.Шинжлэх ухааны үндэслэлтэй зарчим
- 5.Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд иж бүрнээр болон ялгамжтай хандах зарчим

### **Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг төрөөс удирдан чиглүүлэх нь**

Нийгмийн сөрөг үзэгдэл болох гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг удирдан зохион байгуулах явдал эрх зүйт төрийн бүх шатны байгууллагуудын үйл ажиллагааны үндсэн хэргийн нэг байдаг. Төрийн байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг удирдан зохион байгуулах үндсэн арга хэлбэр нь одоогийн дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжоор

Засгийн газар гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг улсын хэмжээнд хөтөлбөр, төлөвлөгөө гарган батлаж, энэ ажлыг улсын хэмжээнд Монгол Улсын Хууль зүйн дотоод хэргийн сайд, аймаг, нийслэл, орон нутагт Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн даргаар толгойлуулсан орон тооны бус зөвлөл зохицуулдаг. Энэ ажлын талаар тайлан гаргуулж авна. Хөтөлбөр төлөвлөгөөний талаар үр дүнг хэлэлцэн цаашид авах арга хэмжээг хамтран төлөвлөнө. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг зохицуулна. Мөн Гэмт хэрэг түүний шалтгаан нөхцлийн талаар статистик мэдээ солилцож, хамтран дүн шинжилгээ хийж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний чиглэлийг тогтооно.

Орон нутгийн зохицуулах зөвлөлүүд нь мөн энэ жишгийн дагуу харъяалах нутаг дэвсгэр дээрээ үйл ажиллагаагаа явуулна.Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхийн хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар гарсан хууль тогтоомжууд, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт, шалгалт явуулна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зардлыг өөрийн төсвөөс гаргаж өгнө. Орон нутгийн зөвлөл нь хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажиллаж, орон нутагтаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил явуулна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил төрийн бус байгууллагууд туслаж ажиллана..

Цагдаагийн байгууллага нь хууль тогтоомжид зааснаар гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журмыг хамгаалах үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага юм. Цагдаагийн байгууллагын ажиллагааны үндсэн гол хэсэг бол гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх явдал бөгөөд албадынх нь үйл ажиллагаа энэ нэгдмэл зорилгод чиглэгдэж байдаг. Ер нь гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын ихэнхийг цагдаагийн байгууллага явуулдаг. Үүнд:

1.Гэмт хэрэг гарч болох шалтгаан нөхцөлийг судлан урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаг.

2.Нэгэнт үйлдэгдсэн гэмт хэргийг шуурхай илрүүлэн, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаг.

3.Гэмт хэрэг үйлдэж болзошгүй буюу үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа этгээдүүдийн үйл ажиллагааг таслан зогсооход чиглэсэн шаардлагатай арга хэмжээг нэн даруй авдаг.

Мөн цагдаагийн байгууллага нь гэмт хэрэг гаргуулахгүй байх, таслан зогсоох, насанд хүрээгүй хүүхдүүдийг гэмт хэрэг зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг бүх хэлбэрээр зохиож, гэмт хэргийг илрүүлсний дараа түүний шалтгаан нөхцөлд дүгнэлт хийж, арилгах тодорхой арга хэмжээ авна.

Гудамж тайлбай үйлчилгээний газар, нийтийн тээврийн буудал, орон сууц зэрэг олон нийтийн газар нийтээр дагаж мөрдөх хэв журмыг сахиулах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаг.

Шүүх, прокурор, хэрэг бүртгэх байгууллага, мөрдөн байцаагч нь холбогдох хуульд заасны дагуу бичсэн мэдэгдлийнхээ биелэлтэд хяналт тавина.

**Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, аж ахуй нэгж, байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслийн оролцоо**

Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, хуулийн этгээд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар дараахи нийтлэг үүрэг хүлээнэ:

1. Байгууллагынхаа дотоодод болон үйл ажиллагаа явуулж байгаа хүрээндээ гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг арилгах талаар тодорхой арга хэмжээ авах;

2. Ажилтнууддаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийг мэдээлэх, сурталчлах.

3. Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах талаар прокурорын болон бусад эрх бүхий албан тушаалтны мэдэгдэл, зөвлөмжийг хүлээж авсан байгууллага, аж ахуйн нэгж түүний дагуу тодорхой арга хэмжээ авч, хариуг хугацаанд нь өгч байх үүрэгтэй.

**Иргэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар дараахь үүрэг хүлээнэ.**

Бусдын нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироохгүй, нийгмийн хэв журмыг гажуудуулахгүй байх

Оршин суугаа нутаг дэвсгэртээ нийгмийн хэв журам сахиулах талаар нутгийн захиргааны байгууллага, гэмт хэрэгтэй тэмцэх, хэв журам сахиулах байгууллагаас хэрэгжүүлж байгаа зохион байгуулалттай арга хэмжээнд оролцох

Гэмт хэргийн талаар олж мэдсэн зүйлээ холбогдох байгууллагад мэдээлэх.

**Иргэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар дор дурдсан эрх эдэлнэ**

Нийгмийн хэв журам сахихыг бусдаас шаардах

Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд шаардлага тавих

Архидан согтуурч, нийгмийн хэв журмын зөрчил гаргаж байгаа этгээдийг эрүүлжүүлэх байргүй газар амь нас, эрүүл мэндэд нь хохирол учруулахгүйгээр эрүүлжүүлэх, үйлдлийг нь таслан зогсоох арга хэмжээ авах

Гэмт халдлагаас эд хөрөнгө, өөрийн буюу бусдын амь нас, эрүүл мэндийг хуулийн хүрээнд хамгаалах.

Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл нь гэмт хэргийн тухай мэдээлэл хийхдээ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүний шалтгаан нөхцөл, хор холбогдлыг олон түмэнд таниулах, сэрэмжлүүлэхийг гол зорилго болгоно.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоохтой холбогдсон хойшлуулшгүй мэдээллийг эрх бүхий байгууллагын хүсэлтээр яаралтай нийтэлж нэвтрүүлнэ.

Төрийн өмчийнхөөс бусад хэвлэл, мэдээллийн хэрэгслээр яаралтай мэдээлэл нийтэлж нэвтрүүлсний төлбөрийг тухайн байгууллага төлнө.

Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хүчирхийлэл, аллага хядлага, садар самуун, гэмт хэрэг үйлдэхийг өөгшүүлэн сурталчилсан, гэмт хэрэг үйлдэх аргыг нарийвчлан харуулсан нийтлэл, нэвтрүүлэг хийхийг хориглоно.

Шүүхээр гэм буруутай нь нотлогдоогүй байхад хэнийг ч гэм буруутай гэж хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг хориглоно.

### **Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулах**

Нутгийн захиргааны байгууллага харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд гэмт хэрэг, нийгмийн хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулахдаа иргэдийг дараахь хэлбэрээр татан оролцуулна. Үүнд:

- Иргэдийг нийтийн эргүүлд гаргах
- Хэв журмын урамшилтай эргүүл, жижүүрээр томилох
- Нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчаар ажиллуулах.

Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж байгаа болон үйлдсэн тухай мэдээллийг цагдаагийн байгууллага иргэдээс төлбөртэй авч болно. Иргэдээс авсан мэдээлэл үндэслэлтэй болох нь тогтоогдсон тохиолдолд цагдаагийн байгууллага төлбөрийг олгоно. Мэдээллийн үнэлгээг гэмт хэргийн хүнд, хөнгөнөөс хамааран ялгавартайгаар тогтооно. Онц хүнд ба зохион байгуулалттай гэмт хэргийн талаархи мэдээллийн төлбөрийг мэдээлэгчтэй тохиролцон тогтоож болно. Цагдаагийн байгууллага мэдээллийн нууцыг чанд хадгалж, шаардлагатай бол мэдээлэгчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах үүрэгтэй.

Хорих ял эдлээд суллагдсан хүнд захиргааны хяналт тогтоох гэмт хэрэгт 5-аас дээш жил хорих ял эдэлсэн, эсхүл түүнийг давтан үйлдсэн хүн хорих ял эдэлж суллагдсан бол дахин гэмт хэрэг үйлдэх, нийгмийн хэв журам зөрчихөөс нь урьдчилан сэргийлэх зорилгоор захиргааны хяналт тогтооно. Хорих ял эдэлж суллагдаад байнга оршин суух газартаа очсоноос хойш 3 хоногийн дотор цагдаагийн

байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй. Хорих байгууллага хорих ял эдэлж байгаа хүнийг суллагдахаас 30 хоногийн өмнө байнга оршин суух газрын цагдаагийн байгууллагад түүний суллагдах тухай мэдэгдлийг зохих тодорхойлолтын хамт хүргүүлнэ.

Захиргааны хяналтад байгаа хүний үүрэг

Нийгмийн хэв журмыг сахих, сард 1 удаа цагдаагийн байгууллагад бүртгүүлэх, цагдаагийн байгууллагаас дуудсан цагт саадгүй ирэх, байнга оршин суугаа газраа өөрчлөх тохиолдолд захиргааны хяналт тавьж байгаа цагдаагийн байгууллагад мэдэгдэж шинээр очсон газрынхаа цагдаагийн байгууллагад 3 хоногийн дотор бүртгүүлэх, байнга оршин суугаа газраасаа 14 хоногоос илүү хугацаагаар явах, гадаад улсад зорчих бол цагдаагийн байгууллагад мэдэгдэх, захиргааны хяналт тавьж байгаа цагдаагийн байгууллагын шаардлагыг биелүүлэх.

Энэ үйл ажиллагаанууд нь огт биелэгдэхгүй байна. Цагдаагийн байгууллага нь эдгээр хүмүүст хяналтыг сайн тавьж чадахгүй байна. Үүнээс болж гэмт хэрэг үйлдсэн этгээд дахин гэмт хэрэг үйлдэж байна. Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд нийгэмд гараад ажлын байр олдохгүй, гэр бүлийн хүрээ сул, хамт олон байхгүй, дахин гэмт хэрэг үйлдэж болохгүй талаар анхааруулга, зөвөлгөө өгөх хүнгүй байгаагаас болж эдгээр хүмүүс нь дахин гэмт хэрэг үйлдэж байна.

Архидан согтууралтын багасгах. Манай нийгэмд архидан согтуурах явдал нь хэрээс хэтэрч байна. Дээрмийн гэмт хэрэг үйлдэгсэдийн 70 гаруй хувь нь согтуугаар үйлдсэн байна. Төр архидан согтуурахтай тэмцэх тусгай төсөл боловсруулж нийгмийг архидалтаас цэвэрлэх ёстой гэж бодож байна. Төр архины үйлдвэрлэлийг хяналтандаа авах, архины үнийг өсгөх, архи үйлдвэрлэдэг үйлдвэрүүдийн тоог цөөрүүлэх, үйлдвэрийн бус аргаар архи үйлдвэрлэгчдийн үйл ажиллагааг таслан зогсоох. Сарын аль нэг 3-5 өдрийг бүх нийтээр архигүй өдөр болгож бүх дэлгүүр, баар, цэнгээний газрыг архиар үйлчлэхгүй болгох, архины хатуулаг буюу градусыг багасгах хэрэгтэй. Засгийн газраас 2004 оноос хойш архидан согтуурахтай тэмцэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлж байгаа боловч үүний нөлөө амьдралд мэдэгдэхгүй байна.

Согтууруулах ундааны үйлдвэрлэлийг хүүхдийн цэцэрлэг, бүх шатны сургууль, эмнэлэг, оюутан, сурагчдын хичээлийн болон нийтийн байр, орон сууц, түүний орц, хонгилд явуулахыг хориглоно гэж заасан байдаг боловч бараг л эдгээр газрын үүдэнд тулган үйлдвэрлэл явуулж байна.

Согтууруулах ундааг импортлох, экспортлох, реэкспортлохдоо зөвхөн гаалийн төв байгууллагаас нэр заан тогтоосон боомтоор улсын хилээр нэвтрүүлнэ гэдэг боловч Монгол Улсад урьд хөршөөс нууцаар маш их тооны спирт болон согтууруулах ундаа орж ирж байна.

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоо, төрлийн талаарх нормативыг тухайн орон нутгийн хүн амын тоо, үйлчилгээний хүрээ, эрүүл мэнд, соёлын байгууллага, оюутан, сурагчдын хичээлийн болон нийтийн байрны байршлыг харгалзан худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно. Гэвч энэ нь амьдралд бас л нийцэхгүй байна. Учир нь согтууруулах ундаа худалдаг болон түүгээр үйлчилдэг газрууд нь 5-н алхамын зайтай байна.

Согтууруулах ундаа үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, борлуулах, худалдах, түүгээр үйлчлэх ажилд 18 нас хүрээгүй хүн авч ажиллуулж болохгүй. Насанд хүрээгүй, эсхүл согтуу хүнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхгүй байх. Хүмүүс өөрийн ашиг орлогыг бодон эдгээр нь огт хамаагүй болжээ.

Архидан согтуурахтай тэмцэх, түүний хор уршгийг олон нийтэд ойлгуулан таниулах талаар төрийн захиргааны төв болон орон нутгийн захиргааны байгууллага, эрүүл мэнд, хэвлэл мэдээлэл, соёл, боловсролын байгууллага бүх төрлийн сурталчилгаа явуулах үүрэгтэй.

Согтууруулах ундаа болон согтууруулах ундааны үйлдвэрийн нэр, тэмдэг, зураг ашиглах замаар согтууруулах ундааг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, кино, интернэт, ханын самбар, зурагт хуудас, зар чимэглэл, зорчигчийн тийз болон бусад биет байдлаар гаргахыг хориглодог боловч эдгээр нь огт биелэгдэхгүй, нууц далд аргаар сурталчилгааг хийсээр байна.

Согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээний талаар төрөл бүрийн сугалаа, хонжвор, аливаа хэлбэрийн урамшуулалт худалдаа явуулахыг хориглодог боловч энэ нь зөрчигдсөөр л байна.

Аж ахуйн нэгж, байгууллагыг 200000-250000 төгрөгөөр торгож, уул согтууруулах ундаа болон хууль бусаар олсон орлогыг хурааж, согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, иргэнийг 35000-50000, аж ахуйн нэгж, байгууллагыг 150000-250000 төгрөгөөр торгож, уул согтууруулах ундаа болон

хууль бусаар олсон орлогыг хурааж, согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээг одоо явч байна. Үүнийг өөрчлөх цаг нэгэн болсон байна. Аж ахуй нэгж байгууллагыг 1000000-10000000 төгрөгөөр торгож, уул согтууруулах ундаа болон хууль бусаар олсон орлогыг хурааж, согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, иргэнийг 100000-1000000 төгрөгөөр торгох, аж ахуйн нэгж, байгууллагыг 1000000-5000000 төгрөгөөр торгож, уул согтууруулах ундаа болон хууль бусаар олсон орлогыг хурааж, согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авах ёстой гэж бодож байна. Одоо авч байгаа арга хэмжээний санкц нь үнэхээр бага байна. Торгуулиа төлөөд л дахин зөрчил гаргасаар байна.

Эрүүгийн хуулийн 147 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан оногдуулах ял буюу санкц таван жилээс дээш найман жил хүртэл гэсэн нь хүнд гэмт хэрэг болно. Уг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял оногдуулахдаа гэмт хэрэг үйлдэх болсон шалтгаан, хохирлын хэр хэмжээ зэргийг харгалзан оногдуулах ялыг багасгах шаардлагатай байна гэж үзэж байна. Хэдийгээр гэмт хэрэгтэй тэмцэхэд шүүхээс оногдуулах ял гол боловч энэ гэмт хэргийг хамгийн доод ял нь чангадаж байна гэж үзэж байна. Учир нь энэхүү гэмт хэргийг субъектууд нь 14 наснаас 25 насны хүмүүс өөрийн хайхрамжгүй байдал, эрх зүйн ухамсар дутуу, ар гэрийн байдал, найз нөхдийн хүрээ, орчин тойрноосоо нөлөөлж дээрмийн гэмт хэргийн учир холбогдлыг ойлгохгүйгээр бага хэмжээний эд зүйл, мөнгө төгрөгийг анх удаагаа дээрэмдэн амьдралдаа маш том алдаж байна. Ингэж хэрэгт холбогдсон хүмүүст шууд л хамгийн доод таван жилийн хугацаагаар хорих ял оногдуулах нь маш их дутагдалтай, хүний эрх чөлөөг ноцтой зөрчиж байна. Мөн Үндсэн хуулинд тунхаглан заасан эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно гэсний хүмүүнлэг шинж нь алдагдаж байна гэж үзэж байна. Энэхүү алдааг нь төр хөнгөрүүлж үзэх нь зүйтэй юм.

Үүнийг эрүүгийн хуулинд нэмэлт өөрчлөлт оруулж өөрчлөх шаардлага зүй ёсоор урган гарч байгааг хөндөх нь зүйтэй байна. Өмнөх эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 39-р зүйлд шүүх гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдийн гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн

байдлыг харгалзан үзэж түүнд эрүүгийн хуулийн тусгай ангид заасан ялын доод хэмжээнээс доогуур ял оногдуулах боломжтой байсан. Харин шинэ эрүүгийн хуулинд энэ заалтыг бүр мөсөн хассан. Миний хувьд энэ заалттай утга агуулга ижил зүйл заалт шинэ эрүүгийн хуульд оруулж өгвөл хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, ардчилсан ёсонд тулгуурлан батласан Үндсэн хуулийн үзэл санаанд нийцэх болов уу гэж үзэж байна.

Криминологийн үүднээс доорхи шат дараалсан арга хэмжээг авах нь дээрмийн гэмт хэрэгтэй тэмцэхэд үр дүнтэй арга хэмжээ болно гэж үзэж байна.

Хамгийн эхэнд авах арга хэмжээ бол ерөнхий боловсролын дунд сургуульд эрх зүйн болон гэмт хэргийн талаар тодорхой ойлголттой болгох сургалт нэмэх. Учир нь энэ гэмт хэргийн субъект нь 14 наснаас эхэлдэг. Энэ нь тухайн хүүхдүүдийг гэмт хэрэг гэж юу болох тухайн гэмт хэргийг үйлдснээр ямар хүнд ял авч болох, ийм гэмт хэрэг үйлдэж болохгүй гэдгийг ойлгуулах нь маш чухал байна. Мөн сургалтын хажуугаар гэмт хэргийн талаар хүмүүжлийн ажил зохион байгуулах, уралдаан тэмцээн зохиовол хүүхдүүдэд гэмт хэргийн хор нөлөөг таниулах, нэгнийгээ гэмт хэрэг үйлдэхээс татгалзуулах, гэмт хэрэг үйлдэхгүй байх зэрэг ач холбогдолтой.

Дээрмийн гэмт хэргийн олон нийтэд хүргэх зорилгоор FM, радио, телевизийн сувагуудаар олон нийтэд хамгийн хялбар аргаар ойлгогдохоор нэвтрүүлэг явуулах, эрх зүйн чиглэлээр тогтмол уралдаан тэмцээн явуулах, иргэдэд сэрэмжлүүлэг мэдээлэл явуулах, иргэдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, өөрийн үйлдлээс болж гэмт хэргийн хохирогч болдог болохыг ойлгуулах

Гудамж тайлбайг гэрэлтүүлэгтэй болгох. Хүн багаар явдаг, харанхуй гудамж талбайгаар байнгын цагдаагийн хөдөлгөөнт эргүүлэгтэй болох. Тогтмол маршрут гарган цагдаагийн эргүүлтэй болгох, тухайн баг, хороонд эргүүл хийж буй цагдаагийн тоог нэмэгдүүлэх, 1 цагдаагийн албан хаагчид үйлчлэх хүний тоо нь дэлхий улс оронд янз бүр байдаг. Жиншээ нь АНУ 350 хүнд нэг цагдаагийн албан хаагч, ОХУ-д 400 хүнд нэг цагдаагийн албан хаагч харин манай улсад 900 хүнд нэг цагдаагийн албан хаагч үйлчилж байна.

Мөн тэнүүлчин, оршин суух тодорхой хаяггүй хүмүүсийг хаягжуулах ажлын баг, хорооны Засаг даргын тамгын ажлын албанаас хэрэгжүүлэх, тэдгээрт хяналт тавих нь чухал байна.



## Дүгнэлт

Монгол улсад 1990 оноос ардчилалын үндэс суурь тавигдаж 1992 онд хүнэлэг,энэрэнгүй ардчилсан ёсонд тулгуурласан Үндсэн хуулиа баталсан. Үндсэн хуулинд хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон хувийн өмчийг хайрлан хамгаалах талаар тусгасан. Тухайлбал: <sup>33</sup>Монгол улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална гэж тунхагласан, 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэгт иргэдийг хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийг шударгаар олж авах, өмчлөх эрхийг баталгаажуулсан байна. Иймд нийтийн болон хувийн өмчийн бүх төрлийг гэмт хэргийн халдлагаас хамгаалах явдал бол эрүүгийн эрх зүйн нэгэн чухал чиг үүрэг мөн. Хууль зүйн утгаараа Эрүүгийн хууль нь зохицуулах чиг үүргийн зэрэгцээ хамгаалах чиг үүргийг түлхүү гүйцэтгэдэг юм. Үүнийг Эрүүгийн хуулийн зорилтоос тодорхой харж болох юм. Үүнд:

Монгол Улсын Эрүүгийн хуулийн зорилт нь Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон хувийн өмч, үндэсний баялаг, байгаль орчин, эрх зүйн журам, энхтайван, хүн төрөлхтөний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалахад оршино.

.Монгол Улсын Эрүүгийн хууль энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд хүн, төр, нийгэмд аюултай ямар үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, түүнийг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээг тогтооно гэсэн нарийн зохицуулалттай юм.

Дээрхээс үзвэл нийтийн болон хувийн өмчийн хамгаалалтыг шинэ Үндсэн хуулийн үзэл санаанд тулгуурлан 2002 онд шинэ Эрүүгийн хуулийг батлан дагаж мөрдөж байгаа нь дэвшилтэд талуудын нэг юм.

Сүүлийн жилүүдэд манай улсад иргэдийн шилжилт хөдөлгөөн, хүн амын ядуурал, ажилгүйдэл, хот хөдөөгийн ялгаа, амьжиргааны тэгш бус байдал, иргэдийн

<sup>33</sup> Монгол Улсын Үндсэн хууль 1992 он Төрийн мэдээлэл сэтгүүл №1

боловсрол, мэргэжил, нас, хүйс, хохирогчийн гэм буруу зэрэг нь бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг үйлдэхэд сөргөөр нөлөөлж байна. Хууль тогтоогч Эрүүгийн хуулийн тусгай ангийн 147 дугаар зүйлд бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийг хуульчилсан байна. Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг гэдэг нь шунахай сэдэлттэйгээр бусдын өмчийн эд хөрөнгийг хууль бусаар хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх аргаар авч өөрийн өмчийн нэгэн адил захиран зарцуулах боломж бүрдүүлэхийг хэлнэ. Энэ гэмт хэрэг нь бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэн авахаас гадна иргэдийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж буй хүнд гэмт хэрэг юм.

Монгол улсад гарч байгаа бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн объект, халдлагыг зүйл, үйлдлийн арга, шалтгаан, түүнчлэн энэ гэмт хэргийг үйдэж байгаа хүмүүсийн хувийн байдал, үйлдлийн арга, гэмт хэрэг үйлдэж байгаа газар зэрэг олон онцлог асуудал анхаарал татаж байна. Иймээс дараах санал дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Эрүүгийн хуулийн 147 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан оногдуулах ял буюу санкц нь зөвхөн хорих ял байна. Шууд таван жилээс дээш найман жил хүртэл гэсэн нь хүнд гэмт хэрэг болно. Уг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял оногдуулахдаа гэмт хэрэг үйлдэх болсон шалтгаан, хохирлын хэр хэмжээ зэргийг харгалзан оногдуулах ялыг багасгах шаардлагатай байна. Учир нь энэхүү гэмт хэргийг субъектууд нь 14 наснаас 25 насны хүмүүс өөрийн хайхрамжгүй байдал, эрх зүйн ухамсар дутуу, ар гэрийн байдал, найз нөхдийн хүрээ, орчин тойрноосоо нөлөөлж дээрмийн гэмт хэргийн учир холбогдлыг ойлгохгүйгээр бага хэмжээний эд зүйл, мөнгө төгрөг анх удаагаа дээрэмдэн амьдралдаа маш том алдаж байна. Ингэж хэрэгт холбогдсон хүмүүст шууд Эрүүгийн хууль заасан доод хэмжээний хорих ял оногдуулах боломжгүй хязгаарлагдмал байна. Мөн Үндсэн хуулинд тунхаглан заасан эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно гэсний хүмүүнлэг шинж нь алдагдаж байна гэж үзэж байна. Энэхүү Үндсэн хуулийн заалтыг зөрчсөн зохицуулалтыг төр залруулах нь зүйтэй юм.

Иймд Эрүүгийн хуулинд нэмэлт өөрчлөлт оруулж өөрчлөх шаардлага зүй ёсоор урган гарч байгааг хөндөх нь зүйтэй байна. 1993 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад тус хуулийн ерөнхий ангийн 39-р зүйлд шүүх гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдийн гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт

хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдлыг харгалзан үзэж түүнд эрүүгийн хуулийн тусгай ангид заасан ялын доод хэмжээнээс доогуур ял оногдуулах боломжтой байсан.

Харин энэ талаар 2002 оны Эрүүгийн хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна. Ингэснээр хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, ардчилсан ёсонд тулгуурлан батласан Үндсэн хуулийн үзэл санаанд нийцнэ гэж үзнэ.

2.Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна. Үүнд

Аж ахуйн нэгж, байгууллагыг 200000-250000 төгрөгөөр торгож, уул согтууруулах ундаа болон хууль бусаар олсон орлогыг хурааж, согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, иргэнийг 35000-50000, аж ахуйн нэгж, байгууллагыг 150000-250000 төгрөгөөр торгож, уул согтууруулах ундаа болон хууль бусаар олсон орлогыг хурааж, согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээг одоо явч байна. Үүнийг өөрчлөх цаг нэгэн болсон байна. Аж ахуй нэгж байгууллагыг 1000000-10000000 төгрөгөөр торгож, уул согтууруулах ундаа болон хууль бусаар олсон орлогыг хурааж, согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, иргэнийг 100000-1000000 төгрөгөөр торгох, аж ахуйн нэгж, байгууллагыг 1000000-5000000 төгрөгөөр торгож, уул согтууруулах ундаа болон хууль бусаар олсон орлогыг хурааж, согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авах ёстой гэж бодож байна.

Криминологийн үүднээс доорхи шат дараалсан арга хэмжээг авах нь дээрмийн гэмт хэрэгтэй тэмцэхэд бага ч гэсэн хувь нэмэр оруулна гэж итгэж байна. Үүнд:

1.Ерөнхий боловсролын дунд сургуульд эрх зүйн болон гэмт хэргийн талаар тодорхой ойлголттой болгох зорилгоор сургалтын программыг өөрчлөлт оруулах шаардлагатай байна. Ингэснээр хүүхдүүдийн хувьд гэмт хэргийн талаар тодорхой ойлголттой болж тухайн гэмт хэрэгт ямар ял шийтгэл эдлэх талаар ойлголтыг нэг түвшинд хүргэнэ. Мөн ангийн багш нь хичээлийн бус чөлөөт цагийг сурагчид нь яаж өнгөрүүлж байгаа, нийлж байгаа хүмүүсийн талаар анхаарал хяналт тавьж энэ талаар эцэг, эхчүүдтэй зөвлөлдөн хүүхдүүдийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах нь зөв юм.

2.Дээрмийн гэмт хэргийн олон нийтэд хүргэх зорилгоор FM, радио, телевизийн сувагуудаар олонд хамгийн хялбар аргаар ойлгогдохоор нэвтрүүлэг, эрх зүйн чиглэлээр тогтмол уралдаан тэмцээн, иргэдэд сэрэмжлүүлэг мэдээлэл явуулах ба иргэдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, өөрийн ямар буруутай үйлдлээс болж гэмт хэргийн хохирогч болж болохыг ойлгуулах

3.Гудамж тайлбайг гэрэлтүүлэгтэй болгох. цагдаагийн эргүүлийн ажиллагааг тогтмол болгох, нэг цагдаагийн албан хаагчид оногдох иргэдийн тоог багасгах зорилгоор цагдаагийн албан хаагчдын тоог нэмэгдүүлэх, цагдаагийн албан хаагчдын мэдэглэг, боловсролыг дээшлүүлвэл гэмт хэрэг үйлдэх орчин нөхцөл боломжийг таслан зогсоох үндэслэл болно.

4.Архидалтыг багасгах. Манай нийгэмд архидан согтуурах явдал нь хэрээс хэтэрч байна. Дээрмийн гэмт хэрэг үйлдэгсэдийн 70 гаруй хувь нь согтуугаар үйлдсэн байна. Төр архидан согтуурахтай тэмцэх тусгай төсөл боловсруулж нийгмийг архидалтаас цэвэрлэх талаар хууль эрх зүйн бодлогыг өөрчлөх шаардлагатай байна. Согтууруулах ундааны үйлдвэрлэлийг төр өөрийн мэдэлд авч хуулийн шаадлага хангасан цөөн тооны үйлдвэрийг ажиллуулж бусад үйлдэрийн үйл ажиллагааг зогсоох, согтууруулах ундааг худалдан борлуулах цэгийн тоог цөөлөх.

5. Төр, Олон нийтийн байгууллагаас хараа хяналтгүй, тэнүүчлэн амьдарч байгаа хүмүүсийг нийгмийн халамжинд хамруулах зорилгоор тэднийг нэгдсэн байранд байлгаж тохирсон хэмжээний хөдөлмөр эрхлүүлэх нэгдсэн арга хэмжээ авах шаардлагатай байна.
























2004-2006 онд бусдын эд хөрөнгийг  
дээрэмдэх гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн тоон үзүүлэлт




**2004-2006 онд бусдын эд хөрөнгийг  
дээрэмдэх гэмт хэрэгт шийтгүүлсэн насанд хүрээгүйчүүдийн тоон үзүүлэлт**





20

2004-2006 онд бусдын эд хөрөнгийг  
дээрэмдэх гэмт хэрэгт шийтгүүлсэн эмэгтэйчүүдийн  
тоон үзүүлэлт



Ном зүй

## 1.Хууль тогтоомж

- 1.Монгол Улсын Үндсэн хууль. УБ. 1992 он
2. Монгол улсын Эрүүгийн хууль. УБ. 1942, 1961, 1986.
- 3.БНМАУ-ын Шүүх цаазын бичиг. УБ. 1926, 1929
- 4.БНМАУ-ын хууль тогтоомжийн эмхтгэл. УБ. 1968 он
- 5.Монгол улсын Эрүүгийн хууль. УБ. 2002 он
- 6.Зарилгаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг. УБ. 1995 он
- 7.Монгол Улсын Дээд Шүүхийн тогтоолын эмхтгэл. УБ. 2004 он
- 8.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль
- 9.БНХАУ-ын Эрүүгийн хууль 1997 он
- 10.Оросын Холбооны Улсын эрүүгийн хууль 2002 он

## 2.Монгол хэл дээрх ном, сурах бичгүүд

1. Ж.Авхиа “Гэмт явдал түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудал УБ. 1997 он
2. Д.Адъяабазар.Монгол Улсын 1921 оноос хойшхи эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. УБ.1998 он
3. Э.Авирмэд, Д.Дашцэдэн, Г.Совд Монгол Эрүүгийн эрх зүй УБ 1999 он
4. Н.Баатаржав, Б.Жаргал “Криминологи” УБ. 2001 он
5. Б.Батзориг, Э.Зууннасан БНХАУ-ын Эрүүгийн ба эрүүгийн заргын хууль.УБ.2006 он
6. Б.Ганболд “Монгол Улсын Эрүүгийн эрх зүй дэх гэмт хэрэг зүйлчлэлийн онол 2001 он
7. Ц.Дамдинсүрэн “Монголын нууц товчоо” УБ. 1975 он
8. Жалан-Аажав “Халх журам”. УБ. 1995 он
9. Н.Жанцан “Криминологи” УБ. 2004 он
- 10.Н.Баатаржав, Б.Жаргал “Криминологи” УБ. 2001 он
- 11.Ц.Цэлмэг “Криминологи” УБ. 2005 он
- 12.С.Нарангэрэл “Монгол улсын эрүүгийн эрх зүй”-н тусгай анги УБ.1999 он

13. Н.Ням-Осор “Чэнгис хааны Их засаг хуулийн тайлбар” УБ. 2001 он

14. Г.Совд “Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар” УБ. 2002 он

### **3.Бусад ашигласан материалууд**

1. Монгол Улсын Засгийн Газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр УБ 2002 он
2. Төрийн мэдээлэл сэтгүүл УБ 2000-2005 оны дугаарууд
3. Монгол Улсын Дээд шүүхийн тогтоолын эмхтгэл 2004-2006 он
4. Цагдаагийн академи “Гэмт явдалтай тэмцэх асуудал” УБ. 2005 он
5. [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn).

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэгтэй тэмцэх арга замыг боловсронгуй болгох нь

## ХАВСРАЛТ

### Дорноговь аймаг дахь Сум дундын 1 дүгээр шүүхийн 2000-2007 оны 9 сар байдлаар шийдвэрлэсэн бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэгийн судалгаа 2000 он

| д/д | Шүүгдэгчийн нэр                | Нас      | Хүйс     | Боловсрол мэргэжил         | Гэмт хэрэг үйлдсэн шалтгаан   | Зүйл анги | Дээрэмдсэн зүйл | Гэмт хэрэг үйлдсэн арга | Гэмт хэрэг хаана, хэзээ гарсан | Шийтгэх тогтоолоор оногдуулсан ял   |
|-----|--------------------------------|----------|----------|----------------------------|-------------------------------|-----------|-----------------|-------------------------|--------------------------------|---|
| 1.  | Ш.Гантулга<br>В.Гантулга       | 23<br>26 | Эр<br>Эр | Бүрэн дунд Мэргэжилгүй     | Согтууруулах ундаа хэрэглэсэн | 125.1     | Алтан бөгж      | Зодож хүч хэрэглэсэн    | Шөнө, гудамжинд                | 3 жил хорих ял оногдуулсан. 40.1-т зааснаар 2 жилийн хугацаагаар тэнссэн                                |
|     |                                |          |          | Бага Мэргэжилгүй           |                               |           |                 |                         |                                |   |
| 2.  | Ч.Отгончулуун<br>Ч.Түвшинсанаа | 19<br>20 | Эр<br>Эр | Бүрэн бус дунд Мэргэжилгүй | Согтууруулах ундаа хэрэглэсэн | 125.1     | 1 хос гутал     | Зодож хүч хэрэглэсэн    | үүдээс хойш гудамжинд          | 39-р зүйлийг журамлан 1 жил 6 сар хорих ял оногдуулсан. 40.1-т зааснаар 1 жил 6 сар хугацаагаар тэнссэн |
|     |                                |          |          | Бүрэн бус дунд Мэргэжилгүй |                               |           |                 |                         |                                |   |
| 3.  | Ж.Үнэбат<br>Ц.Чойдорж          | 20<br>20 | Эр<br>эр | Бүрэн бус дунд Мэргэжилгүй | Согтууруулах ундаа хэрэглэсэн | 125.1     | 1300 төгрөг     | Зодож хүч хэрэглэсэн    | Шөнө гудамжинд                 | 39-р зүйлийг журамлан 1 жил хорих ял оногдуулсан  |
|     |                                |          |          | Бүрэн бус дунд Мэргэжилгүй |                               |           |                 |                         |                                |   |

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэгтэй тэмцэх арга замыг боловсронгуй болгох нь

### 2001 он

| д/д | Шүүгдэгчийн нэр                           | Нас            | Хүйс           | Боловсрол мэргэжил | Гэмт хэрэг үйлдсэн шалтгаан   | Зүйл анги | Дээрэмдсэн зүйл  | Гэмт хэрэг үйлдсэн арга | Гэмт хэрэг хаана, хэзээ гарсан | Шийтгэх тогтоолоор оногдуулсан ял   |
|-----|---|----------------|----------------|--------------------|-------------------------------|-----------|------------------|-------------------------|--------------------------------|---|
| 1.  | Б.Батбаатар<br>С.Хүрэлчулуун<br>Б.Содбаяр | 20<br>21<br>22 | Эр<br>Эр<br>Эр | Бага Мэргэжилгүй   | Согтууруулах ундаа хэрэглэсэн | 125.1     | Цайны халуун сав | Зодож хүч хэрэглэсэн    | Шөнө, гудамжинд                | Б.Батбаатар хэрэгсэхгүй болгосон. 3 жил хорих ял оногдуулсан 40.1 дэх хэсэгт зааснаар 2 жил тэнссэн |
|     |   |                |                | Бага Мэргэжилгүй   |                               |           |                  |                         |                                |   |
|     |   |                |                | Бага Мэргэжилгүй   |                               |           |                  |                         |                                |   |
| 2.  | Д.Даваадорж                               | 26             | Эр             | Бүрэн бус дунд     | Согтууруулах ундаа хэрэглэсэн | 125.1     | 274000 төгрөг    | Зодож хүч хэрэглэсэн    | Шөнө машинд нь                 | 39-р зүйлийг журамлан 1 жил хорих ял оногдуулсан  |

### 2002 он

| д/д | Шүүгдэгчийн нэр | Нас | Хүйс | Боловсрол мэргэжил    | Гэмт хэрэг үйлдсэн шалтгаан   | Зүйл анги | Дээрэмдсэн зүйл          | Гэмт хэрэг үйлдсэн арга | Гэмт хэрэг хаана, хэзээ гарсан | Шийтгэх тогтоолоор оногдуулсан ял                                 |
|-----|-----------------|-----|------|-----------------------|-------------------------------|-----------|--------------------------|-------------------------|--------------------------------|---|
| 1.  | Мөнх-Алдар      | 26  | Эр   | Бүрэн бус дунд Жолооч | Согтууруулах ундаа хэрэглэсэн | 125.1     | Бугуй цаг, савхин бээлий | Зодож хүч хэрэглэсэн    | өдөр барьж байгаа барилгад     | 3 жил хорих ял оногдуулсан 40.1 дэх хэсэгт зааснаар 2 жил тэнссэн |

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэгтэй тэмцэх арга замыг боловсронгуй болгох нь

### 2004 он

| д/д | Шүүгдэгчийн нэр              | Нас      | Хүйс     | Боловсрол мэргэжил        | Гэмт хэрэг үйлдсэн шалтгаан          | Зүйл анги | Дээрэмдсэн зүйл | Гэмт хэрэг үйлдсэн арга | Гэмт хэрэг хаана, хэзээ гарсан | Шийтгэх тогтоолоор оногдуулсан ял        |
|-----|------------------------------|----------|----------|---------------------------|--------------------------------------|-----------|-----------------|-------------------------|--------------------------------|--|
| 1.  | М.Энхжаргао<br>Л.Отгончулуун | 30<br>31 | Эр<br>Эр | Бүрэн дунд<br>Замчин      | Согтууруу<br>лах ундаа<br>хэрэглэсэн | 147.2     | Алтан бөгж      | Зодож хүч<br>хэрэглэсэн | Шөнө<br>вокзал<br>дээр         | 8 жил 1 сар<br>хорих ял<br>оногдуулсан   |
|     |                              |          |          | Бүрэн дунд<br>Мэргэжилгүй |                                      |           |                 |                         |                                |  |
| 2.  | Ч.Болдбаатар                 | 20       | Эр       | Бага<br>Мэргэжилгүй       | Согтууруу<br>лах ундаа<br>хэрэглэсэн | 147.1     | 1 хос гутал     | Зодож хүч<br>хэрэглэсэн | Шөнө<br>орцонд                 | 5 жил 1 хоног<br>хорих ял<br>оногдуулсан |

### 2005 он

| д/д | Шүүгдэгчийн нэр              | Нас      | Хүйс     | Боловсрол мэргэжил        | Гэмт хэрэг үйлдсэн шалтгаан          | Зүйл анги | Дээрэмдсэн зүйл | Гэмт хэрэг үйлдсэн арга | Гэмт хэрэг хаана, хэзээ гарсан | Шийтгэх тогтоолоор оногдуулсан ял      |
|-----|------------------------------|----------|----------|---------------------------|--------------------------------------|-----------|-----------------|-------------------------|--------------------------------|--|
| 1.  | М.Энхжаргао<br>Л.Отгончулуун | 30<br>31 | Эр<br>Эр | Бүрэн дунд<br>Замчин      | Согтууруу<br>лах ундаа<br>хэрэглэсэн | 147.2     | Алтан бөгж      | Зодож хүч<br>хэрэглэсэн | Шөнө<br>вокзал<br>дээр         | 8 жил 1 сар<br>хорих ял<br>оногдуулсан |
|     |                              |          |          | Бүрэн дунд<br>Мэргэжилгүй |                                      |           |                 |                         |                                |  |

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэгтэй тэмцэх арга замыг боловсронгуй болгох нь

### 2006 он

| д/д | Шүүгдэгчийн нэр | Нас | Хүйс | Боловсрол мэргэжил       | Гэмт хэрэг үйлдсэн шалтгаан | Зүйл анги | Дээрэмдсэн зүйл | Гэмт хэрэг үйлдсэн арга   | Гэмт хэрэг хаана, хэзээ гарсан | Шийтгэх тогтоолоор оногдуулсан ял                    |
|-----|-----------------|-----|------|--------------------------|-----------------------------|-----------|-----------------|---------------------------|--------------------------------|--|
| 1.  | М.Жаргалбаяр    | 17  | Эр   | Боловсролгүй Мэргэжилгүй | Гэрт хоолгүй байсан         | 147.2     | 10000 төгрөг    | Хадаас хоолойнд нь тулгаж | Шөнө ШТС-д                     | 8 жил 1сар хорих ял оногдуулсан 2 жилээр хойшлуулсан |

### 2007 он

| д/д | Шүүгдэгчийн нэр             | Нас      | Хүйс     | Боловсрол мэргэжил                             | Гэмт хэрэг үйлдсэн шалтгаан   | Зүйл анги | Дээрэмдсэн зүйл                   | Гэмт хэрэг үйлдсэн арга        | Гэмт хэрэг хаана, хэзээ гарсан | Шийтгэх тогтоолоор оногдуулсан ял |
|-----|-----------------------------|----------|----------|--|-------------------------------|-----------|-----------------------------------|--------------------------------|--------------------------------|-----------------------------------|
| 1.  | Б.Эрдэнэчулуун              | 26       | Эр       | Бүрэн бус дунд Мэргэжилгүй                     | Шунахай                       | 147.2     | 1500 төгрөг, гар утас             | Зодож хүч хэрэглэсэн Хүчиндсэн | Шөнө гудамжинд                 | 8 жил 1сар хорих ял оногдуулсан   |
| 2.  | О.Энхболд                   | 22       | Эр       | Бүрэн бус дунд Гагнуурчин                      | Шунахай                       | 147.1     | Алтан бөгж, ээмэг, гинж, гар утас | Айлган сүрдүүлсэн              | Шөнө гудамжинд                 | 5 жил 1сар хорих ял оногдуулсан   |
| 3.  | Ж.Буянбаатар<br>Г.Отгонболд | 22<br>22 | Эр<br>Эр | Бүрэн бус дунд Жолооч<br>Бүрэн дунд Гагнуурчин | Согтууруулах ундаа хэрэглэсэн | 147.2     | Гар утас, гинж                    | Зодож хүч хэрэглэсэн Хүчиндсэн | Шөнө гудамжинд                 | 8 жил 1сар хорих ял оногдуулсан   |

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэгтэй тэмцэх арга замыг боловсронгуй болгох нь

Дорноговь аймгийн Сум дундын 1 дүгээр шүүхэд 2003 онд бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг гараагүй байна.

| д/д | Шүүгдэгчийн нэр | Нас | Хүйс | Боловсрол мэргэжил     | Гэмт хэрэг үйлдсэн шалтгаан    | Зүйл анги | Дээрэмдсэн зүйл | Гэмт хэрэг үйлдсэн арга | Гэмт хэрэг хаана, хэзээ гарсан | Шийтгэх тогтоолоор оногдуулсан ял                |
|-----|-----------------|-----|------|------------------------|--------------------------------|-----------|-----------------|-------------------------|--------------------------------|--|
| 1.  | Д.Мөнхбаатар    | 29  | Эр   | Бүрэн дунд Мэргэжилгүй | Согтууруул ах ундаа хэрэглэсэн | 125.1     | 1300 төгрөг     | Зодож хүч хэрэглэсэн    | Шөнө, гудамжинд                | 39-р зүйлийг журамлан 1 жил хорих ял оногдуулсан |

**Дорноговь аймаг дахь Сум дундын 2 дугаар шүүхийн 2000-2006 оны байдлаар шийдвэрлэсэн бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн судалгаа**

**2000 он**

**2001 он**

| д/д | Шүүгдэгчийн нэр                                     | Нас            | Хүйс           | Боловсрол мэргэжил         | Гэмт хэрэг үйлдсэн шалтгаан | Зүйл анги | Дээрэмдсэн зүйл                 | Гэмт хэрэг үйлдсэн арга | Гэмт хэрэг хаана, хэзээ гарсан | Шийтгэх тогтоолоор оногдуулсан ял   |
|-----|---|----------------|----------------|----------------------------|-----------------------------|-----------|---------------------------------|-------------------------|--------------------------------|---|
| 1.  | С.Жавхалантөг өлдөр<br>Б.Энхмандах<br>Ц.Хатанбаатар | 16<br>17<br>17 | Эр<br>Эр<br>Эр | Бага Мэргэжилгүй           | Шунахай                     | 125.1     | Хос гутал 2 өмд 2 Маогай Куртик | Зодож хүч хэрэглэсэн    | Шөнө, Подволд                  | С.Жавхалантөг гөлдөрийг 2 жил хойшлуулсан 3 жил хорих ял оногдуулсан 40.1 дэх хэсэгт зааснаар 2 |
|     |   |                |                | Бүрэн бус дунд Мэргэжилгүй |                             |           |                                 |                         |                                |   |
|     |   |                |                | Боловсролгүй Мэргэжилгүй   |                             |           |                                 |                         |                                |   |



Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэгтэй тэмцэх арга замыг боловсронгуй болгох нь

|  |  |  |  |  |  |  |  |  |  |             |
|--|--|--|--|--|--|--|--|--|--|-------------|
|  |  |  |  |  |  |  |  |  |  | ЖИЛ ТЭНССЭН |
|--|--|--|--|--|--|--|--|--|--|-------------|

**2003 он**

| д/д | Шүүгдэгчийн нэр              | Нас      | Хүйс     | Боловсрол мэргэжил         | Гэмт хэрэг үйлдсэн шалтгаан   | Зүйл анги | Дээрэмдсэн зүйл | Гэмт хэрэг үйлдсэн арга | Гэмт хэрэг хаана, хэзээ гарсан | Шийтгэх тогтоолоор оногдуулсан ял  |
|-----|------------------------------|----------|----------|----------------------------|-------------------------------|-----------|-----------------|-------------------------|--------------------------------|------------------------------------|
| 1.  | Д.Баяртогтох<br>Ж.Баярсайхан | 22<br>25 | Эр<br>Эр | Бүрэн дунд Мэргэжилгүй     | Согтууруулах ундаа хэрэглэсэн | 147.2     | 5500 юань       | Зодож хүч хэрэглэсэн    | Шөнө гудамжинд                 | 8 жил 1 сар хорих ял оногдуулсан   |
|     |                              |          |          | Бүрэн бус дунд Мэргэжилгүй |                               |           |                 |                         |                                |                                    |
| 2.  | Ж.Отгонбаяр                  | 37       | Эр       | Бүрэн бус дунд Мэргэжилгүй | Согтууруулах ундаа хэрэглэсэн | 147.2     | 53600 төгрөг    | Зодож хүч хэрэглэсэн    | Шөнө гудамжинд                 | 8 жил 1 хоног хорих ял оногдуулсан |

Дорноговь аймгийн Сум дундын 2 дугаар шүүхэд 2002, 2004, 2005, 2006 онуудад бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг гараагүй байна.

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэгтэй тэмцэх арга замыг боловсронгуй болгох нь

**Сонгинохайрхан дүүргийн шүүхийн 2004-2006 оны байдлаар  
шийдвэрлэсэн бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэгийн судалгаа**

**2004 он**

| Д/д | Шүүгдэгчийн нэр           | Нас      | Хүйс     | Боловсрол мэргэжил               | Ял шийтгүүлсэн эсэх | Зүйл анги | Дээрэмдсэн зүйл                | Гэмт хэрэг үйлдсэн арга                                  | Гэмт хэрэг хаана, хэзээ гарсан    | Шийтгэх тогтоолоор оногдуулсан ял                          |
|-----|---------------------------|----------|----------|----------------------------------|---------------------|-----------|--------------------------------|--|-----------------------------------|--|
| 1.  | Э.Буянбат<br>Ч.Оюунбаатар | 17<br>27 | Эр<br>Эр | Боловсролгүй<br>Мэргэжилгүй      | Үгүй<br>Үгүй        | 147.2     | 165800<br>төгрөгийн эд<br>зүйл | Боож<br>унагааж<br>зодож хүч<br>хэрэглэсэн               | Шөнө<br>гудамжинд                 | Шийтгэх<br>тогтоол<br>биелүүлэхийг 2<br>жил<br>хойшлуулсан |
|     |                           |          |          | Бүрэн бус<br>дунд<br>Мэргэжилгүй |                     |           |                                |  |                                   | 8 жил 1 хоног<br>хорих ял<br>оногдуулсан                   |
| 2.  | О.Пүрэвдаваа              | 22       | Эр       | Бага<br>Мэргэжилгүй              | Үгүй                | 147,1     | 5800 төгрөг                    | зодож хүч<br>хэрэглэсэн<br>хөнгөн<br>гэмтэл<br>учруулсан | Өдөр<br>гудамжинд                 | 5 жил 6 сар<br>хорих ял<br>оногдуулсан                     |
| 3.  | Д.Батмөнх<br>Г.Баасанхүү  | 17<br>22 | Эр<br>Эр | Бага<br>Мэргэжилгүй              | Үгүй<br>Үгүй        | 147,2     | 25000 төгрөг                   | зодож хүч<br>хэрэглэсэн                                  | Шөнө<br>Машины<br>зогсоол<br>дээр | Шийтгэх<br>тогтоол   |

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэгтэй тэмцэх арга замыг боловсронгуй болгох нь

|  |  |  |  |                           |  |  |  |  |  |  |
|--|--|--|--|---------------------------|--|--|--|--|--|--|
|  |  |  |  |                           |  |  |  |  |  | хойшлуулсан                              |
|  |  |  |  | Бүрэн дунд<br>Мэргэжилгүй |  |  |  |  |  | 8 жил 1 хоног<br>хорих ял<br>оногдуулсан |

| д/д | Шүүгдэгчийн нэр          | Нас      | Хүйс     | Боловсрол<br>Мэргэжил                   | Ял<br>шийтгүүлсэн<br>эсэх | Зүйл<br>анги | Дээрэмдсэн<br>зүйл        | Гэмт хэрэг<br>үйлдсэн<br>арга                     | Гэмт хэрэг<br>хаана,<br>хэзээ<br>гарсан | Шийтгэх<br>тогтоолоор<br>оногдуулсан<br>ял |
|-----|--------------------------|----------|----------|---|---------------------------|--------------|---------------------------|---|---|--|
| 4,  | Л.Ганчулуун<br>Н.Мөнхсүх | 21<br>19 | Эр<br>Эр | Бага<br>мэргэжилгүй                     | Үгүй<br>Үгүй              | 147,<br>2    | Диск, пүүз,<br>500 төгрөг | Зодож хүч<br>хэрэглэсэн                           | Шөнө<br>гудамжинд                       | 8 жил 1 хоног<br>хорих ял<br>оногдуулсан   |
|     |                          |          |          | Бага<br>боловсролто<br>й<br>мэргэжилгүй |                           |              |                           |   |   | 8 жил 1 хоног<br>хорих ял<br>оногдуулсан   |
| 5,  | Б.Баярсайхан             | 28       | Эр       | Бүрэн бус<br>дунд<br>Мэргэжилгүй        | 2 удаа<br>шийтгүүлсэн     | 147,<br>2    | Гар утас                  | Хоолойд нь<br>хутга<br>тулган<br>заналхийлс<br>эн | Шөнө гэрт<br>нь                         | 8 жил 1 сар<br>хорих ял<br>оногдуулсан     |

| д/д | Шүүгдэгчийн нэр                         | Нас            | Хүйс           | Боловсрол<br>мэргэжил     | Ял<br>шийтгүүлсэ<br>н эсэх | Зүйл<br>анги | Дээрэмдсэн<br>зүйл               | Гэмт хэрэг<br>үйлдсэн<br>арга             | Гэмт хэрэг<br>хаана,<br>хэзээ<br>гарсан | Шийтгэх<br>тогтоолоор<br>оногдуулсан<br>ял |
|-----|---|----------------|----------------|---------------------------|----------------------------|--------------|----------------------------------|---|---|--|
| 6.  | Н.Бат-Өлзий<br>П.Баялхам<br>Л.Баатархүү | 29<br>25<br>30 | Эр<br>Эр<br>Эр | Бүрэн дунд<br>Мэргэжилгүй | үгүй                       | 147.2        | Цаг, гар<br>утас, 4000<br>төгрөг | Таксины<br>жолоочыг<br>боож,<br>зодож хүч | Шөнө,<br>машинд<br>нь                   | 8 жил 3 сар<br>хорих ял<br>оногдуулсан     |
|     |   |                |                |                           | үгүй                       |              |                                  |   |   |  |
|     |   |                |                |                           | 1 удаа<br>шийтгүүлсэ       |              |                                  |   |   |  |

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэгтэй тэмцэх арга замыг боловсронгуй болгох нь

|  |  |  |  |                           |   |  |  |            |  |   |
|--|--|--|--|---------------------------|---|--|--|------------|--|---|
|  |  |  |  | дунд<br>Мэргэжилгүй       | н |  |  | хэрэглэсэн |  |   |
|  |  |  |  | Бүрэн дунд<br>Мэргэжилгүй |   |  |  |            |  | 8 жил 10 хоног<br>хорих ял<br>оногдуулсан |
|  |  |  |  |                           |   |  |  |            |  | 8 жил 10 хоног<br>хорих ял<br>оногдуулсан |

| д/д | Шүүгдэгчийн нэр             | Нас      | Хүйс     | Боловсрол мэргэжил          | Ял шийтгүүлсэн эсэх | Зүйл анги | Дээрэмдсэн зүйл                 | Гэмт хэрэг үйлдсэн арга                                 | Гэмт хэрэг хаана, хэзээ гарсан | Шийтгэх тогтоолоор оногдуулсан ял                          |
|-----|-----------------------------|----------|----------|-----------------------------|---------------------|-----------|---------------------------------|---|--------------------------------|--|
| 7.  | Т.Батжаргал<br>Б.Отгонгэрэл | 25<br>27 | Эр<br>Эр | Бүрэн дунд<br>Мэргэжилгүй   | үгүй<br>үгүй        | 147.2     | 6000 төгрөг,<br>бичиг<br>баримт | Таксины<br>жолоочыг<br>боож,<br>зодож хүч<br>хэрэглэсэн | Шөнө,<br>машинд<br>нь          | 8 жил 10 хоног<br>хорих ял<br>оногдуулсан                  |
|     |                             |          |          | Бүрэн дунд<br>Цахилгаан     |                     |           |                                 |   |                                | 8 жил 10 хоног<br>хорих ял<br>оногдуулсан                  |
| 8.  | Э.Одонгуа<br>Т.Ургахнаран   | 19<br>15 | Эм<br>Эм | Бага<br>Мэргэжилгүй         | үгүй                | 147.2     | Нэхий дээл,<br>бөгж, зэмэг      | Араас нь<br>боож,<br>зодож хүч<br>хэрэглэсэн            | Шөнө<br>гудамжин<br>д          | 8 жил 10 хоног<br>хорих ял<br>оногдуулсан                  |
|     |                             |          |          | Боловсролгүй<br>Мэргэжилгүй |                     |           |                                 |   |                                | Шийтгэх<br>тогтоол<br>биелүүлэхийг<br>2 жил<br>хойшлуулсан |
| 9.  | Г.Дандар                    | 22       | Эр       | Бүрэн дунд<br>Мэргэжилгүй   | үгүй                | 147.1     | 2900 төгрөг<br>мөнгөн бөгж      | Согтуугаар<br>зодож хүч<br>хэрэглэсэн                   | Шөнө<br>гудамжин<br>д          | 5 жил 1 хоног<br>хорих ял<br>оногдуулсан                   |
| 10. | Г.Буянтогтох<br>Д.Эрхэмбаяр | 25<br>20 | Эр<br>Эр | Бүрэн дунд                  | 1 удаа              | 147.2     | Гар утас,<br>түрүүвчтэй         | Согтуугаар<br>зодож хүч                                 | өдөр<br>гудамжин               | 8 жил 10 хоног   |

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэгтэй тэмцэх арга замыг боловсронгуй болгох нь

|  |               |    |    |                           |      |  |       |            |   |   |
|--|---------------|----|----|---------------------------|------|--|-------|------------|---|---|
|  |               |    |    |                           |      |  |       |            |   | оногдуулсан                               |
|  | Ц.Сумъяабазар | 18 | Эр | Бүрэн дунд<br>Мэргэжилгүй | үгүй |  | мөнгө | хэрэглэсэн | д | 8 жил 10 хоног<br>хорих ял<br>оногдуулсан |
|  |               |    |    | Бага<br>Мэргэжилгүй       | үгүй |  |       |            |   | 8 жил 10 хоног<br>хорих ял<br>оногдуулсан |

2005 он

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэгтэй тэмцэх арга замыг боловсронгуй болгох нь

| д/д | Шүүгдэгчийн нэр                         | Нас            | Хүйс           | Боловсрол мэргэжил         | Ял шийтгүүлсэн эсэх | Зүйл анги | Дээрэмдсэн зүйл  | Гэмт хэрэг үйлдсэн арга            | Гэмт хэрэг хаана, хэзээ гарсан | Шийтгэх тогтоолоор оногдуулсан ял   |
|-----|---|----------------|----------------|----------------------------|---------------------|-----------|--|------------------------------------|--------------------------------|-------------------------------------|
| 1.  | О.Хуягбаатар<br>Р.Амгалан               | 28<br>27       | Эр<br>Эр       | Бага Мэргэжилгүй           | 2 удаа шийтгүүлсэн  | 147.2     | Цүнх, хонины толгой, цувдай, оймс, омо вок, барааны сав, 4500 төгрөг | Согтуугаар зодож хүч хэрэглэсэн    | Шөнө, орцонд                   | 8 жил 1 сар хорих ял оногдуулсан    |
|     |   |                |                | Бага Мэргэжилгүй           | үгүй                |           |  |                                    |                                | 8 жил 1 сар хорих ял оногдуулсан    |
| 2.  | Г.Эрдэнэбаяр<br>Ж.Баатархүү<br>Ч.Батсүх | 20<br>22<br>23 | Эр<br>Эр<br>Эр | Бүрэн бус дунд Мэргэжилгүй | 1 удаа шийтгүүлсэн  | 147.2     | Нэхий куртик, малгай, цаг, гутал                                     | Метал гинжээр зодож хүч хэрэглэсэн | Шөнө гудамжинд                 | 8 жил 10 хоног хорих ял оногдуулсан |
|     |   |                |                | Бүрэн бус дунд Мэргэжилгүй | үгүй                |           |  |                                    |                                | 8 жил 10 хоног хорих ял оногдуулсан |
|     |   |                |                | Бага Мэргэжилгүй           | үгүй                |           |  |                                    |                                | 8 жил 10 хоног хорих ял оногдуулсан |

| д/д | Шүүгдэгчийн нэр | Нас | Хүйс | Боловсрол мэргэжил | Ял шийтгүүлсэн эсэх | Зүйл анги | Дээрэмдсэн зүйл | Гэмт хэрэг үйлдсэн арга | Гэмт хэрэг хаана, хэзээ гарсан | Шийтгэх тогтоолоор оногдуулсан ял |
|-----|-----------------|-----|------|--------------------|---------------------|-----------|-----------------|-------------------------|--------------------------------|-----------------------------------|
|-----|-----------------|-----|------|--------------------|---------------------|-----------|-----------------|-------------------------|--------------------------------|-----------------------------------|

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэгтэй тэмцэх арга замыг боловсронгуй болгох нь

|    |                                      |                |                |                            |                    |       |  |   |                 |  |
|----|--------------------------------------|----------------|----------------|----------------------------|--------------------|-------|--|---|-----------------|--|
| 3. | М.Даваасүрэн                         | 46             | Эр             | Бүрэн бус дунд Мэргэжилгүй | 1 удаа шийтгүүлсэн | 147.2 | 25000 төгрөг, цүнх                     | Тоосгоор цохино гэж заналхийлсэн            | Шөнө, гудамжинд | 1986 оны Эрүүгийн хуулийн 125.1 болгон өөрчилж, 39-р зүйлийг журамлан 1 жил 8 сар хирх |
| 4. | С.Батсуурь<br>П.Чимгээ<br>А.Хүрэлсүх | 28<br>23<br>19 | Эр<br>Эм<br>Эр | Бүрэн дунд Мэргэжилгүй     | үгүй               | 147.2 | 135000 төгрөгийн эд зүйл               | Согтуугаар зодож хүч хэрэглэсэн             | Шөнө гудамжинд  | 8 жил 1 сар хорих ял оногдуулсан   |
|    |                                      |                |                | Бүрэн дунд Мэргэжилгүй     | үгүй               |       |  |   |                 | 8 жил 1 сар хорих ял оногдуулсан   |
|    |                                      |                |                | Бүрэн дунд Мэргэжилгүй     | үгүй               |       |  |   |                 | 8 жил 1 сар хорих ял оногдуулсан   |
| 5. | Ж.Батмягмар<br>Г.Эрдэнэтулга         | 27<br>25       | Эр<br>Эр       | Дээд Инженер               | үгүй<br>үгүй       | 147.2 | Гар утас, нэхий бэлий, машины асаагуур | Таксины жолоочыг боож, зодож хүч хэрэглэсэн | Шөнө, машинд нь | 8 жил 1 сар хорих ял оногдуулсан   |
|    |                                      |                |                | Бүрэн дунд Мэргэжилгүй     |                    |       |  |   |                 | 8 жил 1 сар хорих ял оногдуулсан   |

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэгтэй тэмцэх арга замыг боловсронгуй болгох нь

| д/д | Шүүгдэгчийн нэр  | Нас                        | Хүйс                       | Боловсрол мэргэжил         | Ял шийтгүүлсэн эсэх                  | Зүйл анги | Дээрэмдсэн зүйл                          | Гэмт хэрэг үйлдсэн арга   | Гэмт хэрэг хаана, хэзээ гарсан | Шийтгэх тогтоолоор оногдуулсан ял   |
|-----|--|----------------------------|----------------------------|----------------------------|--------------------------------------|-----------|--|---|--------------------------------|-------------------------------------|
| 6.  | Д.Уранцэцэг<br>Б.Цэцэгмаа<br>Б.Нарангэрэл<br>Ч.Ландан<br>М.Цэцэгээ | 20<br>18<br>19<br>24<br>17 | Эм<br>Эм<br>Эм<br>Эм<br>Эм | Бүрэн бус дунд Мэргэжилгүй | үгүй<br>үгүй<br>үгүй<br>үгүй<br>үгүй | 147.2     | Дээрэмдэж чадаагүй                       | Таксины жолоочыг боож довтолсон боловч гинж нь тасарч баригдсан | өдөр, уулын аманд              | 8 жил 1 хоног хорих ял оногдуулсан  |
|     |  |                            |                            | Бүрэн бус дунд Мэргэжилгүй |                                      |           |  |   |                                | 8 жил 1 хоног хорих ял оногдуулсан  |
|     |  |                            |                            | Бүрэн дунд Мэргэжилгүй     |                                      |           |  |   |                                | 8 жил 1 хоног хорих ял оногдуулсан  |
|     |  |                            |                            | Боловсролгүй Мэргэжилгүй   |                                      |           |  |   |                                | 8 жил 1 хоног хорих ял оногдуулсан  |
|     |  |                            |                            | Бага Мэргэжилгүй           |                                      |           |  |   |                                | 8 жил 1 хоног хорих ял оногдуулсан  |
| 7.  | Д.Гантөмөр   | 27                         | Эр                         | Бага Мэргэжилгүй           | үгүй                                 | 147.2     | Гар утас, 11000 төгрөг, чихэвчний хөгжим | Хятал иргэдэд хутга тулган заналхийлсэн                         | Шөнө, гэрт нь                  | 8 жил 10 хоног хорих ял оногдуулсан |
| 8.  | Д.Бямбажав   | 32                         | Эр                         | Бүрэн бус дунд Мэргэжилгүй | үгүй                                 | 147.2     | Гутал                                    | Тоосгоор цохино гэж заналхийлсэн                                | Орой, траншейнд                | 8 жил 10 хоног хорих ял оногдуулсан |



Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэгтэй тэмцэх арга замыг боловсронгуй болгох нь

2006 он

| д/д | Шүүгдэгчийн нэр        | Нас      | Хүйс     | Боловсрол мэргэжил         | Ял шийтгүүлсэн эсэх   | Зүйл анги | Дээрэмдсэн зүйл                           | Гэмт хэрэг үйлдсэн арга                     | Гэмт хэрэг хаана, хэзээ гарсан | Шийтгэх тогтоолоор оногдуулсан ял   |
|-----|------------------------|----------|----------|----------------------------|-----------------------|-----------|---|---|--------------------------------|-------------------------------------|
| 1.  | Ж.Барс                 | 29       | Эр       | Боловсролгүй Мэргэжилгүй   | 1 удаа ял шийтгүүлсэн | 147.1     | Гутал                                     | Согтуугаар зодож хүч хэрэглэсэн             | Шөнө, гудамжинд                | 8 жил 10 хоног хорих ял оногдуулсан |
| 2.  | Ц.Гантулга<br>А.Мягмар | 26<br>24 | Эр<br>Эр | Бага Мэргэжилгүй           | 3 удаа ял шийтгүүлсэн | 147.2     | Куртик                                    | Тоосгоор цохино гэж заналхийлсэн            | Орой, траншейнд                | 8 жил 1 хоног хорих ял оногдуулсан  |
|     |                        |          |          | Бүрэн бус дунд Мэргэжилгүй | 1 удаа ял шийтгүүлсэн |           |   |   |                                | 8 жил 1 хоног хорих ял оногдуулсан  |
| 3.  | К.Атарбек<br>Л.Ган-Од  | 24<br>24 | Эр<br>Эр | Бүрэн дунд Жолооч          | 1 удаа ял шийтгүүлсэн | 147.2     | Савхин пиджак, гар утас, түрүүвчтэй мөнгө | Таксины жолоочыг боож, зодож хүч хэрэглэсэн | Шөнө Машинд нь                 | 8 жил 1 сар хорих ял оногдуулсан    |
|     |                        |          |          | Дээд Инженер               | 1 удаа ял шийтгүүлсэн |           |   |   |                                | 8 жил 1 сар хорих ял оногдуулсан    |

**Батлав:** Эрүүгийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч

Профессор.....Ц.Бүдханд

Удирдагч: Профессор.....Ц.Бүдханд

Шүүмжлэгч: Магистр.....Б.Баттулга

**Чэнгис хааны нэрэмжит ” Их Засаг”  
Их сургуулийн магистрын зэрэг горилсон  
дипломын ажлын төлөвлөгөө**

**Сэдэв: Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэгтэй тэмцэх арга замыг  
боловсронгуй болгох зарим асуудал**

**Удиртгал**

**Нэгдүгээр бүлэг: Бусдын эд эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэгтэй тэмцэх  
эрх зүйн зохицуулалт.**

**1.1** Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтын  
түүхэн уламжлал.

**1.2** Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн ойлголт, үндсэн шинж, онцлог.

**Хоёрдугаар бүлэг: Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргээс  
урьдчилан сэргийлэх арга замыг боловсронгуй болгох нь**

**2.1** Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн шалтгаан нөхцөл.

**2.2** Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх  
арга зам.

**2.3** Гадаадын зарим улс орнуудын эрх зүйн зохицуулалт.

**Дүгнэлт**

**Хавсралт**

**Ном зүй**

Төлөвлөгөө боловсруулсан магистрын зэрэг горилогч

.....Б.Баттулга

## Удиртгал

### **Сэдвийг сонгон судлах болсон үндсэлэл:**

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийг 2002 оны Монгол Улсын Эрүүгийн хуулийн долдугаар хэсэг Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг, арван есдүгээр бүлэг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 147 дугаар зүйлд тусгагдсэн байна.

Манай орны Эрүүгийн нөхцөл байдлын онцлогоос үзэхэд бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг нийт гарч буй гэмт хэргийн 10 хүрэхгүй хувийг эзэлж, бага гарч байгаа мэт боловч энэ гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээдүүдийн 90 гаруй хувь нь таваас дээш 15 жилийн хугацаагаар хорих ял шийтгүүлж байна. Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг нь хүний оршин суугаа газар болон зан заншил, гэр бүлийн байдал, боловсрол, ажил мэргэжил, хүйс, нийгмийн хөгжлийн байдалтай уялдан үйлдэгддэг бөгөөд үйлдлийн арга хэлбэр, цаг хугацаа, нийгмийн хор аюулын шинж байдал нь өөр өөр байдаг. Зах зээлийн орой бусгаа энэ жилүүдэд амар хялбар амьдрахыг хүссэн этгээдүүд болон бусад шалтгаанаар бусдын бие махбодид халдан довтолж эд хөрөнгө болон эрүүл мэндэд нь хохирол учруулан зэрлэг авирлаж байна.

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийг үйлдэгсэдийн 80 гаруй хувь нь 18-35 насны буюу Монгол улсын ирээдүй болсон залуучууд үйлдэж байна. Монгол Улсын хэмжээнд авч үзвэл 2002 оны шинэ Эрүүгийн хууль дагаж мөрдсөнөөс хойш бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэгт оногдуулж буй ял шийтгэл нь хүнд, онц хүнд гэмт хэрэг буюу оногдуулах ялын хамгийн доод хэмжээ нь 5 жилээс дээш 15 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулж байна. Үүнээс болж энэ гэмт хэргийг үйлдэгсдэд доод тал нь таван жил нэг хоног болон түүнээс дээш 15 жил хүртэл хугацаагаар жирийн болон чанга дэглэмтэй хорих ангид ял эдлүүлж байна. Энэ гэмт хэрэгт хорихоос өөр төрлийн ямарч ял оногдуулах боломжгүйгээр хуульчлагдсан нь чангадсан байна. Дээрмийн гэмт хэрэг үйлдэгсдийн хувийн байдал маш ихээр нөлөөлж байна. Мөн дээрэмдэн авч буй зүйл нь анхаарлыг маш их татаж байна.

Иймээс бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн гаралтын шалтгаан нөхцлийг тогтоохын зэрэгцээ онол практик болон эрх зүйн талаас нь үнэлэлт дүгнэлт хийж цаашид энэ гэмт хэрэгтэй тэмцэх арга замыг боловсронгуй болгох, урьдчилан сэргийлэх асуудалд анхаарал хандуулахын тулд уг сэдвийг судлахаар сонгон авсан болно.

#### **Эрдэм шинжилгээний ажлын зорилго:**

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг нь оногдуулж буй ялын хувьд хүнд, онц хүнд гэмт хэрэг болдог. Мөн нийт энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгсдийн 80 гаруй хувь нь 18-35 насны анх удаагаа гэмт хэрэг үйлдэж буй залуучууд байдаг. Тэдгээрт оногдуулж буй ялын доод хэмжээ нь 5 дээш жилээр хорих ял оногдуулж байна. Өөр төрлийн ял оногдуулах боломжгүй байна. Мөн энэ гэмт хэргийн улмаас иргэдийн эд хөрөнгө төдийгүй амь нас, эрүүл мэндэд хохирол учруулдаг давхар объектой онцлог гэмт хэрэг юм. Иймээс бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийг шалтгаан нөхцлийг тогтоохын зэрэгцээ практик болон эрх зүйн үндэслэлтэй судалгааг, дүгнэлтийг хийх, цаашид уг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга замыг боловсронгуй болгоход анхаарлаа хандуулж, энэхүү гэмт хэргийн гаралтын тоо багасгахад эрдэм шинжилгээний ажлын гол зорилго болно.

#### **Сэдвийн судлагдсан байдал:**

Манай улсын хууль зүйн шинжлэх ухааны анхны эрдэмтэн болох Р.Гүнсэн 1965 онд “Улс хоршооллын хөрөнгийг ашиглан шамшигдуулах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага” сэдвээр дэд доктор, 1974 онд “БНМАУ-д Социалист хөрөнгө хамгаалах эрүүгийн эрх зүйн болон криминологийн асуудал” сэдвээр Хууль зүйн шинжлэх ухааны докторын зэргийг Москва хотноо хамгаалсан, 1972 онд “Хөрөнгөтний биш хөгжлийн замаар социализмд шилжихэд улс хоршооллын өмчийг хамгаалах асуудал” гэсэн бүтээл гаргасныг эс тооцвол бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэгтэй тэмцэх талаар онол, практикийн дагнасан бүтээл одоохондоо гаргаагүй ба зарим эрдэмтэн судлаачид энэ талаар өөрсдийн бүтээлүүдэд зохих хэмжээгээр тусгасан байна. Тухайлбал: ХЗШУ-ны профессор Ж.Авхиа, Г.Совд, доктор, дэд профессор С.Жанцан, академич С.Нарангэрэл зэрэг эрдэмтэн судлаачид өөрсдийн бүтээдээ дээрмийн гэмт хэргийн талаар зохих хэмжээнд судалгаа шинжилгээг дурьдсан байна.

**Эрдэм шинжилгээний ажилд хэрэглэсэн арга зүй:**

Сэдэвт заагдсан бүтээлийг боловсруулахын тулд сэдэвтэй холбогдох бүхий л хууль тогтоомж, судлаачдын бүтээлд задлан шинжилгээ хийж, тодорхой судалгаан дээр харьцуулан судалсан болно. Нийгмийн шинжлэх ухаанд нийтлэг хэрэглэгддэг ерөнхий болон тусгай аргуудаас хэрэглэсэн. Тухайлбал: танин мэдэхүй, диалектик аргад суурьлан бичсэн бөгөөд нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх, индукц, дидукц, харьцуулах, түүхчлэх, статистик, анкетын болон ярилцагын аргуудыг ашигласан болно.

**Эрдэм шинжилгээний ажлын зорилт:**

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн үйлдлийн арга, хэрэгсэл, гэмт хэрэг үйлдэх болсон шалтгаан нөхцөл, хэрэгтний хувийн байдал, хохирогчийн гэм буруу, эрх зүйн зохицуулалт, түүхэн уламжлал, шүүхийн практикт хэрхэн шийдвэрлэж байгаа байдлыг судлаж илрүүлэхийн зэрэгцээ энэхүү гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, тэмцэх арга замыг нарийн боловсронгуй болгоход анхаарах асуудлуудыг нээн илрүүлж, цаашид онол практикт хэрэглэн уг гэмт хэргийн гаралтыг бууруулахад бага ч гэсэн хувь нэмэр оруулахад уг эрдэм шинжилгээний ажлын зорилт оршино.

**Эрдэм шинжилгээний ажлын шинэлэг тал, ач холбогдол:**

Уг судлагдаж буй сэдвийн талаар онол, шүүхийн практикт хэрхэн шийдвэрлэж буй талаас харьцуулан дүгнэлт хийж, практикт тулгамдаж байгаа асуудлуудад дүн шинжилгээ хийж уг гэмт хэргийн шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга замыг боловсронгуй болгох зарим саналыг дэвшүүлэн гаргах ач холбогдолтой гэж үзэж байна.

**Эрдэм шинжилгээ судалгааны ажлын бүтэц:**

Магистрийн зэрэг горилон бичсэн энэхүү дипломын ажил нь 2 бүлэг, 5 зүйлтэй.

## **Нэгдүгээр бүлэг**

### **Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэгтэй тэмцэж буй арга зам, эрх зүйн зохицуулалт**

#### **1.1 Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтын түүхэн уламжлал.**

Монгол улс Үндсэн хуулиндаа монголын ард түмэн бид төрт ёс, түүх соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж эх орондоо хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно... гэж заасан билээ.

Хүннү гүрний хууль нь хориглох заншилд тулгуурласан хууль байсан бөгөөд тус хуульд ангийн ялгааг ихээхэн гаргажээ. Хүннү нарын дараа Монгол нутагт Тоба, Сяньби, Нирун, Түрэг, Уйгар зэрэг төрт улсууд нь өөрсдийн онцлог шинжийг тусгасан хуулийг баримтлан дагаж мөрдөж байв. Тухайлбал: Түрэгийн хуулиар бослого тэмцэл гаргагсад, төрд урван тэрслэгчид чөдөртэй морь хулгайлагсад, бусдын гэргийтэй нөгцөгсдөд алах ял оноож байсан бөгөөд чөдөртэй мориноос өөр зүйл хулгайлагсдад түүний өртгийг арав нугалж төлүүлнэ... хэмээн заасан байна.

Монголын хууль цаазын томоохон эх сурвалж бол. Монголын нууц товчоо бөгөөд түүнд эрүүгийн цаазад холбогдолтой зүйл нь өшөө хонзон авах, хулгай дээрэм хийх, хүн алах зэрэгт ор босгох зарга шүүх, дөнгө зүүх айл хэсүүлэх<sup>1</sup> зэрэг ял оноодог байв. 13-р зууны үед монгол оронд үйлчилж байсан хууль цаазын аугаа их бичиг Чингис хааны “Их засаг” хууль юм. Тус хуулийг Чингис хаан их ор суух үед хуралдуулсан хуралдаанаар батлан тунхаглажээ.

Монгол Ойрадын хууль батлагдсан ба хуулийн эрүүгийн заалтуудаас үзвэл хүний амьжиргааны хэрэгслийн хулгайлах, бусдын эд юмыг эзнийх нь

---

<sup>1</sup> МУИС. Эзэн богд Чингис хааны Их Засаг хууль. 1995

зөвшөөрөлгүй худалдах зэргийг өмчийн эсрэг гэмт хэрэгт оруулан тооцсон бөгөөд энэ дээрмийн талаар тодорхой заалт үгүй байна. Дээрх өмчийн эсрэг гэмт хэрэгт ял шийтгэлийг оногдуулахдаа мөн л амьжиргааны болон ахуйн хэрэглээний талаас нь ангилж ялын ялгамжтай оногдуулдаг байжээ.

Монголын хууль цаазны хамгийн шилдэг нь Халх журам мөн. Халх журмыг 1709-1796 оны хооронд халхын хаад ноёд өөр өөр газар бүгд 14 удаа хуралдаж тогтоосон. “Халх журам” хуулийн 2-р бүлэгт хулгайн цаазыг хуульчилсан ба тэр дотроо дээрмийг хуульчилжээ. Жишээлбэл: “Дээрэмчнийг үзээд эс зарлаваас нэг өст, зар таслаад дээрэмчин мал булаах ба хүн албал зар таслагч хүн гурван өст, хэн нэгэн хүн хулгай дээрэмд цохилт сайн хийвээс ноён нь шан хайрла”, “Гадны хүнээс хүн босч ирж адуу хөөн иржээ. Хуврагын шавь нар хийд сахигчид зарласаар байтал эс очвол баань /ял/ хийд сахигчдаас 2 хязаалан морь авах”, “Аливаа илт хулгай /дээрэм/ хийсэн хүнийг дээдийн хуучин цаазын ёсоор алаадз гэр мал ба эмхүүхэд сэлтийг цөм малын эзэнд өг”, “Илт хулгай хийж баригдсан хүнийг хэдэн хулгайч байсан бүгдийг нь 80 ташуурдаж 2 гарыг хавсарч төмрөөр бугуйвчлан хадаад 1 жил байх ахул малын эзэн ноёнд тушааж тавь, хёр дахин хугай хийсэн хүнийг хоёр жил болох ахул мөнхүү тэр ёсоор хадаж хадгалаад мөн ёсоор тавь, гурван үе хулгай хийвээс насан турш хадаж буу тавь<sup>2</sup>”

1921 онд Ардын хувьсгал ялснаар хуучин төрийн байгууламжийг устгаж, хууль цаазыг нь шинэчлэх шаардлага нийгмийн хөгжлийн зүй тогтлын дагуу үүсэж бий болжээ. Хууль цаазыг өөрчлөн шинэчлэх үеийн гол зорилго нь Манжийн үед Монголын ард түмэнд хэрэглэж байсан феодалын эрүү шүүлтийг хүчингүй болгон шинэ төртэйгөө зохицсон хууль цаазыг боловсруулан гаргах, улмаар төрийн байгуулал, шүүхийн системийг боловсруулах явдал байлаа. Тухайн үеийн Эрүүгийн хууль тогтоомжийн нэг эх сурвалж нь Ардын засгийн газраас гаргасан хууль эрхийн акт бөгөөд 1921 оны 7-р сарын 16-ны 4-р хурлын тогтоолд “Гэмт хэрэгт холбогдогчийн бурууг нотлох баримтанд тулгуурлан тогтоох ба эрүү шүүлт хэрэглэх, бие мах бодийг зовоох зэргийг хориглосон байна. 1921 оны 8-р сарын 3-ны өдрийн 5-р тогтоолд зааснаар албадан хөдөлмөр хийлгэх түүнчлэн 1924 оны 6-р сарын 29-ны өдрийн 18-р тогтоолоор эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүйчүүд, тахир дутуу бологсод, жирэмсэн эмэгтэйчүүдэд оногдуулсан хорих ялыг хэтрүүлэн эцэг эх ойр төрлийн

---

<sup>2</sup> Жалан-Аажав “Халх журам” 1995 он 273-р зүйл

хүмүүст шилжүүлж, хорих ялын өдрийн тоогоор албадан хөдөлмөр хийлгэхээр тогтоожээ.” Энэ мэтчилэн Ардын засгийн газраас удаа дараалан тогтоол гаргаж хууль цаазны шинэчлэлтийг явуулж байсан нь нийгмийн хөгжил дэвшилд ихээхэн түлхэц болсон юм.

Монгол улсын анхны эрүүгийн хууль болох **Шүүх цаазын бичиг**-ийн ерөнхий анги, тусгай ангийг 1926 оны 1-р сарын 11, 15-нд тус тус батлан улс орон даяар дагаж мөрдөхийг батлан хуульчилжээ.

Тус хуулийн 212-р зүйлд зааснаар “Буу зэвсэг хэрэглэж бусдын эд юмыг хүчирхэн дээрэмдсэнийг гурваас долоон жил гяндан хорихоос гадна хэрэв зэвсэг хэрэглэн олон хүний нэвтрэх зам сүвийг тосож эд юмыг дээрэмдэх эсвэл гурваас дээш тооны хүмүүс бүлэглэн зэвсэг хэрэглэн дээрэм хийх аваас<sup>3</sup> долоогоос арван жил хүртлэх хугацаагаар гянданд хорино., хэрэв хүнийг алвал цаазаар авбаас зохин ...” гэжээ.

1934 оны “Шүүх цаазын бичиг”-ийг баталжээ. Үүнтэй уялдан хөгжин улсын ба хоршооллын өмч хөрөнгийг улам сайжруулж, ашиглан шамшигдуулагчдад хүлээлгэх хариуцлагын хэлбэр халдагчийн байдлыг харгалзан тогтоох явдал зайлшгүй шаардлагатай болсон бөгөөд энэ уг Шүүх цаазын бичигт тусгалаа олжээ. Тус хуулийн 7-р бүлгийн 141-р зүйлд зааснаар ”... Бусдын эд хөрөнгийг уул эзэн хүний нүдний өмнө илтээр хулгайлж дээрэмдэн авсан бол нэгээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэвэл зохино. Мөнхүү илтээр хулгайлж дээрэмдэх явдлыг хэд хэдэн хүмүүсээс бүлэглэн үйлдсэн уул хохирсон хүнийг хүнд гэмтээн тахир дутуу болгох ба үхүүлсэн бол гурваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэвэл зохино.

1940 онд БНМАУ-ын Үндсэн хууль батлагдан гарч уг хуулийн 5,7,8- р зүйлүүдэд социалист өмчийн харилцааг бататган бэхжүүлэх талаар тунхаглаж, улс хоршоолол олон нийтийн өмч хөрөнгийг хамгаалан бэхжүүлэх явдлыг БНМАУ-ын иргэн бүрийн ариун үүрэг болгон тогтоосон байна. 1942 оны 1-р сарын 14-ны өдөр Улсын 25-р бага хурлаар эд хөрөнгийг ашиглан шамшигдуулах гэмт хэрэг үйлдэгчдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын талаар хэд хэдэн зүйлийг шинээр оруулжээ.

1990 оны 12-р сарын 28-ний өдөр /БНМАУ-ын иргэний хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсан. Тус хуулиар өмч нь нийтийн, хувийн

---

<sup>3</sup> Д.Адъяабазар.Монгол Улсын 1921 оноос хойшхи эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. 1998 он 32 дахь тал



холимог хэлбэртэй болж төр нь өмчийн олон хэлбэрийг хүлээн зөвшөөрч өмчлөгчийн эрхийн хуулиар хамгаалах зорилгоор Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсан бөгөөд 1986 оны Эрүүгийн хуулийн 3-р бүлэгт заасан социалист өмчийн эсрэг гэмт хэрэг, 5-р бүлэгт заасан иргэдийн амьны өмчийн эсрэг гэмт хэргийг 3-р бүлэгт нэгтгэн бусдын өмчийн эсрэг гэмт хэрэг болгон өөрчлөн найруулжээ. Эрүүгийн хуулийн 125-р зүйлийн 1-т зааснаар ...Бусдын эд хөрөнгийг авах зорилгоор иргэдийн амь нас, эрүүл мэндэд аюултайгаар хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж довтолсон бол гурваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Уг зүйлийн 2 дахь хэсэгт энэ үйлдлийг урьд бусдын эд хөрөнгийг авах зорилгоор дээрэмдсэн, зандалчилсан гэмт хэрэг үйлдсэн этгээд буюу онц аюултай гэмт хэрэгтэн эсхүл зохион байгуулалттай бүлэг этгээд орон байр агуулах саванд хууль бусаар нэвтэрч хийсэн уг үйлдлийг хийхдээ зэвсэг буюу бусад зүйлийг зэвсгийн чанартайгаар хэрэглэсэн, уг үйлдлийн улмаас иргэдийн бие махбодид хүнд гэмтэл учирсан буюу уг үйлдэл нь бусдын эд хөрөнгийг их хэмжээтэй авахад чиглэсэн бол арваас хорин таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж заажаа. Дээрх заалтаас үзвэл 125-р зүйлийн 1 дэх хэсэгт байсан эд хөрөнгө хураах ял 125-р зүйлийн 2 дахь хэсэгт заасан эд хөрөнгө хураах ял, нутаг зааж хорих зэрэг ялыг хассан байна. Мөн 1987 оны Эрүүгийн хуулийн 125-р зүйлийн 2 дахь хэсэгт заасан урьдчилан тохиролцсон бүлэг этгээд гэдгийг зохион байгуулалттай бүлэг этгээд болгон өөрчлөн найруулжээ. 125-р зүйлийн 2 дахь хэсэгт наймаас арван таван жилийн хорих ял оноож байсныг арваас хорин таван жил болгон ихсэгжээ.

## **1.2 Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт**

### **ойлголт үндсэн шинж**

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийг Монгол Улсын Эрүүгийн хуулийн долдугаар хэсэг Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг, арван есдүгээр бүлэг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 147 дугаар зүйлд тусгагдсэн байна. Үүнд:

.....Бусдын эд хөрөнгийг авах зорилгоор амь биед нь аюултайгаар хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж довтолсон бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<sup>4</sup>

---

<sup>4</sup> Монгол Улсын Эрүүгийн хууль 2002 он Төрийн мэдээлэл сэтгүүл №5

.....Энэ хэргийг давтан, бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, урьд энэ гэмт хэрэгт болон булаах, далайлган сүрдүүлэх гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд үйлдсэн, эсхүл зэвсэг, зэвсгийн чанартай бусад зүйл хэрэглэсэн, энэ хэргийн улмаас бусдад их хэмжээний хохирол учирсан бол наймаас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

.....Энэ хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл, урьд нь уулгалан довтлох гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд үйлдсэн, энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол, бусдын бие махбодид хүнд гэмтэл учирсан бол эд хөрөнгийг хурааж арваас дээш хорин таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэжээ.

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг нь өмчийн эсрэг гэмт хэргийн дотроос хамгийн хүнд гэмт хэрэг юм

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн бүрэлдэхүүнийг нарийвчлан авч үзвэл.

**Дээрэмдэх гэмт хэргийн бүрэлдэхүүний объект нь<sup>5</sup>:**

Бусдын өмчийн эрх бөгөөд уг өмчийн эд зүйлийг эзэмших, ашиглах, хамгаалж байгаа хүний амь бие, эрүүл мэндэд халддаг давхар объектод байдаг тул өмчийн эсрэг гэмт хэргийн хамгийн хүнд нь юм.

**Дээрэмдэх гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив тал нь:**

Бусдын өмчийн эд хөрөнгийг өөрийн өмч болгохын тулд биеийн болон сэтгэхүйн хүч хэрэглэсэн буюу тийм хүч хэрэглэхээр довтлох үйлдлээр илэрнэ..

Дээрэмдэх гэмт хэргийн хүчирхийллийн эрчим болон зорилго нь уг өмчийн эд зүйлийг эзэмших, ашиглах, хамгаалж байгаа хүний амь бие, эрүүл мэндэд аюул учруулах шинжтэй байдаг. Үүгээрээ хүч хэрэглэж булаах гэмт хэргээс ялгагдана. Булаах хэргийн хүч хэрэглэж үйлдэхэд гэмт этгээд эд хөрөнгөө хүчээр авах боловч хүчирхийллийн эрчим нь төвөөс зугатах шинжтэй. Өөрөөр хэлбэл эд зүйлээ хүчээр авахаас биш хүний эсэргүүцлийг эргүүлэн хүчээр дарах чиглэл байдаггүй. Гэтэл дээрэмдэх хэргийг үйлдэгч нь эд хөрөнгө авах үндсэн арга түүнийг тухайн үед эзэмшиж, ашиглаж, хамгаалж байгаа хүний амь бие, эрүүл мэндэд хүчээр хор хохирол учруулах төврүү тэмүүлэх чиглэлтэй хүчирхийлэл байдаг.

---

<sup>5</sup> Г.Совд. Монгол Улсын Эрүүгийн хуулийн талбар. УБ. 2002 он. 219, 220 дахь тал

Дээрэмдэх гэмт хэргийн хүчирхийлэл нь биеийн болон сэтгэхүйн аль ч хэлбэртэй байж болно. Биеийн хүчирхийлэл нь бусдын эрхэнд халдаж зодох, шархтуулахаас эхлээд янз бүрийн зэвсэг хэрэглэж халдах хэлбэрүүдтэй байж болно.

Сэтгэхүйн хүчирхийлэл гэдэг нь айлган сүрдүүлсэн тулгарсан заналхийлэл байдаг. Хэрэв эд хөрөнгийг шилжүүлэн өгөхгүй бол түүний амь бие, эрүүл мэндэд аюул учруулахаар бэлэн байгаа нь бодитой болсон байдаг.

“Сэтгэхүйн хүч хэрэглэх” гэдэг нь хохирогчийн амь бие, эрүүл мэндэд аюултайгаар хүч нэн даруй хэрэглэхээр заналхийлнэ гэсэн үг бөгөөд энэ нь үг яриа, үйл хөдөлгөөний хэлбэрээр илэрч болно.<sup>6</sup>

Дээрэмдэх гэмт хэргийн бүрдэл нь эд зүйл авсан эсэх, хүний амь бие, эрүүл мэндэд аюул учруулсан эсэхээс шалтгаалахгүй тийм шинжтэй хүчирхийлэл хийх довтолгоон эхэлснээр төгсдөг онцлогтой.

#### **Дээрэмдэх гэмт хэргийн бүрэлдэхүүний субъект нь:**<sup>7</sup>

14 насанд хүрсэн, сэтгэхүйн хувьд хэрэг хариуцах чадвартай этгээд Монгол Улсын иргэн, гадаадын харъяат, аль ч улсын иргэн биш хүн байж болно.

#### **Дээрэмдэх гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив тал нь:**

Шунахай сэдэлттэй бөгөөд бусдын эд хөрөнгийг өөрийн болгон хүчээр авах зорилготой шууд санаатай байдаг.

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн хүндрүүлэх болон онц хүндрүүлэх бүрэлдэхүүнийг нэг бүрчлэн нарийвчлан авч үзье. Үүнд:

#### **Давтан үйлдэх**

Гэмт хэрэг давтан үйлдэхийг эрүүгийн хуулийн 18 дугаар зүйлд заажээ. Үүнд:

.....Энэ хуулийн нэг зүйл, түүний нэг хэсэгт заасан гэмт хэргийг хоёр буюу түүнээс дээш удаа үйлдсэн байхыг давтан гэмт хэрэг гэнэ. Энэ хуулийн тусгай ангийн хэд хэдэн зүйл, хэсэгт заасан хоёр буюу түүнээс дээш гэмт хэрэг үйлдэх нь зөвхөн тусгай ангид заасан тохиолдолд давтан гэмт хэрэгт тооцогдоно.

.....Хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдсөн, ялгүй болсон, ялгүйд тооцогдсон этгээд гэмт хэрэг шинээр үйлдсэн нь давтан гэмт хэрэг болохгүй.

---

<sup>6</sup> Монгол Улсын Дээд Шүүхийн тогтоолын эмхтгэл 2004 он 361 дэх тал

<sup>7</sup> Г.Совд. Монгол Улсын Эрүүгийн хуулийн талбар. УБ. 2002 он. 220, 221 дэх тал

Дээрмийн гэмт хэргийг давтан үйлдэнэ гэдэг бол дээрмийн хэргийг тус тусдаа бүрдэлтэй хоёр буюу түүнээс дээш удаа үйлдэхийг хэлэх бөгөөд урьд нь шийтгүүлсэн шийтгүүлээгүй аль аль нь хамаарна. Харин түрүүчийн дээрмийн үйлдлээс хойш одоо шийтгүүлж байгаа үйлдэл хүртэл хөөн хэлэлцэх хугацаа өнгөрөөгүй буюу түрүүчийн шийтгүүлсэн хэргээс хойш ял шийтгэлгүйд тооцогдоогүй байх учиртай. Гэмт хэргийг давтан үйлдэх нь 147.2 зааснаар хүндрүүлэх нөхцөлд орно.

### **Гэмт хэрэгт хамтран оролцох хэлбэр<sup>8</sup>**

.....Хоёр буюу түүнээс дээш этгээд урьдчилан үгсэж тохиролцоогүй боловч гэмт хэрэг үйлдэхдээ санаатай нэгдсэн бол бүлэглэн гүйцэтгэгч гэнэ.

.....Гэмт хэрэг хамтран үйлдэх талаар урьдчилан үгсэж тохиролцсон хоёр буюу түүнээс дээш этгээдийг урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг гэнэ.

Үүнийг Эрүүгийн хуулийн 147.2 дахь хэсэгт хүндрүүлэх бүрэлдэхүүнд тусгасан байна.

.....Гэмт хэрэг үйлдэхийн тулд урьдчилан нэгдсэн, тогтвортой бүлгийг зохион байгуулалттай бүлэг гэнэ.

.....Гэмт хэрэг үйлдэж ашиг олох зорилготой, бүтэц, зохион байгуулалт бүхий этгээдүүдийн нэгдлийг гэмт бүлэглэл гэнэ.

Үүнийг Эрүүгийн хуулийн 147.3 дахь хэсэгт онц хүндрүүлэх бүрэлдэхүүнд тусгасан байна.

### **Зэвсэг болон зэвсгийн чанартай бусад зүйл**

Зэвсэг болон зэвсгийн чанартай бусад зүйлийг хэрэглэсэн гэдэгт халуун, хүйтэн зэвсэг юуны өмнө орно. Халуун зэвсэг гэдэгт тэсрэх бодисын хүчээр амьд биеийг устгах чадалтай зэвсэг орох бөгөөд үүнд гар хийцийнхээс эхлээд байлдааны зориулалт бүхий бүх төрөл, хэлбэрийн буу хамаарна. Хүйтэн зэвсэг гэдэг нь хатгах, огтлох, үйлчилгээгээр амь биеийг устгах гэмтээх чадалтай, жад, сэлэм, хутга, сүх, хайч хүртэл хамаарна.

Зэвсгийн чанартай бусад зүйл хэрэглэсэн гэдэгт халуун, хүйтэн зэвсгээс гадна хүний амь бие, эрүүл мэндэд хор хүргэх чадалтай, эд зүйлийг зориуд бэлтгэн хэрэглэснийг ойлгоно. Үүнд: муна, лантуу, лом, төмөр нударга, ташуур хүртэл хамаарна. Гэхдээ энэ бол тусгай зориулсан зүйл байх учиртай. Иймд

---

<sup>8</sup> Монгол Улсын Эрүүгийн хууль 2002 он Төрийн мэдээлэл сэтгүүл №5

тухайн тодорхой нөхцөлд тохиолдлоор олдсон зүйлийг хэрэглэснийг бусад зэвсгийн чанартай хэрэглэсэн гэж үзэж болохгүй.

Монгол Улсын Дээд Шүүхийн талбарт<sup>9</sup>

”Зэвсэг” гэдэгт бүх төрлийн галт болон хүйтэн зэвсэг хамаарна.

“Зэвсгийн чанартай хэрэглэсэн бусад зүйл” гэдэгт гааз, сүх, царил, алх, бороохой гэх мэт бусдын амь бие, эрүүл мэндэд гэмтэл учруулж болох бусад зүйлийг тус тус ойлгоно.

“Хэрэглэсэн” гэдэгт зэвсэг болон бусад зүйлээр довтолгоонд өртөгчийн амь бие, эрүүл мэндэд хохирол учруулах, тэдгээрээр сүрдүүлэхийн аль алиныг хамааруулсан үйлдэл болно.

Зэвсэг болон зэвсгийн чанартай зүйл хэрэглэн довтолсон бол энэ нь хэрэглэсэн гэсэн үг юм. Тухайн зүйлээр гэмтэл учруулсан үгүйгээс үл хамааран хэрэглэсэнд тооцно.

Зэвсгийн хэлбэртэй зүйл хэрэглэснийг хохирогч зэвсэг гэж андуурч ойлгосон боловч уул зүйл нь гэмтэл бодитойгоор учруулж чадахгүй бол хэргийг зэвсгийн чанартай зүйл хэрэглэсэн гэж зүйлчлэхгүй.

### **Хохирлын хэмжээг тодорхойлох**

Эрүүгийн хуулийн 147.2 дахь хэсэгт хүндрүүлэх бүрэлдэхүүний шинж болох их хэмжээ, 147.3 дахь хэсэгт онц хүндрүүлэх бүрэлдэхүүний шинж болох онц их гэдгийг Эрүүгийн хуулийн 29 дүгээр зүйлийн тайлбар. Үүнд:

.....Гэмт хэрэг үйлдэх үед мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид заасан нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун хорин таваас дээш хоёр зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээг их, хоёр зуугаас дээш дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээг онц их гэж тооцон хохирлын хэмжээг тодорхойлно<sup>10</sup>.

Улсын Их хурлын тогтоолоор 2007 оны 10 сарын 01-ний өдрөөс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 90000 төгрөгөөр тогтоосон. Бусдын эд хөрөнгийг их хэмжээтэй авах зорилготой довтолсон бол тэр хэмжээний эд хөрөнгө байсан эсэх, авч чадсан эсэхээс хамаарахгүйгээр уул хэргийг бусдын эд хөрөнгийг их хэмжээтэй дээрэмдсэн гэж зүйлчилнэ.<sup>11</sup>

---

<sup>9</sup> Монгол Улсын Дээд Шүүхийн тогтоолын эмхтгэл 2004 он 361 дэх тал

<sup>10</sup> Монгол Улсын Эрүүгийн хууль 2002 он Төрийн мэдээлэл сэтгүүл №5

<sup>11</sup> Монгол Улсын Дээд Шүүхийн тогтоолын эмхтгэл 2004 он 362 дахь тал

### **Хүнд гэмтэл учруулах**

Бусдын бие махбодид хүнд гэмтэл учруулсан бол онц хүндрүүлэх нэгэн шинж болж байна. Дээрэмдэх гэмт хэргийг үйлдэхдээ бусдын бие махбодид учруулсан гэмтлийн зэргийг шүүх эмнэлэгийн шинжээчийн дүгнэлтээр тогтоолгох ёстой. Хүнд гэмтлийн хууль зүйн ойлголтыг Эрүүгийн хуулийн 96 дугаар зүйлийн тайлбартай адилаар ойлгож хэрэглэх учиртай. 96 дугаар зүйлд:

#### **Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийг төсөөтэй**

##### **бусад гэмт хэргээс ялган зүйлчлэх нь**

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн бусад төсөөтэй гэмт хэргээс ялгагдах онцлогийг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнээр нь авч үзье. Юуны өмнө дээрмийн гэмт хэрэгтэй практикт хамгийн ихээр алдаж зүйлчлэгддэг хэргийг авч үзье. Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг нь бусдын эд хөрөнгийг булаан гэмт хэргээс дараах шинжээр ялгагдана. Үүнд:

1.Бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэрэг нь бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргээс үйлдлийн аргаараа ялгагдна. Булаан гэмт хэрэг нь төвөөс зугтаасан шинжтэй байдаг. Харин дээрмийн гэмт хэрэг нь төврүү чиглэсэн байдаг. Булаан гэмт хэрэг хүч хэрэглэж болон хүч хэрэглэхгүйгээр булаах гэсэн 2 хэлбэртэй бөгөөд хүч хэрэглэж булаах үед гэмт этгээд нь илээр буюу бусдын нүдний өмнө хохирогчийн биед аюулгүйгээр зөвхөн түлхэх, угзрах гэсэн хэлбэрээр хүч илэрч болох бөгөөд энэ үед хохирогчийн биед яльгүй гэмтэл учирна. Дээрмийн гэмт хэрэгт гэмтэл учрахаас гадна тийм аюул учруулах нөхцөл байдал үүсдэггүй. Түүнчлэн дээрмийн гэмт хэргийн үед хохирогч нь гэмт этгээдээс айж улмаар амь нас, эрүүл мэндээ хамгаалахаар эд зүйл, мөнгөө гаргаж өгөх болон гэмт этгээд нь хохирогчийн биед далд байгаа зүйлийн нэгжин авдаг. Мөн хувцас болон гутлыг нь тайлуулан авдаг.

Дээрмийн гэмт хэргийн үед хэрэглэж байгаа буюу хэрэглэхээр заналхийлж байгаа хүч нь биеийн буюу сэтгэл зүйн шинжтэй байж болох бөгөөд учрах үедээ довтолгоонд өртөгсдийн амь бие, эрүүл мэндэд бодитой аюул учруулдаг буюу учруулж болзошгүй байдгаараа хүч хэрэглэж булаах гэмт хэргээс ялгагдана.

Булаах гэмт хэрэг нь бусдын амь бие, эрүүл мэндэд аюулгүйгээр хүч хэрэглэхдээ хохирогчийн буюу бусад хүмүүсийн амь бие, эрүүл мэндэд аюул

учруулаагүй үйлдэл байна. Энэ нь түлхэх, хүлэх, байранд нь оруулж түгжих, амыг нь боох зэрэг үйлдлээр илэрч болно. Булаах үйлдлийн үед хэрэглэсэн хүчний улмаас улайх, зулгарах зэрэг түргэн эдгэрэх хөнгөн гэмтэл учирсан байж болно. Эд хөрөнгө авахын тулд хүч хэрэглэснээс үүсэн гэмтэл нь шинж чанар, зэргийн хувьд үүнээс хэтэрч эрүүл мэндийг сарниулах, хөдөлмөрийн чадварыг бага боловч алдагдуулахад хүргэсэн бол дээрмийн гэмт хэргийн шинжтэй болно<sup>12</sup>.

2.Бүрэлдэхүүний хэлбэрээр ялгаатай. Булаах гэмт хэрэг нь материалаг бүрэлдэхүүнтэй бөгөөд бусдын эд хөрөнгийг булаан авч өөрийн болон бусдын эзэмшилд шилжүүлснээр бүрэлдэхүүн бүрэн төгсдөг. Харин дээрмийн гэмт хэрэг нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй. Бусдын эд хөрөнгийг авахаар хүч хэрэглэж болон хүч хэрэглэхээр заналхийлэн довтолсон үеэс бүрэлдэхүүн төгсөж төгссөн гэмт хэрэгт тооцно.

Бусдын эд хөрөнгийг дээрэдэх гэмт хэрэг нь будсын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргээс дараах шинжээр ялгагдана. Үүнд:

1.Объектоор – хулгайн гэмт хэргийн объект нь өмч лөх эрх байдаг бол дээрмийн гэмт хэргийн объект нь өмчлөх эрхээс гадна иргэдийн амь нас, эрүүл мэнд байдаг.

2.Үйлдлийн аргаараа – хулгайлах гэмт хэргийн үед өмчлөгчийн нүднээс далдуур нууц далд аргаар гэмт үйл ажиллагаа хэрэгждэг бол дээрмийн гэмт хэргийн үед өмчлөгч этгээдэд хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж түүний нүдэн дээр эд хөрөнгийг авдаг.

Бусдын эд хөрөнгийг дээрэдэх гэмт хэрэг нь будсын эд хөрөнгийг авахаар далайлган сүрдүүлэх гэмт хэргээс дараах шинжээр ялгагдана. Үүнд:

1.Үйлдлийн аргаараа ялгагдана – Далайлган сүрдүүлэх гэмт хэргийн үед өмчлөгч буюу түүний ойр дотны хүмүүст хүч хэрэглэн, нэр төрийг нь гутаасан мэдээ баримт тараана гэж сүрдүүлж заналхийлэх ба энэхүү заналхийлэх нь дээрмийн гэмт хэрэг шиг тэр даруйдаа хэрэгжих биш хэсэг хугацааны дараа хэрэгжих магадлалтай.

2.Мөн далайлган сүрдүүлэх гэмт хэргийн илэрэл нь нэр төрийг нь гутаасан мэдээ, баримт тараана гэсэн заналхийллийн хэлбэрээр илэрдэг бол

---

<sup>12</sup> Монгол Улсын Дээд Шүүхийн тогтоолын эмхтгэл 2004 он 360-361 дахь тал

дээрмийн гэмт хэргийн заналхийлэл нь ална, буудна, хутгална гэх мэт заналхийлэл байдаг.

Бусдын эд хөрөнгийг дээрэдэх гэмт хэрэг нь будсын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэргээс дараах шинжээр ялгагдана. Үүнд:

1.Залилан мэхлэх гэмт хэрэг нь эд хөрөнгө, мөнгө, үнэт зүйлийг хуурч мэхлэх буюу түүний итгэлийг эвдэх замаар шунахай сэдэлтээр авч буй идвэхтэй үйлдэл юм.

2.Залилах гэмт хэргийн нэг гол шинж нь хохирогч этгээд нь хөрөнгөө гэм буруутай этгээдэд хуурч мэхлэгдэж буюу итгэл эвдэж сайн дураараа шилжүүлэн өгдөг.

## **Хоёрдугаар бүлэг**

### **Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэгтэй урьдчилан сэргийлэх арга замыг боловсронгуй болгох нь**

#### **2.1 Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн шалтгаан нөхцөл.**

Миний Дорноговь аймгийн Сум дундын 1-р шүүх, Сум дундын 2-р шүүхийн 2000 оноос 2007 он хүртэл дээрмийн гэмт хэргийн дэлгэрэнгүй судалгаа, Сонгинохайрхан дүүргийн шүүхийн 2004 оноос 2006 он хүртэл дэлгэрэнгүй судалгаа, Чнгэлтэй, Баянгол, Сүхбаатар, Хан-Уул, Баянзүрх дүүргийн шүүхийн 2004 оноос 2006 он хүртэл хийсэн судалгаагаар дээрмийн гэмт хэргийн 95 гаруй хувь нь хот суурин газарт үйлдэгдэж байгаа бөгөөд ихэвчлэн гудамж талбай,



орц, такси, вокзал хүний хөлнөөс зайдуу харанхуй / гэрэлтүүлэггүй/ газарт орой, үдшийн цагаар гарч байна. Дээрмийн довтолгооны ихэнх нь хохирогчийн халдаж зодсон, заналхийлсэн, сэтгэл санааны дарамтанд оруулсан, зэвсэг хэрэглэсэн гэх мэт үйдэлээр илэрч байна.

**Дээрмийн гэмт хэрэг үйлдэгсэн этгээдүүдийн нас:** нийт 585 хүнээс насанд хүрээгүй 71 хүүхэд, 18-35 хүртэлх насны хүн 456 хүн, 35 дээш насны хүн 23 хүн байна. 90 гаруй хувь нь 14-35 хүртэлх насны эрэгтэй хүмүүс үйлдэж байна.

**Дээрмийн гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийн хүйс:** эмэгтэй 54, эрэгтэй 531 хүн байна.

Энэ тоон үзүүлэлтийг харахад маш харуусалтай байна. Монгол Улсын маань ирээдүй болсон залуучууд маань торны цаана амьдралынхаа залуу насыг өгөрүүлж байна. Эдгээр хүмүүсээс хэд нь засран хүмүүжиж хэд нь гэмт хэргтний замаар замнах бол.

**Дээрмийн гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийн боловсрол:** боловсролгүй 32 хүн, бага боловсролтой 100 хүн, дээд боловсролтой 12 хүн, үлдсэн 441 хүн нь бүрэн бус дунд, тусгай дунд, бүрэн дунд боловсролтой хүмүүс байна.

**Дээрмийн гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийн урьд нь ял шийтгүүлсэн байдал:** эдгээр хүмүүсийн 80 гаруй хувь нь өмнө нь ял шийтгүүлж байгаагүй буюу анх удаагаа гэмт хэрэг үйлдсэн байна. Үлдэх 20 хувь нь ял шийтгүүлж байсан байна.

Дээрмийн гэмт хэргийг ихэндээ согтуугаар үйлдэж байгаа бөгөөд энэ гэмт хэргийн хохирогч нь согтуу байхдаа халдлагад өртсөн тохиолдол их байна. Дээрмийн гэмт хэрэг үйлдэгчдийн олонх нь боловсролын түвшин доогуур , 30 орчим хувь нь боловсролгүй, бага боловсролтой хүн байна.

Дээрмийн гэмт хэрэг үйлдэгчдийн ихэнх нь эрхэлсэн тодорхой ажилгүй, хөнгөн хялбар амьдрахыг хүсэгчид бэртэгчин хүмүүс байна. Тэдний 80 гаруй хувь нь ажил хөдөлмөр эрхэлдэггүй, согтууруулах ундаа хэрэглэдэг. Дээрмийн гэмт хэргийн 80 гаруй хувь нь согтуугаар үйлдэгдэж байна.

Дээрх судалгаанаас дүгнэн үзвэл дээрмийн гэмт хэргийн шалтгаан нөхцөл нь

### **1. Ажилгүйдэл:**

Ажилгүйдэл нь ямарч нийгмийн байгууллын үед бодитойгоор байдаг үзэгдэл бөгөөд зах зээлийн нийгэмд хөдөлмөрлөх нь хувь хүний эрх бөгөөд

өөрийн мэдлэг чадвао, авъяас, хүсэл сонирхол, мэргэжил болон өөрийнхөө боломжийн хэрээр ажил хөдөлмөр эрхэлдэг. Өнөөдөр гагцхүү манай оронд бус дэлхий даяар ажилгүйдэл ихэсч байна. Манай оронд ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн захад бүртгүүлсэн хүний тоо 32000 хүсэн байна. Гэхдээ бодит байдал дээр дээрх тоог 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний хүмүүс ажилгүй байна.<sup>13</sup> Ажил хөдөлмөр бол хувь хүний амьжиргаагаа залгуулах гол арга хэрэгсэл болдог бөгөөд ажилгүй хүн бол орлогогүй, амьжиргаа муу байх нь зүй ёсны хэрэг. Ажилгүй хүнд өдөр, хоног удаан өнгөрч уйдахын эрхэнд болохгүй, бүтэхгүй хүмүүстэй нийлж тэнэх, архидан согтууран гэмт хэрэг үйлдэхэд хүрдэг. Ажилгүй бол гэмт хэрэг үйлдэх шалтгаан болж байна. Энд тэмдэглэхэд ажилгүй байгаа хүмүүсийн олонх нь мэргэжилгүй, мэргэжилтэй ч түүндээ эзэн болоогүй, авъяас чадваргүй, ажиллах, сурах эрмэлзлэл муутай байна. Тэгэхдээ ажилгүй байх гол шалтгаан нь тэдэнд өөрсдөд нь байна. Монгол улсад ажилгүйчүүдийн тоо маш их байна. Энэ нь ажлын байр олдохгүй байгаа бус одоогийн залуус ажлын байр, цалин хөлсөө голж байгаатай холбоотой юм. Мөн ямарч үр дүнгүйгээр дээд сургуульд орж суралцан төгсөөд тухайн чиглэлээр ажиллах ажлын байр олдохгүй байна. Нийт дээрмийн гэмт хэрэг үйлдэгсэдийн 90 гаруй хувь нь ямар нэгэн эрхэлсэн тодорхой ажилгүй байна.

## **2. Архидан согтуурал:**

Гэмт хэргийн гаралтанд архидан согтуурлын нөлөөний тухай асуудал нь анхаарах хамгийн чухал тулгамдсан асуудал болоод байна. Согтуурал нь олон зууны турш хүн төрөлхтөнд хортой нөлөөгөө үзүүлсээр ирсэн бөгөөд манай улс зах зээлийн харилцаанд шилжсэн үеэс улам бүр газар авах болсон. Согтуурал нь гэмт явдлын нийгэм, сэтгэл зүйн шалтгааныг дэмжиж түлхэц өгч байдаг. Бөгөөд энэ нь нийгэмд харш зан ааш гаргах бодит нөхцөл байдал болдог. Хувь хүн нь эцэстээ хэнд ч хэрэггүй хор шаар нийгмийн шавхруу болдог. Согтуурал нь хүний мэдрэлийн системийн ажиллагаа, сэтгэхүй хэвийн байдлыг алдагдуулж, гадаад орчны нөлөөнд хэт цочромтгой хандаж зэрлэг, бүдүүлэг аашлах, хүнлэг ёс, иргэний үүрэг, хууль болон тогтоосон журмыг хүндлэхгүй болдог. “Архи шилнээсээ бусдыг дийлдэг” гэсэн ардын маань сургаал хүртэл бий. Архичид согтууруулах ундааг уухаа амьдралын зорилгоо болгож архины

---

<sup>13</sup> Ц.Цэлмэг Криминологи УБ. 2005 он 66 дахь тал

мөнгө олохын тулд гэмт хэрэг үйлдэхээс буцахгүй байдалд орох нь цөөнгүй. Энэ нь харгис хэрцгий, бүдүүлэг авирлах шалтгаан болж улмаар хүч хэрэглэсэн гэмт хэрэг үйлдэхэд хүргэдэг.<sup>14</sup>

Одоогийн залуус чөлөөт цагаа зохистой өнгөрүүлэх бус баар, цэнгээний газарт архи, согтууруулах ундааг хэт их хэрэглэн өөрийгөө жолоодох чадваргүй болж гэмт хэрэгтэн эсвэл хохирогч болж байна. Жил ирэх бүр архидалт улам залуужиж байна. Ялангуяа сүүлийн үед хүүхэд, эмэгтэйчүүд ихээр архидан согтуурах болж улмаар гэмт хэрэг, зөрчилд холбогдох болсон нь сэтгэл эмзэглүүштэй.<sup>15</sup> Манай улс нэг хүнд ноогдох спирт, архины хэмжээгээр дэлхийд тэргүүлэгчдийн эгнээнд орж 1 хүнд жилд 10 литр архи ноогдож байгаа. Хэрвээ архи уудаггүй, бага зэрэг уудаг хүмүүсийг хасаад тооцвол насанд хүрсэн нэг хүнд 22 литр буюу 44 шил архи ноогдож байна.

Энэ тоон дээр нэрмэл архи, пиво, дарс зэргийг нэмэгдүүлбэл ямар тоо гарах бол. Үүнээс болж гэмт хэрэг үйлдэх хүмүүсийн тоо өсөн нэмэгдсээр байна. Ганц дээрмийн гэмт хэрэг дээр бус бусад бүх төрлийг гэмт хэргийг үйлдэхдээ архидан согтуурсан байдал ихээр гарч байна. Манай залуучууд чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлэх газар байхгүй байна. Мөн шоудаж байгаа нь энэ гээд хэтэрлээ архи, согтууруулах ундаа хэрэглэж байгаа нь харамсалтай зүйл. Монголд бараг бүх дэлгүүрт архи зарж байна. Чанартай, чанаргүй маш олон төрлийн архийг үйлдвэрлэлийн болон үйлдвэрлэлийн бус нөхцөлд үйлдвэрлэн зах зээлд худалдаалж байна. Монгол улс архидалтаас нийгмээ цэвэрлэж чадахгүй бол хөгжин дэвшилт зогсоно.

### **3. Тэнүүчлэл:**

Манай орон зах зээлийн харилцаанд шилжин орсон 1990 оноос эхлэн орон, гэргүй хүмүүсийн асуудал хурцаар тавигдаж эхэлсэн. Өнөөдөр албан ёсны мэдээгээр 3500 хүүхэд болон насанд хүрэгсэд орон гэргүй тэнүүчилж байгаа гэдэг боловч бодит байдал дээрээ тэнүүлчдийн тоо 10000 гаруй байгаа гэсэн судалгааны дүн бидэнд байна. Орон гэр бол хүний амьдралын наад захын шаардлага бөгөөд орон гэргүй байна гэдэг бол сурч боловсрох, ажил хөдөлмөр эрхлэх, нийгмийн бусад эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болдог. Хэрхэн амь амь

---

<sup>14</sup> Ц.Цэлмэг Криминологи УБ. 2005 он 67 дахь тал

<sup>15</sup> Цагдаагийн академи “Гэмт явдалтай тэмцэх асуудал” УБ. 2005 он

зуулгаа залгуулдаг талаар ярилцахад 60 хувь нь хог түүдэг, бусад нь хулгай, дээрмийн замаар мөн гуйлга гуйх аргаар амьдардаг гэжээ.<sup>16</sup> Тэдгээр хүүхдүүдээс ямар нэгэн байдлаар гэмт хэрэг хийсэн талаар асуухад 76 хувь нь тийм, 34 хувь нь тэр л аргаар байнга амьдарч байдаа гэсэн байна. Энэ бүхнээс үзэхэд орон гэргүй хүмүүст нийгмийн харш зан төлөв гүнзгийрэн тогтсон., хууль зөрчихийг юманд бодохоо больсон, гэмт хэргийн замаар амьдардаг, нийгэм болон чинээлэг хүмүүсийг үзэн яддаг, өөрийгөө гэмт хэрэг үйлдэж байна гэж боддоггүй, ял шийтгэлээс айхаа больсон зэрэг шинжтэй байна.

#### **4. Ядуурал:**

Гэмт хэрэг үйлдэхэд суурь нөхцөл болдог. Өнөөдөр манай нийгэм баян, чинээлэг, дунд, ядуу, нэн ядуу гэсэн 5 хэсэгт хуваагдаж байгаа бөгөөд хүн амын 3 хүрэхгүй хувь нь дээд буюу баян чинээлэг хэсэгт хамрагдаж байна. Харин нэн ядуу хэсэгт 38 хувь нь хамрагдаж байгаа. 20 хувь нь дунд хэсэгт, үлдэх 35 хувь ядуу амьдарч байна.<sup>17</sup> Манай орон ядуучуудын тоо жил ирэх тусам нэмэгдэж байна. Хүн амын орлого өдрөөс өдөрт хомсдож, цөөн зарим нь өдрөөс өдөрт баяжиж юмны үнэ тэнгэрт хадаж байгаа цаг үед бид амьдарч байна. Төсвийн байгууллагын ажилчдын цалинг 30 хувиар өсгөсөн. Гэвч юмны үнэ дагаад л өссөн. Тэгээд дүндээ дүн болсон. Харин өдөрт 3000-5000 төгрөг өөрсдийн хөдөлмөрөөр олж авдаг хүмүүст улам муугаар нөлөөлж амьдралаа залгуулах чадваргүй болгож байна.

Ядуу амьдарч байгаа хүмүүс боловсрол, мэргэжил олж авах нөхцөл муутай, хүрээлэн байгаа орчин нь таагүй, нийгмийн баялагаас тун өчүүхэн хувийг хүртдэг учир оюун ухааны ядууралд ч нэрвэгдсэн байдаг. Тэдний хууль эрх зүйн мэдлэг дорой, ухамсар муу, гэмт хэрэг үйлдэхээс төдийлөн эмээхгүй, амьдрахын тулд яахаас ч буцахгүй шинжтэй. Мэдээж бүх ядуу хүмүүс нийгэмд харш зан төлөвтэй гэмт хэрэг үйлдэхэд бэлэн гэсэн хэрэг биш бөгөөд ядуурал нь гагцхүү гэмт хэрэг үйлдэх шалтгаан нөхцөл болж байна.

Монгол улсын 5-н иргэн бүрийн 3 нь нэн ядуу өрхөд хамрагдаж байна. Энэ манай нийгмийн хамгийн том дутагдал юм. Ядуурал манай нийгмээс арилаагүй тохиолдолд гэмт хэргийн тоо багасахгүй.

#### **5. Боловсрол, мэргэжил:**

---

<sup>16</sup> Ц.Цэлмэг Криминологи УБ. 2005 он 69 дахь тал

<sup>17</sup> Цагдаагийн академи “Гэмт явдалтай тэмцэх асуудал” УБ. 2005 он 38 дахь тал

Уг гэмт хэргийг үйлдэж байгаа нийт хүмүүсийн боловсролгүй, бага, бүрэн бус дунд, тусгай дунд боловсролтой хүмүүс 80 гаруй хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл дээд боловсролтой хүн уг гэмт хэргийг бараг үйлдэхгүй буюу 5 гаруй хувийг эзэлж байна. Монгол ардын сургаалд эрдэмтэй хүн даруй их мөрөн дөлгөөн гэдэг үг бий.

#### **6. Эцэг, эх болон сурган хүмүүлэгч, цагдаагийн байгууллагын хараа хяналтгүй байдал.**

Эцэг эх нь хүүхдээ сургуульдаа явж байгаа эсэх орой үдшийн цагаар хаагуур хэнтэй явж байгаа болон болох болохгүй хүнтэй нийлж байгааг анхаарахгүй байна. Сурган хүмүүжүүлэгч багш нар нь хүүхдүүдийн сурлага болон хичээлийн идэвхийн талаар анхаарал тавихгүй байна. Цагдаагийн байгууллага нь тэнсэн хянан харгалзаж буй хүмүүст бүрэн гүйцэт хараа хяналт тавьж ажиллахгүй байна. Үүнээс болж дахин гэмт хэрэг үйлдэх явдал тасрахгүй гарч байна.

#### **7. Хохирогчийн гэм буруу:**

Дээрмийн гэмт хэргийн гарахад хохирогчийн буруу маш их байна. Хохирогч нь архи болон согтууруулах ундаа ихээр хэрэглэсэн буюу өөрийгөө удирдан жолоодох чадваргүй үедээ гудамж талбайгаар ганцаараа явах, олон хүний газар их хэмжээний мөнгө болон гар утас, үнэт эдлэлүүдийг гаргах, хэтэрхий оройн цагаар ганцаараа харанхуй гудамж талбайгаар явах нь энэ гэмт хэргийн хохирогч болж байна.

Дээрх нөхцөл байдлууд нь дээрмийн гэмт хэрэг гарах гол үндсэн нөхцөлүүд болж байна.

Сүүлийн жилүүдэд манай улсад иргэдийн шилжилт хөдөлгөөн, хүн амын ядуурал, ажилгүйдэл, хот хөдөөгийн ялгаа, амьжиргааны тэгш бус байдал, иргэдийн боловсрол, мэргэжил, нас, хүйс, хохирогчийн гэм буруу зэрэг нь бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг үйлдэхэд ихээр нөлөөлж байна. Хууль тогтоогч Эрүүгийн хуулийн тусгай ангийн 147 дугаар зүйлд бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийг хуульчилсан байна. Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг гэдэг нь шунахай сэдэлттэйгээр бусдын өмчийн эд хөрөнгийг хууль бусаар хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх аргаар авч өөрийн өмчийн нэгэн адил захиран зарцуулах боломж бүрдүүлэхийг хэлнэ. Энэ гэмт хэрэг нь бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр

заналхийлэн авахаас гадна иргэдийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж буй хүнд гэмт хэрэг юм.

## **2.2 Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга зам.**

Эрүүгийн хуулийн 147 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан оногдуулах ял буюу санкц нь зөвхөн хорих ял байна. Шууд таван жилээс дээш найман жил хүртэл гэсэн нь хүнд гэмт хэрэг болно. Уг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял оногдуулахдаа гэмт хэрэг үйлдэх болсон шалтгаан, хохирлын хэр хэмжээ зэргийг харгалзан оногдуулах ялыг багасгах шаардлагатай байна. Учир нь энэхүү гэмт хэргийг субъектууд нь 14 наснаас 25 насны хүмүүс өөрийн хайхрамжгүй байдал, эрх зүйн ухамсар дутуу, ар гэрийн байдал, найз нөхдийн хүрээ, орчин тойрноосоо нөлөөлж дээрмийн гэмт хэргийн учир холбогдлыг ойлгохгүйгээр бага хэмжээний эд зүйл, мөнгө төгрөг анх удаагаа дээрэмдэн амьдралдаа маш том алдаж байна. Ингэж хэрэгт холбогдсон хүмүүст шууд л хамгийн доод хорих ял оногдуулах нь маш их дутагдалтай байна. Мөн Үндсэн хуулинд тунхаглан заасан эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно гэсний хүмүүнлэг шинж нь алдагдаж байна гэж үзэж байна. Энэхүү алдааг нь төр хөнгөрүүлж үзэх нь зүйтэй юм.

Үүнийг эрүүгийн хуулинд нэмэлт өөрчлөлт оруулж өөрчлөх шаардлага зүй ёсоор урган гарч байгааг хөндөх нь зүйтэй байна. 1986 оны эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 39-р зүйлд шүүх гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдийн гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдлыг харгалзан үзэж түүнд эрүүгийн хуулийн тусгай ангид заасан ялын доод хэмжээнээс доогуур ял оногдуулах боломжтой байсан. Харин шинэ эрүүгийн хуулинд энэ заалтыг бүр мөсөн хассан. Миний хувьд энэ заалттай утга агуулга ижил зүйл заалт шинэ эрүүгийн хуульд оруулж өгвөл хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, ардчилсан ёсонд тулгуурлан батласан Үндсэн хуулийн үзэл санаанд нийцэх болов уу гэж үзэж байна.

Эрүүгийн хуулийн 147.1 дэх хэсэгт оногдуулах ялын доод хэмжээг 3-н жил болгон өөрчлөх нь оновчтой болов уу гэж бодож байна. Учир нь хохирогчид учруулсан гэм хороос харгалзан үзэх нь маш чухал байна. Хүний биед ямарч гэмтэл учруулахгүйгээр заналхийлэн 500 төгрөг дээрэмдсний төлөө шууд 5-н жил оногдуулах нь арай хүнд зүйл болж байна. Хэрвээ хорих ялын доод

хугацааг 3-н жил болгон хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар гол өөрчлөгдөх зүйл нь эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 61-р зүйлийг журамлах боломжтой болно. Ингэснээр гэмт буруутай этгээдийг шууд хорих ял эдлүүлэх бус үнэхээр хөнгөрүүлж үзэх боломжтой гэж шүүх үзэвэл тэнсэн хянан харгалзах хугацаа тогтоож өгч тухайн хүнийг нийгмээс тусгаарлахгүйгээр нийгэмд нь засан хүмүүжүүлэх боломжтой гэж үзэж байна.

Криминологийн үүднээс доорх шат дараалсан арга хэмжээг авах нь дээрмийн гэмт хэрэгтэй тэмцэхэд бага ч гэсэн хувь нэмэр оруулна гэж итгэж байна. Үүнд:

Хамгийн эхэнд авах арга хэмжээ бол ерөнхий боловсролын дунд сургуульд эрх зүйн болон гэмт хэргийн талаар тодорхой ойлголттой болгох сургалт нэмэх. Учир нь энэ гэмт хэргийн субъект нь 14 наснаас эхэлдэг. Энэ нь тухайн хүүхдүүдийг гэмт хэрэг гэж юу болох тухайн гэмт хэргийг үйлдснээр ямар хүнд ял авч болох, ийм гэмт хэрэг үйлдэж болохгүй гэдгийг ойлгуулах нь маш чухал байна.

Дээрмийн гэмт хэргийн олон нийтэд хүргэх зорилгоор FM, радио, телевизийн сувгуудаар олонд хамгийн хялбар аргаар ойлгогдохоор нэвтрүүлэг явуулах, эрх зүйн чиглэлээр тогтмол уралдаан тэмцээн явуулах, иргэдэд сэрэмжлүүлэг мэдээлэл явуулах, иргэдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, өөрийн ямар буруутай үйлдлээс болж гэмт хэргийн хохирогч болдог болохыг харуулж ойлгуулах

Гудамж тайлбайг гэрэлтүүлэгтэй болгох. Хүн багаар явдаг, харанхуй гудамж талбайгаар байнгын цагдаагийн эргүүлтэй болгох. Тогтмол маршрут гарган цагдаагийн эргүүлтэй болгох

Архидалтыг багасгах. Манай нийгэмд архидан согтуурах явдал нь хэрээс хэтэрч байна. Дээрмийн гэмт хэрэг үйлдэгсэдийн 70 гаруй хувь нь согтуугаар үйлдсэн байна. Төр архидан согтуурахтай тэмцэх тусгай төсөл боловсруулж нийгмийг архидалтаас цэвэрлэх ёстой гэж бодож байна. Архины үнийг өсгөх, архи үйлдвэрлэдэг үйлдвэрүүдийн тоог цөөрүүлэх, үйлдвэрийн бус аргаар архи үйлдвэрлэгчдийн үйл ажиллагааг таслан зогсоох. Сарын аль нэг 3-5 өдрийг бүх нийтээр архигүй өдөр болгож бүх дэлгүүр, баар, цэнгээний газрыг архиар үйлчлэхгүй болгох.

### **2.3 Гадаадын зарим улс орнуудын эрх зүйн зохицуулалт**

**БНХАУ-ын эрүүгийн хуульд бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийг тусгасан нь:**

**БНХАУ-ын эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлд<sup>18</sup>:**

Хүчирхийлэл, сүрдүүлэг буюу бусад аргаар албаны ба амины эд хөрөнгийг тонон дээрэмдсэн байвал гурван жилээс дээш арван жилээс доош хугацаатай хорихоор шийтгээд зоосоор яллахаар шийтгэнэ.

Доорх байдлуудын аль нэг нь байвал арван жилээс дээш хугацаатай хорих, хугацаагүй хорих буюу алахаар шийтгээд зоосоор яллах буюу эд хөрөнгийг нь хураан авахаар нийлүүлэн шийтгэнэ.

**Нэг.** Гэрт орж тонон дээрэмдсэн байвал

**Хоёр.** Олон нийтийн зам харилцааны бааз хэрэгслийн дээр тонон дээрэмдсэн байвал

**Гурав.** Банк буюу бусад мөнгөн гүйлгээний байгууламжийг тонон дээрэмдсэн байвал

**Дөрөв.** Олон удаа тонон дээрэмдсэн буюу тонон дээрэмдсэн тоо нь лут байвал

**Тав.** Тонон дээрэмдээд хүнийг хүнд шархдуулсан, үхүүлсэн байвал

**Заргаа.** Цэрэг цагдаагийн нэр барьж тонон дээрэмдсэн байвал

**Долоо.** Буу барьж тонон дээрэмдсэн байвал

**Найм.** Цэргийн хэрэгслийн эд бараа буюу аюулаас аврах, гамшигаас тэнхрүүлэх, тусалж тэтгэх эд барааг тонон дээрэмдсэн байвал

Эдгээрийг хүндрүүлэх нөхцөл болгон заасан байна.

Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэгт оногдуулах ял нь

1. Хугацаатай хорих
2. Хугацаагүй хорих
3. Зоосоор яллах
4. алах ял
5. Эд хөрөнгийг хураан авах

Хугацаатай болон хугацаагүй хорих ялыг БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 45, 46, 47 дугаар зүйлүүдэд зааж өгсөн байна.

---

<sup>18</sup> БНХАУ-ын Эрүүгийн хууль. 1997 он



**ОХУ-ын эрүүгийн хуульд бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийг тусгасан нь:**

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 162 дугаар зүйлд бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийг зүйлчлэн тусгасан байна. Үүнд:

1.Дээрэмдэх буюу бусдын эд хөрөнгийг дээрэмдэх зорилгоор хүний амь нас, эрүүл мэндэд аюултайгаар хүч хэрэглэх эсвэл хүч хэрэглэхээр сүрдүүлж довтолсон бол 3-8 жилийн хугацаагаар хорьж эд хөрөнгийг нь хураах эсвэл эд хөрөнгийг нь хураахгүйгээр хорих ял шийтгэнэ.

2.Дээрмийн үйлдлийг:

а/Урьдчилан тохиролцсон бүлэг этгээд үйлдсэн

б/Нэг бус удаа давтсан

в/Орон байр, байшин, агуулахад хууль бусаар нэвтэрч үйлдсэн

г/Буу зэвсэг, зэвсгийн чанартайгаар ашиглагдах эд зүйлс хэрэглэж үйлдсэн бол эд хөрөнгийг хурааж 7-оос 12 жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ.

3.Дээрмийн үйлдлийг:

а/Зохион байгуулалттай бүлэг үйлдсэн

б/Ихээхэн хэмжээний эд хөрөнгийг авах зорилгоор үйлдсэн

в/Хохирогчийн биед хүнд гэмтэл учруулсан

г/Урьд нь 2 түүнээс дээш удаа хулгай, сүрдүүлгийн хэргээр ял шийтгүүлж байсан этгээд үйлдсэн бол эд хөрөнгийг хурааж 8-аас 15 жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ.<sup>19</sup>

Үүнээс харахад оногдуулах ялын доод хэмжээ нь манай улсын хувьд 5-8 жилээс эхлэж байна. БНХАУ-ын хувьд 3-8 жил, ОХУ-ын хувьд 3-8 жил байна. БНХАУ-ын хуульд гэрт орж тонон дээрэмдсэн, олон нийтийн зам харилцааны бааз хэрэгслийн дээр тонон дээрэмдсэн, банк буюу бусад мөнгөн гүйлгээний байгууламжийг тонон дээрэмдсэн гэж онцлог объектуудыг зааж өгсөн байна. ОХУ-ын хуульд орон байр, байшин, агуулахад хууль бусаар нэвтэрч үйлдсэн гэж заасан байна. Бусад хүндрүүлэх нөхцөл байдлуудын хувьд манай орны хуультай адил төсөөтэй байна.

---

<sup>19</sup> ОХУ-ын “Эрүүгийн хууль” 162-р зүйл 2002 он

## Дүгнэлт

.Монгол Улсын Эрүүгийн хууль энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд хүн, төр, нийгэмд аюултай ямар үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, түүнийг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээг тогтооно гэсэн нарийн зохицуулалттай юм.

Дээрхээс үзвэл нийтийн болон хувийн өмчийн хамгаалалтыг шинэ Үндсэн хуулийн үзэл санаанд тулгуурлан 2002 онд шинэ Эрүүгийн хуулийг батлан дагаж мөрдөж байгаа нь дэвшилтэд талуудын нэг юм.

Сүүлийн жилүүдэд манай улсад иргэдийн шилжилт хөдөлгөөн, хүн амын ядуурал, ажилгүйдэл, хот хөдөөгийн ялгаа, амьжиргааны тэгш бус байдал, иргэдийн боловсрол, мэргэжил, нас, хүйс, хохирогчийн гэм буруу зэрэг нь бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг үйлдэхэд ихээр нөлөөлж байна. Хууль тогтоогч Эрүүгийн хуулийн тусгай ангийн 147 дугаар зүйлд бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийг хуульчилсан байна. Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг гэдэг нь шунахай сэдэлттэйгээр бусдын өмчийн эд хөрөнгийг хууль бусаар хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх аргаар авч өөрийн өмчийн нэгэн адил захиран зарцуулах боломж бүрдүүлэхийг хэлнэ. Энэ гэмт хэрэг нь бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэн авахаас гадна иргэдийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж буй хүнд гэмт хэрэг юм.

Монгол улсад гарч байгаа бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн объект, халдлагыг зүйл, үйлдлийн арга, шалтгаан, түүнчлэн энэ гэмт хэргийг үйдэж байгаа хүмүүсийн хувийн байдал, үйлдлийн арга, гэмт хэрэг үйлдэж байгаа газар зэрэг олон онцлог асуудал анхаарал татаж байна. Иймээс дараах санал дүгнэлтийг гаргаж байна.. Үүнд:

1. Эрүүгийн хуулийн 147 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан оногдуулах ял буюу санкц нь зөвхөн хорих ял байна. Шууд таван жилээс дээш найман жил хүртэл гэсэн нь хүнд гэмт хэрэг болно. Уг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял оногдуулахдаа гэмт хэрэг үйлдэх болсон шалтгаан, хохирлын хэр хэмжээ зэргийг харгалзан оногдуулах ялыг багасгах шаардлагатай байна. Учир нь энэхүү гэмт хэргийг субъектууд нь 14 наснаас 25 насны хүмүүс өөрийн

хайхрамжгүй байдал, эрх зүйн ухамсар дутуу, ар гэрийн байдал, найз нөхдийн хүрээ, орчин тойрноосоо нөлөөлж дээрмийн гэмт хэргийн учир холбогдлыг ойлгохгүйгээр бага хэмжээний эд зүйл, мөнгө төгрөг анх удаагаа дээрэмдэн амьдралдаа маш том алдаж байна. Ингэж хэрэгт холбогдсон хүмүүст шууд л хамгийн доод хорих ял оногдуулах нь маш их дутагдалтай байна. Мөн Үндсэн хуулинд тунхаглан заасан эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цргцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно гэсний хүмүүнлэг шинж нь алдагдаж байгна гэж үзэж байна. Энэхүү алдааг нь төр хөнгөрүүлж үзэх нь зүйтэй юм.

Үүнийг эрүүгийн хуулинд нэмэлт өөрчлөлт оруулж өөрчлөх шаардлага зүй ёсоор урган гарч байгааг хөндөх нь зүйтэй байна. 1986 оны эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 39-р зүйлд шүүх гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдийн гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдлыг харгалзан үзэж түүнд эрүүгийн хуулийн тусгай ангид заасан ялын доод хэмжээнээс доогуур ял оногдуулах боломжтой байсан. Харин шинэ эрүүгийн хуулинд энэ заалтыг бүр мөсөн хассан. Миний хувьд энэ заалттай утга агуулга ижил зүйл заалт шинэ эрүүгийн хуульд оруулж өгвөл хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, ардчилсан ёсонд тулгуурлан баталсан Үндсэн хуулийн үзэл санаанд нийцэх болов уу гэж үзэж байна.

**2. Эрүүгийн хуулийн 147.1 дэх хэсэгт оногдуулах ялын доод хэмжээг 3-н жил болгон өөрчлөх нь оновчтой болов уу гэж бодож байна.** Учир нь хохирогчид учруулсан гэм хороос харгалзан үзэх нь маш чухал байна. Хүний биед ямарч гэмтэл учруулахгүйгээр заналхийлэн 500 төгрөг дээрэмдсний төлөө шууд 5-н жил оногдуулах нь ариа хүнд зүйл болж байна. Хэрвээ хорих ялын доод хугацааг 3-н жил болгон хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар гол өөрчлөгдөх зүйл нь эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 61-р зүйлийг журамлах боломжтой болно. Ингэснээр гэмт буруутай этгээдийг шууд хорих ял эдлүүлэх бус үнэхээр хөнгөрүүлж үзэх боломжтой гэж шүүх үзэвэл тэнсэн хянан харгалзах хугацаа тогтоож өгч тухайн хүнийг нийгмээс тусгайрлахгүйгээр нийгэмд нь засан хүмүүжүүлэх боломжтой гэж үзэж байна.

Криминологийн үүднээс доорх шат дараалсан арга хэмжээг авах нь дээрмийн гэмт хэрэгтэй тэмцэхэд бага ч гэсэн хувь нэмэр оруулна гэж итгэж байна. Үүнд:

**1.**Хамгийн эхэнд авах арга хэмжээ бол ерөнхий боловсролын дунд сургуульд эрх зүйн болон гэмт хэргийн талаар тодорхой ойлголттой болгох сургалт нэмэх. Учир нь энэ гэмт хэргийн субъект нь 14 наснаас эхэлдэг. Энэ нь тухайн хүүхдүүдийг гэмт хэрэг гэж юу болох тухайн гэмт хэргийг үйлдснээр ямар хүнд ял авч болох, ийм гэмт хэрэг үйлдэж болохгүй гэдгийг ойлгуулах нь маш чухал байна.

**2.**Дээрмийн гэмт хэргийн олон нийтэд хүргэх зорилгоор FM, радио, телевизийн сувгуудаар олонд хамгийн хялбар аргаар ойлгогдохоор нэвтрүүлэг явуулах, эрх зүйн чиглэлээр тогтмол уралдаан тэмцээн явуулах, иргэдэд сэрэмжлүүлэг мэдээлэл явуулах, иргэдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, өөрийн ямар буруутай үйлдлээс болж гэмт хэргийн хохирогч болдог болохыг харуулж ойлгуулах

**3.**Гудамж тайлбайг гэрэлтүүлэгтэй болгох. Хүн багаар явдаг, харанхуй гудамж талбайгаар байнгын цагдаагийн эргүүлтэй болгох. Тогтмол маршрут гарган цагдаагийн эргүүлтэй болгох

**4.**Архидалтыг багасгах. Манай нийгэмд архидан согтуурах явдал нь хэрээс хэтэрч байна. Дээрмийн гэмт хэрэг үйлдэгсдийн 70 гаруй хувь нь согтуугаар үйлдсэн байна. Төр архидан согтуурахтай тэмцэх тусгай төсөл боловсруулж нийгмийг архидалтаас цэвэрлэх ёстой гэж бодож байна. Архины үнийг өсгөх, архи үйлдвэрлэдэг үйлдвэрүүдийн тоог цөөрүүлэх, үйлдвэрийн бус аргаар архи үйлдвэрлэгчдийн үйл ажиллагааг таслан зогсоох. Сарын аль нэг 3-5 өдрийг бүх нийтээр архигүй өдөр болгож бүх дэлгүүр, баар, цэнгээний газрыг архиар үйлчлүүлэхгүй болгох.

**5.** Хараа хяналтгүй, тэнүүчлэн амьдарч буй хүмүүсийг төрөөс болон бусад Олон нийтийн байгууллага, Цагдаагийн байгууллагаас судалгааг явуулж, тэдэнд хараа хяналт тавих, тусламж үзүүлэх хөтөлбөр боловсруулан ажиллах, хүүхдүүдийг тэнүүчлэлийн замаас салгах нь маш чухал байна.

Хэрвээ ингэж чадвал ганц дээрмийн гэмт хэрэг бус бүх төрлийн гэмт хэргийн тоо буурна гэдэгт бат итгэлтэй байна.

## **Ном зүй**

### **1.Хууль тогтоомж**

- 1.Монгол Улсын Үндсэн хууль. УБ. 1992 он
2. Монгол улсын Эрүүгийн хууль. УБ. 1942, 1961, 1986.
- 3.БНМАУ-ын Шүүх цаазын бичиг. УБ. 1926, 1929
- 4.БНМАУ-ын хууль тогтоомжийн эмхтгэл. УБ. 1968 он
- 5.Монгол улсын Эрүүгийн хууль. УБ. 2002 он
- 6.Зарилгаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг. УБ. 1995 он
- 7.Монгол Улсын Дээд Шүүхийн тогтоолын эмхтгэл. УБ. 2004 он
- 8.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль
- 9.БНХАУ-ын Эрүүгийн хууль 1997 он
- 10.Оросын Холбооны Улсын эрүүгийн хууль 2002 он

### **2.Монгол хэл дээрх ном, сурах бичгүүд**

1. Ж.Авхиа “Гэмт явдал түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудал  
УБ. 1997 он
2. Д.Адъяабазар.Монгол Улсын 1921 оноос хойшхи эрүүгийн хууль  
тогтоомжийн хөгжилт. УБ.1998 он
3. Э.Авирмэд, Д.Дашцэдэн, Г.Совд Монгол Эрүүгийн эрх зүй УБ 1999 он
4. Н.Баатаржав, Б.Жаргал “Криминологи” УБ. 2001 он
5. Б.Батзориг, Э.Зууннасан БНХАУ-ын Эрүүгийн ба эрүүгийн заргын  
хууль.УБ.2006 он
6. Б.Ганболд “Монгол Улсын Эрүүгийн эрх зүй дэх гэмт хэрэг  
зүйлчлэлийн онол 2001 он
7. Ц.Дамдинсүрэн “Монголын нууц товчоо” УБ. 1975 он
8. Жалан-Аажав “Халх журам”. УБ. 1995 он
9. Н.Жанцан “Криминологи” УБ. 2004 он

10. Ц.Цэлмэг “Криминологи” УБ. 2005 он
11. С.Нарангэрэл “Монгол улсын эрүүгийн эрх зүй”-н тусгай анги УБ.1999 он
12. Н.Ням-Осор “Чэнгис хааны Их засаг хуулийн тайлбар” УБ. 2001 он
13. Г.Совд “Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар” УБ. 2002 он

### **3.Бусад ашигласан материалууд**

1. Монгол Улсын Засгийн Газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр УБ 2002 он
2. Төрийн мэдээлэл сэтгүүл УБ 2000-2005 оны дугаарууд
3. Монгол Улсын Дээд шүүхийн тогтоолын эмхтгэл 2004-2006 он
4. Цагдаагийн академи “Гэмт явдалтай тэмцэх асуудал” УБ. 2005 он
5. [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn).